

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-34
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	35-111
<hr/>	
1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг томилох, чөлөөлөх тухай асуудал	37-52
2.Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай асуудал	52-58
3.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	58-59
4. Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нарын 38 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	59-61
5.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 4 гишүүн 2024.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	61-63
6.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	63
7. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	63-64
8.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	64-65
9.Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	65-67
10. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	67-68
11.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн	68-69

хэлэлцүүлэг/ 12.Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 13.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/ 14.“Шүүгчийн орон тоог батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл 15.“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл 16.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл 17.“Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл 18.“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ - Өмнөх асуудлуудын санал хураалт 19.Биеийн тамир, спортын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар - Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тухай болон хамат өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалт 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ 20.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ 21.Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	69-72 72-73 73-74 74 74-75 75-76 76-85 85-89 89-91 91-103 103-105 105-111
--	--

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 30-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 02 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Г.Дамдинням;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Д.Батлут, Ж.Батсуурь, Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, С.Бямбацогт, Н.Ганибал, Х.Ганхуяг, Т.Доржханд, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан, Н.Наранбаатар, М.Оюунчимэг, Л.Оюун-Эрдэнэ, Д.Өнөрболор, Д.Сарангэрэл, Ц.Сэргэлэн, Ц.Туваан, Ч.Ундрал, Ж.Чинбүрэн, Л.Энх-Амгалан, Б.Энхбаяр, Т.Энхтүвшин, Ж.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Г.Амартүвшин, С.Батболд, Ш.Раднаасэд;

Тасалсан: А.Адъяасүрэн, С.Ганбаатар;

Хоцорсон: Д.Ганбат- 1 цаг 37 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг томилох, чөлөөлөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх А.Үйлстөгөлдөр, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэр дэвшигч Ц.Цолмон, Р.Батрагчаа, Б.Болдбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Нэр дэвшүүлсэн Улсын Их Хурлын саналыг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга А.Үйлстөгөлдөр, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нар танилцуулав.

Нэр дэвшигчид болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, С.Бямбацогт, Т.Доржханд, О.Цогтгэрэл, М.Оюунчимэг, Ц.Даваасүрэн, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад нэр дэвшигч Ц.Цолмон, Р.Батрагчаа, Б.Болдбаатар нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.2-т заасны дагуу нууц санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Цэдэвийн Цолмонг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 13
Бүгд: 41
68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Бямбадоржийн Болдбаатарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 14
Бүгд: 41
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Рагчаагийн Батрагчааг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 14
Бүгд: 41
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын тогтоолыг танилцуулж, дараах Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.“Монгол Улсын Их Хурлын санал болгосноор Цэдэвийн Цолмонг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон Шилаагардийн Солонгыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:07/

2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор “Бямбадоржийн Болдбаатарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон Батсүхийн Буяндэлгэрийг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:07/

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор “Рагчаагийн Батрагчааг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон Гомбожавын Туулхүүг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн

найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:08/

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

Уг асуудлыг 12 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, нэр дэвшигч О.Машбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар, Д.Цогтбаатар, М.Оюунчимэг нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, нэр дэвшигч О.Машбат нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 105 дугаар зүйлийн 105.3-т заасны дагуу нууц санал хураалт явуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчоор Очирсүхийн Машбатыг томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны санал хураалтын дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид албан бичгээр хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 12 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын сонгуультай холбогдуулан 2024 оны хаврын ээлжит чуулган ирэх 7 хоногт завсарлах тул Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу энэ хүртэл хугацаанд Засгийн газрын нэн яаралтай горимоор өргөн мэдүүлснээс бусад аливаа хууль, тогтоолын төслийг хүлээж авахгүй болсныг мэдэгдэв./12:35/

Дөрөв.Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нарын 38 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн газрын Мал аж ахуйн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Мөнхнасан, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, “Бодлого судлалын төв”-ийн тэргүүн А.Энх-Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“52.2.Бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр гэсэн ерөнхий хуваарийн дагуу ашиглана. Отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр, уст цэг, хужир мараа бүхий бэлчээрийг нийтээр ашиглана. Бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээрийн даацыг харгалзан, багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээний дагуу ашиглуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 12 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 4 гишүүн “Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо./12:41/

Тав.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 4 гишүүн 2024.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, мөн шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Н.Мөнгөнцэцэг, мөн зөвлөлийн Хуулийн хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Ж.Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 12 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 12 цаг 48 минутаас хуралдааныг даргалав.

Зургаа.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Р.Батрагчаа, Төрийн ёслолын газрын дарга Э.Одмөнх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 12 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 12 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 13 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Арав.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Статистик, дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн С.Батхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 03 минут үргэлжилж, 13 цаг 05 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 22 минутад эхлэв.

Арван нэг.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Арван хоёр.Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч А.Энх-Эрдэнэ, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Б.Алтантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 14 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Арван гурав.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 14 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Арван дөрөв. “Шүүгчийн орон тоог батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 14 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Арван тав. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 14 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Арван зургаа. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 14 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Арван долоо. “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 14 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Арван найм. “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, мөн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газрын дарга Э.Батболд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хот, хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн үндэсний хорооны ахлах мэргэжилтэн М.Буяндэлгэр, Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн асан, Техникийн ухааны доктор Н.Тогтох, Монгол Улсын Их сургуулийн профессор, Шинжлэх ухааны доктор Р.Ринчинбазар, “Эрчим хүчний хөгжлийн төлөө Монголын нийгэмлэг”-ийн захирал Д.Пүрэвбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр нар хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	16
Татгалзсан:	23
Бүгд:	39

41.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	18
Татгалзсан:	20
Бүгд:	38

47.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	19
Татгалзсан:	20
Бүгд:	39

48.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	17

Бүгд: 38
55.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

1.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“52.2.Бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр гэсэн ерөнхий хуваарийн дагуу ашиглана. Отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр, уст цэг, хужир мараа бүхий бэлчээрийг нийтээр ашиглана. Бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээрийн даацыг харгалзан, багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээний дагуу ашиглуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 20
Бүгд: 38
47.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17

Бүгд: 38
55.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Д.Цогтбаатар нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Д.Цогтбаатар нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв./15:39/

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн "... дүгээр сарын ...-ний" гэснийг "06 дугаар сарын 15-ны" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв. /15:42/

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"6.4.Энэ хуулийн 6.1-д заасан хөнөөлт организмтай тэмцэх, ариутгах, халдваргүйжүүлэх, устгах арга хэмжээний зааврыг ургамал хамгааллын асуудал хариуцсан

төрийн захиргааны байгууллага батлан энэ хуулийн 26.1-д заасан мэдээллийн санд байршуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв./15:44/

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийн талаар санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мөнгөн зээлийн ажиллагааг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль тогтоомжийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв./15:46/

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан/-ийн талаар санал хураалтыг явуулав.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооноос “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр батлах гэсэн горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 17

Бүгд: 38

55.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан/-ийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв./15:47/

“Шүүгчийн орон тоо батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: “Шүүгчийн орон тоог батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 17

Бүгд: 38

55.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 17

Бүгд: 38

55.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 18

Бүгд: 38

52.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

“Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Биеийн тамир, спортын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцүүлэх талаар горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39

53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул Биеийн тамир, спортын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэхээр тогтов.

Арван ес.Биеийн тамир, спортын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Биеийн тамир, спортын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн “13.1.11” дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 13.1.6 дахь заалтын “санхүүгийн дэмжлэгийг төсөвт тусган санхүүжүүлэх” гэснийг “олгосон санхүүжилтийг зарцуулах” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.1.7, 13.1.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.7.орон нутгийн төсвөөс өсвөр үе, оюутны шигшээ багт санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

13.1.10.нутаг дэвсгэрийн нэгжийн онцлогийг харгалзан спортын төрлийг хөгжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19

Бүгд: 39

51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Биеийн тамир, спортын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Г.Амартүвшин, Л.Мөнхбаатар, М.Оюунчимэг, Б.Энх-Амгалан /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт, 4 дэх заалтын 46.10 дахь хэсэг, мөн зүйлийн 6 дахь заалтыг тус тус хасаж, 2 дахь заалтын 32.2.4, 32.2.5 дахь заалтыг өөрчлөн найруулж 32.8 дахь хэсэг болгож, 4 дэх заалтын 46.9 дэх хэсэг, 5 дахь заалтын 71.1.31 дэх заалтыг тайлбар болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.8.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 32.2.1, 32.2.2-т зааснаас бусад тохиолдолд шүүгчийн сул орон тоо гарсан бол энэ хуулийн 34.9-д заасан нэр дэвшигчийг сонгон шалгаруулалтад тэнцсэн эрэмбийн дарааллыг баримтлан энэ хуулийн 35.1-д заасны дагуу өргөн мэдүүлнэ.”

“46.9.Шүүгч зэрэг дэвтэй байх бөгөөд шүүгчид зэрэг дэв олгох журмыг Улсын Их Хурал батална.”

“Тайлбар:-Энэ хуульд заасан “Шүүхийн цахим платформ” гэж шүүхийн үйл ажиллагаанд мэдээлэл цуглуулах, боловсруулах, хайх, илгээх, хүлээн авах, ашиглах болон түүний аюулгүй байдлыг хангах зорилго бүхий үндсэн программ хангамж, техник хангамж,

мэдээллийн сан, бусад бүрэлдэхүүн системийг хэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19

Бүгд: 39

51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “давж заалдах, анхан шатны” гэснийг “Ерөнхий зөвлөлийн ажлын алба,” гэж өөрчилж, “72 дугаар зүйлийн 72.1.5 дахь заалт “шүүгчид” гэсний дараа “болон шүүхийн захиргааны ажилтанд” гэж,” гэснийг “72 дугаар зүйлийн 72.1.5 дахь заалтын “шүүгчид” гэснийг “шүүгч болон шүүхийн захиргааны ажилтанд” гэж,” гэж, “85 дугаар зүйлийн 85.6 дахь хэсгийн “орон тоог” гэсний дараа “, албан тушаалын цалингийн хэмжээг” гэж,” гэснийг “85 дугаар зүйлийн 85.6 дахь хэсгийн “орон тоог” гэснийг “орон тоо, албан тушаалын цалингийн хэмжээг” гэж,” гэж тус тус өөрчилж 4 дүгээр зүйлд шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19

Бүгд: 39

51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 12.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 12.1, 12.2 дахь хэсэг болгох:

“12.1.Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нээлттэй эсхүл хаалттай явуулах эсэх асуудлыг энэ хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ.

12.2.Шүүхийн үйл ажиллагааг дараах байдлаар олон нийтэд нээлттэй, ил тод явуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 20

Бүгд: 39

48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 17

Бүгд: 39

56.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19

Бүгд: 39

51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 12.1.2 дахь заалт, 12.2 дахь хэсэг, 12.10, 12.13, 12.14 дэх хэсгийг тус тус өөрчлөн найруулж, 12.11 дэх хэсгийг хасах.

“12.1.2.шүүх хуралдааныг нээлттэй явуулах, шүүхийн цахим хуудас, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсхүл олон нийтийн цахим сүлжээгээр энэ хууль болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайлсан хуульд заасны дагуу шууд дамжуулах, эсхүл олон нийтэд дуу-дүрсний бичлэгээр хүргэх;”

“12.2.Нээлттэй явуулсан шүүх хуралдааны шийдвэрийг хэргийн оролцогч нарт гардуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүхийн бусад шийдвэр, шүүгчийн захирамж, шүүх хуралдааны тэмдэглэлийг албажиж гарснаас нь хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 12.1.3-т заасан цахим мэдээллийн санд ил тод, нээлттэй байршуулна.”

“12.10.Төрийн нууцад хамаарах хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд хаалттай явуулахаар тусгайлан зааснаас бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаан нээлттэй байна.”

“12.13.Энэ хуулийн 12.10-т заасан шийдвэрт гомдол, хүсэлт гаргах, гомдол, хүсэлтийг шийдвэрлэх журмыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайлсан хуулиар зохицуулна.

12.14.Шүүх энэ хуулийн 12.1.1, 12.1.2-т заасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэр, энэ хуулийн 12.1.3-т заасан цахим мэдээллийн санд төрөлжүүлэн архив, албан хэрэг хадгалалтын хугацааны турш, шүүх хуралдааны бичлэгийг Ерөнхий зөвлөлийн баталсан журамд заасан хугацаанд хадгална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 20

Бүгд: 40

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18

Бүгд: 40
55.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 12.5 дахь хэсгийн “заавал байршуулна” гэснийг “байршуулахтай холбоотой журмыг Ерөнхий зөвлөл батална” гэж, 12.1.1 дэх заалтын “хуульд заасны дагуу сонирхогч этгээд биечлэн болон цахимаар” гэснийг “хууль болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайлсан хуульд заасны дагуу сонирхогч этгээд” гэж, 12.8 дахь хэсгийн “хэсэгчлэн хаахаас” гэснийг “зарим хэсгийг хаахаас” гэж тус тус өөрчилж, 12.3 дахь хэсгийн “биечлэн, эсхүл цахимаар” гэснийг, 12.16, 12.17 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 24.5 дахь хэсгийн “заавал” гэснийг, мөн зүйлийн 3 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “48 дугаар” гэсний өмнө “32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалтын “32.2.2-т” гэснийг “32.2.2, 32.8-д” гэж,” гэж нэмж, “19.2.3” гэсний дараа “дахь заалтын “Хүрээлэнд” гэснийг “Шүүхийн академид” гэж” гэж, мөн зүйлийн “Хүрээлэн” гэснийг “Шүүхийн академи” гэснийг “Хүрээлэнгийн” гэснийг Шүүхийн академийн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал:

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 24
Бүгд: 40
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг үйлдэх, шийдвэр гаргах,” гэж нэмж, мөн зүйлийн 2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 24
Бүгд: 40
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 20

Бүгд: 40
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 20
Бүгд: 39
48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 11.11 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байж болно. Цаасан баримтыг шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын ажилтан хөрвүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “цахим хаягаар” гэснийг “цахимаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3.2 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Төрийн нууцад хамаарах хэрэг, энэ хуульд тусгайлан зааснаас бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

2.Хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын ялагч, хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нээлттэй, эсхүл хаалттай явуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 34.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2 дахь хэсгийн “хаалттай” гэснийг “нээлттэй, эсхүл хаалттай” гэж өөрчлөх:

“1.Төрийн нууцад хамаарах хэрэг, энэ хуульд тусгайлан зааснаас бусад шүүх хуралдааныг нээлттэй явуулна.”

“2.1.хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын ялагч, хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс хүсэлт гаргасан бол.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 2 дахь заалтын 34.4 дүгээр зүйлд шилжүүлж 6 дахь хэсэг болгох:

“6.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасан албаны нууцыг задруулахгүй байх баталгааны зохицуулалт шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулахад хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 7.5, 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7.5, 7.6, 7.7 дахь хэсэг болгож, мөн зүйлийн 2, 5, 6, 7, 8 дахь заалт, 4 дэх заалтын 75⁶ дугаар зүйлийн 75⁶.4.3, 75⁶.4.4 дэх заалтыг тус тус хасах:

“7.5.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байж болох бөгөөд шүүхийн цахим платформын шаардлагад нийцсэн байна. Цаасан баримт бичгийг шүүхийн захиргааны эрх бүхий ажилтан хөрвүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулна.

7.6.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шүүхийн мэдэгдэх хуудас, тэмдэглэл, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шийдвэр зэрэг баримт бичгийг цахимаар хөтлөх, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, хуульд заасан бусад этгээдэд танилцуулах, гардуулах, эрх, үүрэг тайлбарлах, нэхэмжлэл, хариу тайлбар, сөрөг нэхэмжлэл, бие даасан шаардлага, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлт, нотлох баримтыг танилцуулах ажиллагааг шүүхийн цахим платформыг ашиглан цахимаар явуулж болно.

7.7.Хэргийн оролцогчтой цахимаар харилцахад төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, мэдэгдэл хүргэх систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, мэдэгдэл хүргэх системд иргэний, эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар, өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шууданг ашиглана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 20
Бүгд: 40
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Шүүх хуралдаан, хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааг нээлттэй явуулах

8.1.Төрийн нууцад хамаарах хэрэг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

8.2.Хэргийг шийдвэрлэж буй шүүгч, шүүх бүрэлдэхүүн дараах тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулахаар, эсхүл хэрэгт авагдсан нотлох баримтыг олон нийтэд мэдээлэхгүй талаар шийдвэр гаргаж болно.

8.2.1.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд насанд хүрээгүй гэрч, хохирогч оролцож байгаа бол шүүх өөрийн санаачилгаар;

8.2.2.нээлттэй ил тод байх нь хүний үндсэн эрхэд ноцтой хохирол учруулж болзошгүй талаар хэргийн оролцогчийн гаргасан хүсэлт тайлбарыг шүүх үндэслэлтэй гэж үзсэн;

8.2.3.цаашид үргэлжлэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ноцтой хохирол учруулах үндэслэлтэй гэж үзвэл.

8.3.Энэ хуулийн 8.2-т заасан шийдвэр нь шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол хэлбэртэй байна. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл хэргийн оролцогч гомдол, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, сонирхогч бусад этгээд хүсэлт гаргах эрхтэй.

8.4.Энэ хуулийн 8.2-т заасны дагуу шийдвэрлэсэн хэргийн үйл баримт, нотлох баримтын талаар олж мэдсэн хэргийн оролцогч, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, бусад этгээд уг үйл баримт, нотлох баримтын талаар олон нийтэд түгээх, хэвлэн нийтлэх, аливаа байдлаар нийтэд дэлгэхийг хориглоно.”

8.5.Иргэний эрх зүйн чадамжгүй, согтуурсан, мансуурсан, 18 насанд хүрээгүй хэргийн оролцогч биш этгээдээс бусад хүн нээлттэй шүүх хуралдааныг хөндлөнгөөс ажиглах зорилгоор шүүх хуралдааны танхимд чөлөөтэй нэвтрэн орох эрхтэй. Шүүх хуралдаан хөндлөнгөөс ажиглагч этгээд нь шүүх хуралдаанд оролцох дэг, журмыг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19

Бүгд: 39

51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “нэрийг” гэснийг “гарчгийн” гэж, “өөрчлөн найруулсугай” гэснийг “өөрчилсүгэй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19

Бүгд: 39

51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 17

Бүгд: 39

56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг төсөлд хэвээр үлдээх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19

Бүгд: 39

51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 8.5 дахь хэсгийн “ажиллагаанд хөтлөгдөх” гэснийг “ажиллагааны” гэж, “байна” гэснийг “байж болно” гэж өөрчилж, мөн зүйлийн 2 дахь заалтын 10¹ дүгээр зүйлийн 10¹.1-10¹.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 10¹.1, 10¹.2 дахь хэсэг болгох:

“10¹.1.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхийн цахим платформыг ашиглан явуулж болох бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь шүүхийн цахим платформын шаардлагад нийцсэн байна.

10¹.2.Цаасан баримтыг шүүхийн захиргааны эрх бүхий ажилтан хөрвүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 17

Бүгд: 39

56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 10¹ дүгээр зүйлийн 10¹.6 дахь хэсгийн “үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, тухайн этгээдийг таньж, баталгаажуулах боломжтой бусад цахим систем” гэснийг “эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн үүсгэсэн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар,” гэж өөрчилж, 10¹.5, 10¹.7, 10¹.8 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19

Бүгд: 39

51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 16 цаг 50 минутаас хуралдааныг даргалав.

Г.Занданшатар: 3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 32.9, 32.10, 32.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 32.9 дэх хэсэг болгож, мөн зүйлийн 4, 5, 6 дахь заалтыг тус тус хасах:

“32.9.Шүүх цахим баримт бичгийг эргэлзээтэй гэж үзвэл энэ хуульд заасны дагуу шаардлагатай ажиллагаа хийнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18

Бүгд: 40

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн “гардуулна.” гэсний дараа “Цахим нэхэмжлэлийг хариуцагчид энэ хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1-д заасны дагуу гардуулна.” гэж, 57.2 дахь хэсгийн “ирүүлнэ.” гэсний

дараа “Цахимаар гаргасан хариу тайлбарыг тоон гарын үсгээр баталгаажуулна.” гэж, 71 дүгээр зүйлийн 71.2 дахь хэсгийн “үүрэгтэй” гэсний дараа “Цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд шүүхээс цахим системээр мэдэгдэл илгээснээр товыг мэдэгдсэнд тооцно” гэж,” гэснийг, “108.4 дэх хэсгийн “гардан авна.” гэсний дараа “Цахимаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг энэ хуулийн 10¹ дугаар зүйлийн 10¹.1-д заасны дагуу гардуулна” гэж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18

Бүгд: 40

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1/“9 дүгээр зүйл:

“9 дүгээр зүйл.Шүүх хуралдаан, хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааг нээлттэй явуулах

9.1.Төрийн нууцад хамаарах хэрэг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

9.2.Хэргийг шийдвэрлэж буй шүүгч, шүүх бүрэлдэхүүн дараах тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулахаар, эсхүл хэрэгт авагдсан нотлох баримтыг олон нийтэд мэдээлэхгүй талаар шийдвэр гаргаж болно:

9.2.1.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд насанд хүрээгүй гэрч, хохирогч оролцож байгаа бол шүүх өөрийн санаачилгаар;

9.2.2.нээлттэй ил тод байх нь хүний үндсэн эрхэд ноцтой хохирол учруулж болзошгүй талаар хэргийн оролцогчийн гаргасан хүсэлт тайлбарыг шүүх үндэслэлтэй гэж үзсэн;

9.2.3.цаашид үргэлжлэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ноцтой хохирол учруулах үндэслэлтэй гэж үзвэл.

9.3.Энэ хуулийн 9.2-т заасан шийдвэр нь шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол хэлбэртэй байна. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл хэргийн оролцогч гомдол, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, сонирхогч бусад этгээд хүсэлт гаргах эрхтэй.

9.4.Энэ хуулийн 9.2-т заасны дагуу шийдвэрлэсэн хэргийн үйл баримт, нотлох баримтын талаар олж мэдсэн хэргийн оролцогч, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, бусад этгээд уг үйл баримт, нотлох баримтын талаар олон нийтэд түгээх, хэвлэн нийтлэх, аливаа байдлаар нийтэд дэлгэхийг хориглоно.

9.5.Иргэний эрх зүйн чадамжгүй, согтуурсан, мансуурсан, 18 насанд хүрээгүй хэргийн оролцогч биш этгээдээс бусад хүн нээлттэй шүүх хуралдааныг хөндлөнгөөс ажиглах зорилгоор шүүх хуралдааны танхимд чөлөөтэй нэвтрэн орох эрхтэй. Шүүх хуралдаан хөндлөнгөөс ажиглагч этгээд нь шүүх хуралдаанд оролцох дэг, журмыг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “цахим шуудан” гэснийг “энэ хуулийн 59.12-т заасны дагуу гэж,” гэснийг хасаж, “шаардлагатай тохиолдолд” гэснийг “эсхүл” гэж тус тус” гэснийг “хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд” гэснийг “хүргүүлэх, эсхүл” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 20
Бүгд: 40
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ш.Адъяа нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ш.Адъяа нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 39
57.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “30 дугаар зүйлийн 30.4.4 дэх заалтын “байгууллага,” гэснийг,” гэснийг, “75 дугаар зүйлийн 75.2.6,” гэснийг тус тус хасаж, “50.4-т” гэсний өмнө “энэ хуулийн” гэж нэмж, мөн зүйлийн “, 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсгийн “байгууллагын нууц,” гэснийг 6 дугаар зүйлийн “хэсгийг” гэснийг “хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсгийг” гэж өөрчилж мөн зүйлд шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 15.36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нэг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “ажиллагаанд хөтлөх” гэснийг “ажиллагааны” гэж, “байна” гэснийг “байж болно” гэж өөрчилж, 2 дахь заалтын 2.1 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 3 дахь хэсэг болгож, мөн зүйлийн 7 дахь хэсгийн “эрүүгийн” гэснийг “зөрчлийн” гэж, “хүргүүлнэ” гэснийг “хүргүүлж болно” гэж өөрчлөх:

“3.Хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхийн нэгдсэн цахим платформыг ашиглан явуулж болох бөгөөд хэргийн баримт бичиг, материал нь шүүхийн нэгдсэн цахим платформын шаардлагад нийцсэн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18

Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хорь.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Баярмаа, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай болон Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулиудын санал хураалтыг явуулах боломжгүй болсон тул хэлэлцэх асуудлыг хойшлуулж, Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх талаар горимын санал гаргав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу дээрх хуулийн төслүүдийн санал хураалтыг хойшлуулав. /17:22/

Хорин нэг.Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Баярбат, мөн яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Батболд, мөн газрын ахлах шинжээч Г.Чинсанаа, ахлах мэргэжилтэн Б.Одбаатар, Хуулийн хэлтсийн ахлах шинжээч Г.Гантөр, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, шинжээч Б.Амарбаясгалан,

мөн газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, “Төрийн орон сууцны корпораци” Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн захирал Б.Эрдэнэбулган, мөн компанийн Хөрөнгийн ашиглалт, зохицуулалтын газрын дарга Ч.Маргад-Эрдэнэ, “Нийслэлийн Орон сууцны корпораци” Хувьцаат компанийн Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Н.Түвшинтөгс, мөн компанийн Захиргааны хэлтсийн хуульч П.Гэрэлт-Очир, Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын Санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал П.Мөнхбаяр, “Алекс” Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн захирал, хуульч Б.Лхамсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ж.Түвшинжаргал, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Баярбат нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-г заасны дагуу дээрх хуулийн төслүүдийн санал хураалтыг хойшлуулав. /17:50/

Бусад. Улсын Их Хурлын Б.Пүрэвдорж “Малчдын зээлийг тэглэ” гэсэн лоозонг ширээн дээрээ байрлуулсан байв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 21 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 31 минут үргэлжилж, 72 гишүүнээс 40 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр 17 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
11 цаг 02 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 05 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 23 асуудал байгаа.

Хуулийн төслүүд эцэслэн батална. Нийт 12 хууль, түүний хамт өргөн мэдүүлсэн 40 хуультай.

2 дугаарт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал.

3 дугаарт, Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай асуудал,

4 дүгээрт, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

5 дугаарт, Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

6 дугаарт, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

7 дугаарт, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

8 дугаарт, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

9 дүгээрт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

10 дугаарт, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл,

11-д, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл,

12 Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг,

13. Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг,

14. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

15. Хууль зүй, дотоод хэргийн эрхлэх асуудлын хүрээнд хамрах хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд,

16. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

17. “Шүүгчийн орон тоог батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

18. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

19. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

20. “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

21. “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

22. “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

23. Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж 1 гишүүн санал ирүүлсэн байна.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр хоршооны хууль хэрэгжээд бас энэ хөдөөгүүр зээл олгож байгаа. Тэгэхээр энэ дээр бас тодорхой болгоомжтой байгаарай л гэж би байнга сануулга хэлээд байгаа. Тэгэхээр

ер нь бол зээлээ авдгаараа ав. Манай малчид зээлээ авдгаараа ав. Тэгээд зээл авчхаад тэр 8 жилийн туршид энэ /бүтэн өгөөрэй энэ, үүнийг бүтэн өгөөрэй зураглаачаа, зураглаачаа үүнийг бүтэн өгөөрэй/ 8 жил зээлээ авдгаараа ав. Тэгээд 8 жил засгийн бариагүй үйлдвэрийг манай малчид өөрсдөө барина гэж явж байгаад эрсдэлд оруузай л гэж би бас захиад байгаа. Ер нь бол хоршоонд хамтарч зээл авч байгаа тэр хүмүүс дээрээ маш болгоомжтой байгаарай. Ах, дүү 2 мөнгөнөөс болоод тангараг тасардаг ийм тохиолдол маш их байгаа.

Тийм учраас энэ хариуцлагагүй зарим нэг этгээдийн өмнөөс зээл төлөх тийм эрсдэл гаруузай гэж хэлмээр байна. Ер нь бол аль болох л зээл авахдаа хувиараа, малчин хувиараа зээл авч болж байгаа, дангаараа зээл авч болж байгаа. Тэр дангаараа зээлийг л аль болох аваарай л гэж бас та бүхэнд зөвлөмөөр байна.

Тэгээд авсан зээлээрээ өнөөдөр байгаа тэр өндөр хүүтэй зээлээ эхний ээлжид хаачих. Тэгвэл илүү үр дүнтэй. Тэгээд жоохон илүү гарах юм бол нөгөө нэг манай энэ ЖДҮ-чид шиг ЖДҮ-ийн зээл авчхаад нөгөө нэг 3 хувийн хүүтэй зээл авчхаад баахан өндөр хүүтэйгээр банкад хадгалуулсан. Түүнтэй адилхан банкад жоохон өндөр үнэтэй хадгалуулаад арвижуулах талаараа бас анхаараарай гэж хэлмээр байна.

Тэгээд ер нь бол малчдын зээл бол дунджаар 5 сая төгрөгийн зээл байгаа. Тэгэхээр энэ 5 сая төгрөгийн зээл та нар бас авна гэсэн үг. Тэгэхээр энэ үүнийг аваад ингээд тэр 18, 20 хувийн хүүтэй зээлийг 3 хувь руу буулгалаа гэхэд нэг жилийн зөрөө нь бол төрөөс нэг 700 мянган төгрөг л та нар дээр гарч байгаа юм байна лээ. 700 мянган төгрөг. Тэгэхээр ийм учраас ер нь бол тэр та бүхнийг зүгээр ингээд л нэг жоохон энэ малчдын зээлээр бол нэг жоохон авах гэж байгаа хүмүүсийг л нэг тийм баярлуулаад байх шиг байна.

Тэгэхээр аль болох л бид нарын манай АН-ын бүлгээс өргөн барьсан малчдын зээлийг тэглэмээр байна. Дунджаар 5 сая төгрөгийн зээлтэй байгаа тэр зээлийг тэглэхэд бол ойролцоогоор нэг 750 тэрбум төгрөг л гарах юм. 5 их наяд төгрөг гаргаж байхын оронд 750 тэрбум төгрөгөөр малчдынхаа зээлийг тэглэх шаардлагатай байна.

Манай зарим ард иргэд бас дургүйцдэг. Гэхдээ 50 жил болоогүй, 40 жил болоогүй айхтар хүнд ийм зуд Монгол орон даяар нүүрлэсэн. Тийм учраас нэг удаа малчдаа бодож энэ 750 тэрбум төгрөгөөр малчдын зээлийг хаах бүрэн боломж манай Монгол Улсад байгаа. Энэ яамнууд дээр тавьсан яамдын сайд нар, дарга нарын гарын салаагаар урсдаг мөнгө бол хангалттай их бий. Хэдэн их наядаараа байгаа гэж байгаа юм. Засаг замбараагүй зарж байна. Энэ мөнгөнөөс хэмнэж байгаад 750 тэрбум төгрөгийг л гаргаад малчдынхаа зээлийг хаачих юм бол малчдаа маш их тийм буян болно.

Тэгэхээр би бол энэ зээлийг тэглүүлэхийн талаар эцсээ хүртэл зүтгэнэ, эцсээ хүртэл тэмцэнэ. Ямар ч байсан тэр хоршооных нь зээлийг аваад явж бай. Тэгээд малчдын зээлийг шинэ засаг байгуулагдаад, шинэ парламент байгуулагдахаар үүнийг хамгийн эхний эн тэргүүнд шийднэ ээ л гэсэн ийм зорилттой явж байгаа шүү. Тэгээд итгэл найдвараа бүү алдаарай гэж хэлмээр байна.

Г.Занданшатар: Энэ хэлэлцэх асуудалд орно.

Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батална. Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах шаардлага хангасан үед хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах дэгтэй. Ийм учраас хойшлуулж байна.

Одоо хэлэлцэх асуудалдаа орно.

Ажлын хэсгийг оруулаарай.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Ажлын хэсгийг оруулъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцэнэ.

Ажлын хэсэг байна уу? Танилцуулах хүн байна уу? Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай саналыг танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1. 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд Цэдэвийн Цолмонг нэр дэвшүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хорооноос шийдвэрлэж, санал, дүгнэлтээ ирүүлснийг танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Цэдэвийн Цолмонг Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд, Цэдэвийн Цолмонг Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх саналыг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 72,7 хувиар дэмжсэн болно. Асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү гэж Төрийн байгуулалтын байнгын хорооноос Хууль зүйн байнгын хороонд уламжлаад ингээд Хууль зүйн байнгын хорооноос Цэдэвийн Цолмонг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах саналыг дэмжсэн байна.

Цэдэвийн Цолмонг 1 дүгээрт, онол эрдэм шинжилгээний ажлын мэдлэг, туршлага, 2 дугаарт, хууль тогтоох байгууллага Улсын Их Хуралд хууль тогтоох чиглэлээр ажилласан ажлын

туришлага, 3 дугаарт, Гүйцэтгэх эрх мэдэл Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хууль боловсруулах, биелүүлэх чиглэлээр ажилласан ажлын туришлага, 4 дүгээрт, шүүх байгууллагад ажилласан туришлагаудыг үндэслэж Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлж байна.

Цэдэвийн Цолмон нь 1973 онд төрсөн. 1988 онд Улаанбаатар хотын 10 жилийн 52 дугаар дунд сургуулийг төгссөн. 93 онд Омск хотын технологийн сургуулийг фото техникч, технологич мэргэжлээр, бакалаврын зэрэгтэй. 94-98 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр, 2001-2003 онд Их Британи улсын Эксетерийн Их сургуулийн Хууль зүйн магистрын зэрэг, 2013-аас 14 онд АНУ-ын Нью-Йорк хотын Колумбийн Их сургуулийн Хууль зүйн магистрын зэрэгтэй тус тус төгсгөсөн.

1993-аас 94 онд Улсын Их Хурлын Тамгын газарт Зохион байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн, 98-аас 2001 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш, 2004 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх, 2004-2013 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, 2016-2019 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, 2020-оос 22 онд Эрдэнэс Монгол ХХК-ийн дэд захирлаар тус тус ажилласан. 2022 оноос Монголын хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч арбитрчаар ажиллаж байна.

Цолмон Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлсэн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье гэсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг Алтанхуягийн Үйлстөгөлдөр танилцуулна. Содбаатар даргыг дууд.

А.Үйлстөгөлдөр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1

дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 14 дүгээр захирамжаар Рагчаагийн Батрагчааг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар Улсын Их Хуралд санал болгон Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулж байна.

Нэр дэвшигч Бэсүд овогтой Рагчаагийн Батрагчаа нь 1977 онд Улаанбаатар хотод төрсөн, 46 настай, эхнэр 4 хүүхдүүдийн хамт амьдардаг. Нэр дэвшигч Батрагчаа нь 1995 онд Улаанбаатар хотын 10 жилийн 77 дугаар дунд сургуульд бүрэн дунд, 1999 онд Отгонтэнгэр Их сургуулийн Олон улсын эрх зүйн бакалаврын зэрэг, 2002 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Хууль зүйн ухааны магистрын зэрэгтэй тус тус төгссөн. Англи, орос хэлтэй.

Нэр дэвшигч Батрагчаа нь 1999-2000 онд Сэлэнгэ аймгийн Зүүнхараа дахь Сум дундын прокурорын газарт хяналтын прокурор, 2001-2003 онд Түшээ хууль зүйн дээд сургуульд эрх зүйн тэнхимийн багш, 2005-2006 онд Их Британийн Умард Ирландын хаант улсын Бермен хуулийн фирмд туслах хуульч, 2007-2008 онд Дата мо компани болон Кью жи экс Монгол компанид хуульч, 2008-2016 онд Эй энд Эй Глобал хуулийн фирмийн захирал, өмгөөлөгч, 2016-2019 онд Төрийн орон сууцын корпорац төрийн өмчит газрын Захиргаа санхүүгийн газрын дарга, 2019-2020 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, 2020-2022 онд Эрчим хүчний яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, 2022-2024 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, 2024 оны 01 сараас Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөхөөр тус тус ажиллаж ирсэн туришлагатай бөгөөд үүнээс хуульч мэргэжлээр 17 жил ажилласан байна.

Нэр дэвшигч Рагчаагийн Батрагчаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан болзлыг бүрэн хангасан, эрх зүйч мэргэжилтэй, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, хууль зүй, улс төрийн өндөр мэргэжилтэй байх шаардлагыг бүрэн хангаж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах санал болгож байна. Нэр дэвшигч Батрагчааг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох асуудлыг хууль тогтоомжид заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай 3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 13 дугаар захирамжаар Бямбадоржийн Болдбаатарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах Улсын Их Хуралд санал болгон Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулж байна.

Нэр дэвшигч Хиад овогтой Бямбадоржийн Болдбаатар нь 1968 онд Улаанбаатар хотод төрсөн, 56 настай, эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг. Нэр дэвшигч Болдбаатар нь 1986 онд Улаанбаатар хотын 10 жилийн 33 дугаар дунд сургуульд бүрэн дунд, 1992 онд Москва хотын Авто замын дээд сургуулийг инженер, 2001 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйн бакалаврын суралцсанаар суралцаж төгссөн. Орос, англи хэлтэй.

Нэр дэвшигч Болдбаатар нь 1990-1991 онд Гадаадад суралцагч Монгол оюутны Холбооны ерөнхийлөгчөөр, 92-оос 1997 онд Боловсрол компанид

менежер, 1997-2000 онд Түшиээ дээд сургуульд гүйцэтгэх захирал, 2004-2005 онд Улсын Их Хурал дахь Эх орон Ардчилал эвслийн бүлгийн ажлын албанд ахлагч, МАХН-ын бүлгийн дэд дарга, 2005-2006 онд УБТЗ компанид Хууль зүйн албаны дарга, 2006-2012 онд Улсын Их Хурал дахь АН-ын зөвлөлийн бүлгийн ажлын албаны дарга, 2012-2016 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, 2017-2021 онд Монгол Улсаас Бүгд найрамдах Болгар Улсад суугаа ЭСЯ-нд зөвлөх, 2021 оноос Улсын Их Хурлын Тамгын газарт зөвлөх, ахлах зөвлөх, Хууль, эрх зүйн газрын даргаар тус тус ажиллаж ирсэн туршилагатай бөгөөд үүнээс хуульч мэргэжлээр 19 жил ажилласан байна.

Нэр дэвшигч Бямбадоржийн Болдбаатар нь Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан болзлыг бүрэн хангасан, эрх зүйч мэргэжилтэй, хууль зүй, улс төрийн өндөр мэргэжилтэй байх шаардлагыг бүрэн хангаж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгож байна. Нэр дэвшигч Бямбадоржийн Болдбаатарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох асуудлыг хууль тогтоомжид заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Одоо нэр дэвшүүлсэн байгууллага болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Уучлаарай.

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгосон нэр дэвшигчийн талаарх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Рагчаагийн Батрагчаа, Бямбадоржийн Болдбаатар, Улсын Их Хурлаас Цэдэвийн Цолмон нарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар тус тус санал болгосон.

Байнгын хороо уг асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцэж, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгосон Рагчаагийн Батрагчаа, Бямбадоржийн Болдбаатар, Цэдэвийн Цолмон нарыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Б.Буяндэлгэр, Ш.Солонго, Туулхүү нарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай болон Ц.Цолмон, Б.Болдбаатар, Р.Батрагчаа нарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгосон нэр дэвшигчийн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Нэр дэвшсэн байгууллага болон нэр дэвшигчдээс асуух асуулттай, үг хэлэх гишүүн байна уу? Тасаллаа. Алга байна.

Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Өөр ахиж байхгүй. Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Асуулт, үг нэг явж байгаа.

Ж.Сүхбаатар: Би нэр дэвшигчид 3 нэр дэвшигч томилогдох гэж байна. Өөрөөр хэлбэл цэцийн гишүүдийн 3-ны 1 нь нэг дор солигдож байгаа юм. Тэгэхээр одоогийн парламент бол өмнөх 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх чиглэлээр бол ажилласан. Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийг гол манадаг, хянадаг, ийм Үндсэн хуулийн биелэлтийг хангадаг ийм газар.

Өнгөрсөн муу зүйлүүд бол байгаа. Жишээлбэл Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр аймгийн АН-ын дарга байсан хүн гэж хэлээд, улс төрийн би өндөр мэргэшилтэй гэж хэлээд хуульч биш хүн тавигдаж байсан. Тэгэхдээ түүнтэй харьцуулах юм бол өнөөдөр ингээд дандаа хууль зүйн чиглэлээрээ олон жил ажилласан хүмүүс орж ирж байгаа нь сайшаалтай. Тэгэхдээ 1 асуудлууд байгаа.

Би та 3 нэр дэвшигчдэд бас хэлэх зүйл бол ер нь Үндсэн хуульд үнэнч байх тухай асуудал байгаад байгаа юм. Үндсэн хуульд тангараг өргөх ёстой, Үндсэн хуульд үнэнч байх ёстой. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн сүүлийн жилүүдийн гол дутагдал нь юу гэж яриад байсан бэ гэхээр зэрэг улс төрийн өндөр мэргэшилтэй гэдэг нэрийн доор улс төрийн өндөр мэргэшилгүй хүмүүс томилогдоод байна. Цэц бизнесийн сонирхлоор ямар нэгэн сэжигтэй ийм шийдвэрүүд гаргаад байна. Тодорхой улс төрчдийн талд ороод байна гэдэг юм уу ийм асуудлууд гарсан.

Тэгэхээр манай энэ Болдбаатар, Цолмон, Батрагчаа 3 байж байна. Төвч голч байх гэдэг бол Үндсэн хуульд захирагдахаас гадна төвч голч байх энэ

чанараа анхаараарай. Ер нь бол цэцэд орохоор зэрэг нөгөө хөх тэнгэр эд нар гэдэг ч шиг ингээд манай зарим нь буруу ойлгоод даналзаад байдаг юм байна лээ. Цэцийн хуралдаанд би бас олон удаа л Их Хурлыг төлөөлж оролцлоо. Тэгээд бүр тэр байтугай асуудлыг ойлгож байгаа мөртөө Улсын Их Хурлын эмнитетэд хүртэл халдсан өөрсдөд нь хамааралтай хүртэл тийм шийдвэрүүдийг хүртэл ингээд л өөдөөс харж байгаад л гаргаж байгаа юм.

Тэгэхээр энэ Үндсэн хуулийн онол, арга зүйн талаар бас нэлээн дэвшилттэй тэр зүйлүүдийг нь Үндсэн хуулийн цэц бол харуулах хэрэгтэй байна. Тэгээд гол хэлэх гэж байгаа юм бол юу байна вэ гэхээр зэрэг бид нар ойрын жилүүдэд бол асуудалтай тулгарна. 126 гишүүнтэй шинэ парламентыг. Ер нь сайн юм муутайгаа ирдэг. Тэгээд яваандаа сайн нь давамгайлж амьдралд хэвшиж тогтдог гэж үздэг. Манай хүмүүсийн ихэнх нь бол үгүй ээ нэг сайн юм ирчихлээ гэхэд тэр чигтээ тэр өдрөөсөө сайхан болно гэж бодно.

Тэгэхээр 126 гишүүнтэй парламентад асуудлууд их гарна, зөрчил тэмцэл гарна, сахилгагүй байдлууд гарна, шүүмжлэл их ирнэ. Гэхдээ энд ямар асуудлууд үүсэх вэ гэхээр энэ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дээр Үндсэн хуулийн гол санаа бол парламентын Бүгд Найрамдах Улс, парламентын ардчилсан тогтолцоог бид хамгаалахаар энэ Үндсэн хуулийн амин сүнс өөрөө оршиж байгаа.

Тэгэхээр одоогийн Үндсэн хуулийн цэцийн гишүүд ямарваа шийдвэр гарлаа гэхэд эцсийн дүндээ парламентын амин сүнсийг, тэр Үндсэн хуулийн амин сүнсийг голыг хамгаалах ёстой ард түмний төлөөлөгчдийн байгууллага юм. Тэгэхээр би та 3-аас үнэхээр хичээнгүйлэн үзэх зүйл нь бол та хэдийн цэцийн гишүүнээр байх хугацаанд Монгол Улсын парламентын дархлаа, Монгол Улсын парламентын ардчилсан тогтолцоо суларч болохгүй. Их Хурлын гишүүд

асуудалд орж болно. Ард түмний төлөөлөгч юм чинь 126 дотор битгий хэл, 76 дотор олон асуудлууд гарч л байгаа. Амьдрал. Гэхдээ цаад хүнтэй хувь хүнийх нь асуудалтай холбогдоод тухайн парламентыг ажиллах чадамжгүй, бүтээмжгүй энэ байдал руу оруулж болохгүй.

Тийм учраас би энэ цэцийн гишүүдийнхээ зүрх сэтгэлд Үндсэн хууль гэдэг бол цаасан дээр бичигдсэн зүйл биш шүү. Энэ бол үе үеийн хүмүүсийн зүрх сэтгэл дээр ард түмний тэр зүрх сэтгэлээс гарч ирсэн ийм амин сүнс байгаа.

Тэгэхээр энэ амин сүнсэнд үнэнч байгаасай. Тэгээд дандаа шинэ улсууд байж байгаа. Өмнөх улсууд ч гэсэн нэлээн сайжраад явж байгаа. Тэгээд гурвууланд чинь захиж хэлэх юм ийм байна. Мэдээж амьдрал болсон хойно ингээд үйл ажиллагаатай холбоотой асуудлууд дээр санал бодлоо хэлээд явах байх. Тэгэхээр энэ дээр л хэлье дээ. Амин сүнс шүү. Үзэл санаа, амин сүнс. Энд л захирагдаж Үндсэн хуульдаа үнэнч байж ингээж л ажиллахыг би хүсэж байна.

Г.Занданшатар: Үг хэллээ. Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр бас нэр дэвшиж орж ирж байгаа 3 нэр дэвшигч гурвуулаа бас туршилагатай. Ялангуяа бас хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалд аль алинд нь ажиллаж байсан ийм туршилагатай байна. Энэ бол бас маш онцлог бас онцлог байна. Цэцийн гишүүдийг бид нар томилохдоо сүүлийн үед нэлээн олон багш нараар томилчихсон. Миний маш сайхан багш нар, олон багш нар цэцийн гишүүн болсон байгаа. Түүнээс гадна бас тийм үү, тэнд дутагдаад байгаа өнгө бол үндсэндээ энэ улс төрийн болон хууль, эрх зүйн, дээрээс нь шүүх засаглалын бас ийм тодорхой туршилагатай хүмүүс бас тэнд дутагдаж байсан. Үндсэндээ энэ нөхөгдөж байна гэж ойлгож байгаа.

Цолмон болд тийм үү, яах аргагүй гүйцэтгэх засаглалд насаараа ажилласан, Хууль зүйн яамны Хууль зүйн бодлогын газрын даргаар арваад жил ажилласан туршилагатай хүн. Хууль хэрэгжүүлэх тал дээр. Мөн бас Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын даргаар бас 3 жил ажилласан. Улсын Их Хурал төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага. Төрийн бодлогын бүх асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцдэг, тодорхойлдог. Улс төр, нийгэм, эдийн засаг, шүүх, хууль хяналт гээд бүгд хэлэлцэгддэг энэ тогоонд чанагдана гэдэг бол маш өндөр туршилага, хуримтлуулж байгаа.

Болдбаатар даргын хувьд ч ялгаа байхгүй бас, 12-16 онд Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын даргаар ажиллаж байсан бас ийм туршилагатай. Бас одоо юу гэдэг юм улс төржихгүй. Энэ бас томилгоо болдог юм уу ямар нэгэн улс төр харсан байдлаар орж ирэхгүй байгаад нь бас талархаж байна. Бас тийм. Ийм туршилагатай хүн.

Тийм болохоор та хэд маань бас тэр улс Үндсэн хуулийн цэц дээр очоод энэ дутагдаад байгаа бас өнгө аясыг бас тийм үү, гүйцээгээсэй. Солонгын 7 өнгө шиг л байж байж тийм үү, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр бас мэргэн байна. Энэ тал дээр анхаараасай гэж 1 дүгээрт, нь захиж хэлэх гэж байгаа юм.

2 дугаарт, нь 19 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бид нар хийсэн. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт сайн болсон. Байгалийн баялгийн өгөөжийг Монголын ард түмэн хүртэх энэ боломжийг Үндсэн хуулиараа бид нар нээж өгсөн. Өнөөдөр хүртээд эхэлж байгаа. Цаашидаа ч өшөө их хүртэх бололцоотой болж байгаа. Нийгэмд шударга ёсыг тогтоох, шударга ёсны хүсэл эрмэлзэл ард түмэнд маш их байсан. Үүнийг бас бий болгох тал дээр Үндсэн хуульдаа бид бас өөрчлөлт хийсэн. Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо байгуулах, хянан шалгах эрх мэдлийг нэмэгдүүлсэн. Энэ хүрээндээ үндсэндээ Хянан шалгах түр хороо ажиллаж,

мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж, нийгэмд нүүрлээд байсан хулгай, хууль зөрчдөг асуудлыг цэгцэлж байгаа. Үүнийг өшөө цааш нь төгс төгөлдөр болгох шаардлагатай байх.

Монгол төрийн бодлого бас тодорхой байх, тогтвортой байх энэ асуудлыг бас Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлт шийдчихсэн. Урт хугацааны хөгжлийн бодлоготой байна, түүндээ уялдуулж төсөв төлөвлөгөө бүх юм уядаг байх. Энэ бол амжилттай хэрэгжиж байгаа. Яг ийм байдлаар бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор бид нар Үндсэн хуулийг амилуулах, Үндсэн хуулийн зүйл, заалтыг тийм үү, хэрэгжүүлэх нэлээд олон хуулийн нэмэлт, өөрчлөлт хийх ёстой. Энэ маань хангалттай бас хийгдэхгүй байгаа. 40 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт хийгдэх ёстой. Зарим нь хийгдээд явж байна, зарим нь хийгдэхгүй байна.

Тийм болохоор бас 19 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амилуулж, нийгэмд хэрэгтэй, ард иргэдэд хэрэгтэй, Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, Монгол Улсын эдийн засагт ач холбогдолтой ийм томоохон бас хуулиудын өөрчлөлтүүдийг хийх тал дээр та бүхэн бас илүү бас анхаарч ажиллаарай. Яагаад гэвэл би хэлж байгаад Улсын Их Хурлын Тамгын газарт тийм үү, энэ төрийн бодлого тодорхойлох, хууль тогтоох дээд засаглалд ажиллаж тийм үү, гал тогоонд бас удирдаж барьж явсан хүний хувьд юу дутагдаж байгааг манай Цолмон дарга, Болдбаатар дарга нар сайн мэдэж байгаа, сайн мэдэж байгаа.

Тийм болохоор энэ тал дээр бас нэг дутагдаж байгаа нь Үндсэн хуулийн заалт амилуулахад тодорхой дутагдаж байгаа бас асуудлууд байгаа шүү. Энэ болгон дээр бас илүү санаачилга гаргаад, илүү бас Улсын Их Хуралтай хамтарч ажиллаж, энэ асуудлыг илүү амилуулъя. Ингэж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг төгс төгөлдөр болгож, Монгол Улсын энэ тусгаар тогтнол,

үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн ач холбогдлыг нэмэгдүүлэхэд анхааръя гэдэг тал дээр санаачилгатай ажиллаарай л гэж ингэж хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэллээ. Тогмидын Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа. Өмнөх 4 жилийн хугацаанд Үндсэн хуулийн цэц дээр бол маш олон маргааныг бас үүсгэж байсан. Тэгээд тэр хүрээндээ Үндсэн хуулийн цэц гэдэг бол маш чухал ийм институц юм байна. Ялангуяа энэ парламентын ардчиллыг бэхжүүлэхэд, ардчиллыг хамгаалахад, тэгээд цаашаа энэ Үндсэн хуулийг хөгжүүлэхэд бол хамгийн их чухал ийм бүтэц байдаг юм байна гэдгийг бол маш сайн ойлгосон.

Тэгээд тийм болохоор надад бол ийм тов тодорхой 2 асуудал байгаа юм л даа.

1 дүгээрт, бүх нэр дэвшигчдээс асуумаар байгаа юм. Та бүхэн энэ парламентын ардчиллыг бэхжүүлэх чиглэлээр цаашаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал ярилаа гээд тэгэхэд түүн дээр бол байж чадах уу, 1.

2-т нь, ингээд онолын чиглэлээр бид нар маргаан өрнүүлэх үнэхээр их зайлигүй шаардлага байгаа юм байна лээ л дээ. Тэгсэн тохиолдолд өрнүүлсэн тэр маргааныхаа үр дүнд зөвлөмжийг бас ингээд парламентаар өгөх ёстой юм билээ. Үндсэн хуулийн цэцийн гишүүд гэдэг бол зөвхөн Үндсэн хуулиа хамгаалдаг байж болохгүй юм байна лээ шүү. Үндсэн хуулийн цэцийн гишүүд гэдэг бол цаашаа Үндсэн хуулийг хөгжүүлэх, үзэл санааг хөгжүүлэх, тэгээд цаашаага тэр хөгжил дэвшлийнх нь тал дээр нь яг онолын ингээд хамгаалагчид байх ёстой юм байна лээ шүү. Тэгээд тэр агуулгаараа парламент буруу шийдвэр гаргах юм бол түүнийг нь хязгаарлах ёстой юм байна лээ.

Тэгээд ийм агуулгыг та бүгд бас дэмжиж байна уу. Манай парламентын зарим гишүүд болохоор парламент л шийдвэр гаргасан бол бандан пад. Цэц бол түүний хүрээнд л гарах ёстой, түүний хүрээнд л ажиллах ёстой гэж бас яриад байдаг. Гэтэл олон улсын Үндсэн хуулийн тэр цэц нь болохоороо Үндсэн хуулиа хамгаалахаас гадна Үндсэн хуулийн бас зүйл, заалтад тайлбар хийдэг, соён гэгээрүүлдэг, тэгээд парламентын бас буруу шийдвэрүүдийг зөвхөн ингээд хуулийн хүрээнд биш, тэр суурь үзэл санаа, тогтолцооных нь хүрээнд нь ингээд яриад засаж, залруулдаг ийм бүтэц байх ёстой юм байна гэдэг ийм итгэл үнэмшил авсан. Тэгээд энэ дээр та бүгд бас байж чадах уу гэдэг ийм 2 асуудал бол байна.

Тэгээд яах вэ, эцэст нь гээд хэлэхэд яах вэ, 2022 онд бид нар 01,02 дугаар шийдвэр гаргаж байсан. Маш олон хүмүүс шүүмжилж байсан юм л даа. Тухайлбал давхар дээл углуулчихлаа, Доржханд аа гээд. Цэцэд бол бид нар бүр б цаг маргаан хийж байсан. Үүний үр дүнд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт өнөөдөр ингээд бий болоод ардчилал маань ингээд бэхжээд, парламент маань ингээд солонгорсон. Нэг намын биш, нэг хүний дарангуйлал биш илүү ингээд дархлаатай парламент үүсэх цаг хугацаа өнөөдөр үүсчхээд байгаа юм л даа. Энэ дээр бол нийгмээрээ бүгдээрээ ингээд буруу шааж байсан ч гэлээ гэсэн өнөөдөр үр дүнг нь хараад бүгдээрээ зөв байжээ гээд байгаа юм. Тэр үед бол Үндсэн хуулийн цэцийн гишүүд бол нэг талдаа байж чадсан юм. Өөрөөр хэлэх юм бол нийгэм яаж хүлээж авахаас үл хамаараад, улс төр яаж салхилахаас үл хамаараад, хатуу зарчим дээрээ ингээд байгаад, улс орныхоо эрх ашиг дээрээ ингээд байж чадсан болохоор өнөөдрийн энэ өөрчлөлтүүд гарсан байдаг юм.

Тэгээд үүн дээр бол Үндсэн хуулийн цэцийн үүрэг нөлөө маш их байдаг юм байна. Цаашидаа ч илүү байх юм байна. Яагаад тэгээд тэгэхээр парламентын ардчиллын бэхжүүлэх ажил маань

дуусаагүй байгаа юм. Маши олон хуульчид Үндсэн хууль гэдэг бол алгын чинээ цаас, тэгээд зүрхний хэмжээтэй байна, тэгээд зүрхэнд багтах эх орон юм энэ тэр гээд бас ингээд уянгалаад байдаг юм шүү. Зарим хүмүүсийн нэрийг дурдаад. Уучлаарай. Үндсэн хууль засаж сайжруулах шаардлагатай бол засаж сайжруулах шаардлага бол байна. Ялангуяа эдийн засгийн асуудлууд, зохицуулалтууд ерөөсөө ороогүй. Түүнээсээ болоод бид нар, хот ч байхгүй, ингээд түгжирчихсэн, гацчихсан ийм зүйлүүд байгаад байгаа юм.

Тэгэхээр цаашаагаа үүнийгээ сайжруулаад явах ийм шаардлага байгаа л бол үүнийг хийх талд нь та нар бас байж чадах уу гэдэг дээр бас асуулт асуумаар байгаа юм. Үгүй бол ингээд л бид нар зөвхөн хамгаалагч, өөрчилж болохгүй, бид нар л үүнийг өөрчлүүлэхгүй гэсэн байдалтай байх юм бол энэ улс яаж хөгжих билээ ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? 1 номер Бямбадоржийн Болдбаатар нэр дэвшигч.

Б.Болдбаатар: Их Хурлын дарга, гишүүдэд энэ өдрийн амар амгаланг айлтгая. Тэгээд Доржханд гишүүний асуултад хариулъя. Үндсэн хууль гэдэг бол зүгээр цаасан дээр бичээд орхичих зүйл биш. Энэ байнга амилж байх ёстой. Энэ бол Монголын ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл болсон ийм тулгуур гол хууль байгаа.

Нийгмийн харилцаа орчин үеийн шинжлэх ухаан, технологийн дэвшилтэй уялдаад байнга хувьсан өөрчлөгдөж байгаа. Тэр хүрээгээрээ бас энэ нийгмийн харилцааг зохицуулж байгаа гол хуулиуд, тулгуур хуулиуд, ердийн хуулиуд бүгд өөрчлөн хувьчлагдаж байх ёстой. Цаг үеийнхээ шаардлагад нийцээд. Тэр утгаараа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт зайлиггүй хийгдэж байх ёстой гэж би бол хувьдаа үздэг юм. Тэр утгаараа Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга ажиллаж

байхдаа 2019, 2016 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж байсан. Үүний дараагаар бас 19 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэ ажлын хэсэгт ч бас санаа оноогоо хүргэж байсан. Энэ хүрээнд манай үйлчилж байгаа Үндсэн хуульд бас нэлээдгүй өөрчлөлт хийх шаардлага байгаа. Яах вэ 16, 19 онд хийсэн нэмэлт, өөрчлөлтөөр тэр олон иргэдийн нийгмийн захиалгаар болсон энэ өөрчлөлтүүдийг хийж чадаагүй тал бий. Гүйцээж хийх шаардлага байгаа. Түүний дотроос одоо Их Хуралд өргөн баригдаад байгаа Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуульд маргаан шийдвэрлэх тэр процессын тухай хуулиуд дээрээ бас Үндсэн хуульд нийцүүлээд нэмэлт, өөрчлөлтөө хийх замаар энэ хуулиудыг шинэчлэх шаардлага байгаа гэж харж байгаа.

2 дугаарт нь, бас Доржханд гишүүн бас зөв асуулт хөндөж тавилаа. Юу вэ гэхээр зэрэг, Үндсэн хуулийн цэц бол зөвхөн Үндсэн хуулийг биелэлтийг хангаж байдаг. Тэгээд баталгааг хангаж байдаг. Хяналтын чиг үүрэг биелүүлэхээс гадна мөн бас Үндсэн хуулийг сурталчлах, Үндсэн хуулийн биелэлтийг хангах талаар бусад байгууллага, ард иргэдэд зөвлөгөө өгөх ийм чиг үүрэг байх нь зүйтэй байх гэж бодож байгаа. Ер нь манай Монгол Улсад одоо хэрэгжиж байгаа хууль тогтоомж бас л хангалттай хэмжээгээр гарчхаад байгаа. Нэг хэцүү асуудал байгаа нь юу гэхээр зэрэг хууль тогтоомжийн биелэлт хангалтгүй байгаад байдаг. Хууль тогтоомж ард иргэд нь, аж ахуйн нэгж, байгууллагууд нь энэ нийгмийн харилцаанд орж байгаа тэр бүх субъектүүд хангалттай мэдэж чадахгүйгээс хууль биелэхгүй байх асуудал хаа сайгүй байгаа.

Тийм учраас хуулийг сурталчлах ажиллагаанд цэц төдийгүй бүх л төрийн байгууллага, албан тушаалтан, төрийн болон орон нутгийн байгууллагууд гээд энэ бүх улсууд бүгдээрээ оролцож, бие биедээ таниулга сурталчилгаа хийж байх замаар хуулийн биелэлтийг сайжруулах

шаардлагагүй гэж үзэж байгаа. Тийм учраас энэ тал дээр хэрвээ томилогдох юм бол энэ чиглэлээр бас энэ хууль тогтоомжийн эрх зүйг орчныг бүрдүүлэх чиглэлээр бас ажиллана гэсэн ийм бодолтой байгаа.

Г.Занданишатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Үндсэн хуулийн цэцийн гишүүний томилгоо орж ирж байна. Тэгээд яг өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц гэдэг байгууллага өнгөрсөн хугацаанд ер нь л нэг ийм төлөвшилгүй явж ирсэн байгууллага л өнөөдөр дарга, цэрэг байхгүй, нэг асуудлаар удаа дараа өөр өөр шийдвэр гаргадаг, улс төрчдийн, эрх баригчдын захиалгаар шийдвэр гаргадаг нь тодорхой болоод л өнгөрсөн хугацаанд явж ирсэн. Ийм хараат бус бие даасан байдал байхгүй. Яг л нэг ийм шүүмж талаасаа хэлэх юм бол асар олон зүйлүүд Үндсэн хуулийн цэц дээр бид бүгд захын хүн хэлнэ. Тэгэхдээ өнөөдөр орж ирж байгаа энэ 3 хүний томилгоо бас харьцангуй бэлтгэгдсэн, шаардлага хангасан ийм бэлтгэгдсэн боловсон хүчнүүд орж ирж байх шиг байна. Би тэгээд та 3-аас 1 тодорхой нэг асуулт асуучихъя.

Тэр нь одоо яг Үндсэн хуулийн цэцийн тухай, цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиуд Улсын Их Хурал дээр явж байгаа. Мааш олон тийм зөрчилтэй асуудлуудыг ярилцаж хэлэлцэгдээд хэлэлцэх эсэх нь үндсэндээ хэлэлцүүлгийн шатад явж байгаа. Энэ хууль дээр байгаа тодорхой нэг заалт иргэний үндсэн эрхийн маргааныг Үндсэн хуулийн цэц дээр авч хэлэлцдэг, хэлэлцэх нь зөв эсэх тухай маргаан асуудал яг Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд ороод ирчихсэн явж байгаа. Та бүгд, та 3 энэ хууль дээр энэ зүйл заалт дээр ямар байр суурьтай байдаг вэ? Зөв гэдэг бол яагаад, буруу гэдэг бол яагаад гээд товчхон гурвуулаа энэ дээр хариулт өгөхийг хүсье.

Г.Занданишатар: Хэн хариулах вэ? Дараалаад Батрагчаа хариулъя. 2 номер Рагчаагийн Батрагчаа.

Р.Батрагчаа: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Миний хувьд иргэний үндсэн эрхийн маргааныг цэц дээр хүлээж авч шийдвэрлэх нь бол зөв гэж үздэг. Гэхдээ одоо Их Хурал дээр явж байгаа Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль дээр бас тийм учир дутагдалтай заалтууд байдаг. Яагаад би иргэний эрхийн үндсэн эрхийн маргааныг авч шийдвэрлэх ёстой вэ гэхээр шүүхийн шийдвэрийг цэц хянахгүй. Харин шүүхийн шийдвэрийн хэрэглэсэн тэр хууль нь өөрөө Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянадаг ийм зарчмаар хянаад явах нь зүйтэй байна гэдэг байдлаараа иргэний эрхийн үндсэн эрхийн маргааныг цэц хянах нь бол зүйтэй юм байна гэж судлаачийнхаа хувьд үздэг юм.

Г.Занданишатар: 4 номер Цэдэвийн Цолмон нэр дэвшигч саяын асуудлаар товч тодорхой ярьчих.

Ц.Цолмон: Гишүүдэд энэ өглөөний мэндийг хүргэе. Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Энэ Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг 2001 оноос эхэлж боловсруулж эхэлсэн юм байна лээ. Энэ чиглэлээр ажлын хэсэг нэлээн ажилласан байгаа. Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшиж байгаа учраас энэ хуулийн төслийн үйл явцтай нь холбоотой хэрхэн ажиллаж байгааг дотор нь ямар зүйл заалтууд байгаа талаар нарийвчлан судалсан. Саяхан энэ МУИС болон Улсын Их Хурлын Тамгын газар нийлээд Үндсэн хуулийн цэц дээр маргаан хянан шийдвэрлэх асуудал, Үндсэн хуулийн цэцийн талаар эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан байна лээ. Протоколтой танилцсан. Мөнх-Оргил гишүүн хурлыг өөрөө ахалсан. Монгол Улсад энэ Үндсэн хуулийн чиглэлээр судалгаа хийдэг бүхий л эрдэмтэд, мэргэд, докторууд Үндсэн хуулийн цэцийн

гишүүнээр ажиллаж байсан болон ажиллаж байгаа бүх хүмүүс орж нээлттэй илэн далангүй бас ярилцсан байна лээ.

Тэр Үндсэн хуулийн хүний иргэний үндсэн эрх зөрчигдсөн эсэх асуудлыг Үндсэн хуулийн цэц маргаан харьяалж шийддэг нь энэ маш чухал асуудал. Хувь хуульчийнхаа хувьд үүнийг 100 хувь дэмжиж байгаа. Зүгээр сая дэвшигч бас ярьж байна. Яг ямар маргааныг, ямар хэлбэрээр, яаж шийдэх ёстой вэ гэдэг дээр энэ Үндсэн хуулийн цэцийн тухай хууль болон маргаан хянан шийдвэрлэх хууль Улсын Их Хурал дээр хэлэлцэж байгаа учраас энэ дээр бас Улсын Их Хурал нэлээн сайн анхаарлаа хандуулж чамбай байдлаар шийдвэрлэх ёстой болов уу гэж бодож байна.

Ер нь гаднын улсын энэ Үндсэн хуулийн цэц болон Үндсэн хуулийн энэ маргааныг шийддэг байгууллагынх нь гол үндсэн хийдэг ажил нь иргэний үндсэн эрх зөрчигдсөн эсэх маргааныг шийдвэрлэж байдаг. Үүгээрээ иргэний Үндсэн хуульд заасан үндсэн эрх нь зөрчигдөх эсэхээс Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэц хамгаалж байдаг ийм л институц. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд энэ өөрчлөлт орж байгаа асуудлыг бүхэлдээ дэмжиж байгаа. Ер нь гэхдээ зүгээр хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрүүд нь үндсэн хүний иргэний үндсэн эрхийг зөрчөөд байна уу, үндсэн эрхийг нь бусад байгууллага зөрчсөнтэй холбоотой асуудал маргаан үүсгэх үү гэдгийг энэ цэцийн маргаан шийдвэрлэх тухай хууль дээр нарийвчлан зохицуулж өгөх нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байна. Баярлалаа.

Г.Занданишатар: 1 номер
Болдбаатар, Бямбадоржийн
Болдбаатар.

Б.Болдбаатар: Цогтгэрэл
гишүүний асуултад хариулья. Тэгэхээр иргэний үндсэн эрхийг зөрчсөн асуудлыг Үндсэн хуулийн цэцээр авч үздэг асуудал

бол одоо яригдаж байгаа асуудал биш л дээ. Энэ бусад орнуудын Үндсэн хуулийн шүүхүүд дээр бас байдаг, яригддаг энэ маргааныг бас хэлэлцэн шийдвэрлэдэг ийм туршилага бас байдаг. Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр гэж Улсын Их Хурал 2001 онд баталсан байдаг. Энэ хөтөлбөр дээр хүний үндсэн иргэний үндсэн эрхийг хамгаалах чиглэлээр юу хийвэл зохих вэ гэдэг ийм зорилтыг дэвшүүлж тавьсан. Үүнээс хойш энэ иргэний үндсэн эрхийг хангах чиглэлээр эрдэмтэн, судлаачдын нэлээн олон бүтээлүүд гарч байсан, хэлэлцүүлгүүд явж байсан, эрдэм шинжилгээний хурлаар ярьж байсан энэ асуудлууд хийгдчихсэн.

Мөн саяхан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр энэ чиглэлээр бас тодорхой зорилтуудыг тавьсан. Мөн Улсын Их Хурлаас баталсан хууль зүйн үндсэн чиглэл байгаа. Энэ дээр бас мөн энэ талаар тусгасан байсан. Тэгээд энэ хүрээнд манай Улсын Их Хурлын гишүүдээс өргөн барьсан цэцийн 2 хууль дээр иргэний үндсэн эрхийн маргааныг цэц шийдвэрлэдэг байхаар орж ирсэн байна лээ, байгаа.

Ер нь хуульч хүний хувьд харахад иргэний үндсэн эрхийн маргааныг цэц буюу Үндсэн хуулийн шүүхээр шийдэх нь зөв асуудал. Тэгэхдээ ямар арга хэлбэрээр хамгаалах вэ гэдэг дээрээ бас анхаарал хандуулах хэрэгтэй. Зүгээр одоо өргөн баригдсан байгаа 2 төслийн хүрээнд би хувь хүнийхээ хувьд харахад энэ маргааныг эхлээд Үндсэн хуульд Үндсэн хуулийн цэц шийдвэрлэж одоо байгаа 4 төрлийн маргаанаас гадна 5 дахь маргаан болгож оруулах замаар хуулийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийгээд түүнийхээ дараагаар энэ Үндсэн хуулийн цэц иргэний үндсэн эрхийн маргааныг шийддэг байх хуулийн зохицуулалтаа хийх нь зүйтэй юм болов уу гэж харж байгаа.

Тэгэхээр зэрэг энэ механизмыг яаж байх вэ гэдгийг бас нэлээн судалж байж хийх ёстой л доо. Зүгээр одоо байгаа төсөлдөө тусгасан байдлаар бас түрүүн

нэр дэвшигч нар ярьж байна. Шүүхийн шийдвэрийг эргээж бас хянадаг байх чиглэлээр ингээд харагдах юм бол бас Үндсэн хуулийн зөрчилд ч хүргэж магадгүй ийм бас байдал үүсэх учраас энэ дээр бас манай Улсын Их Хурал, тэгээд бусад байгууллагууд маань бол нэлээн хянуур хандаж шийдвэрийг гаргах нь зүйтэй гэсэн ийм ойлголттой байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Ингээд нэр дэвшээд орж ирж байгаа 3 хүний тухайд бол дэмжиж байна. Яагаад гэвэл энэ хүмүүс бол яг энэ хуулийн салбартаа танигдсан бас ёс зүйтэй. Яг нөгөө төрийн хар хүн гэдэг шиг бас ажлаа хариуцлагатай хийгээд улс төрийн нам гээд туйлираад байдаггүй. Ийм бас залуу гэж хэлж болох, ийм мундаг хүмүүс орж ирж байгаад би дэмжиж байна, 1 дүгээрт. Харин та нарын очих гэж байгаа юм энэ манай Монгол Улсын цэц маань өөрөө ямар болчихоод байна вэ гэдэг бол бид нарын хувьд сүүлийн үед эргэлзээ төрүүлдэг болчихсон. Уг нь бол цэцийн дээр хөх тэнгэр гээд хүмүүс Үндсэн хуулийн цэц гэдэг байгууллагыг бол яг үнэний туйл гэж хардаг, ёс зүйтэй хамгийн чухал байгууллага гэж үздэг. Гэтэл сүүлийн үед яг энэ нөгөө улс төрчдийгөө дагаад юм уу эсвэл нийгмийн энэ уур амьсгалыг дагаад манай цэц маань өөрөө дотроо хүртэл ямар ч ёс зүйгүй энэ тэр болоод хувираад байна л даа. Одоо бие биеийнхээ янз бүрийн бичлэгийг бичдэг, бичлэгээ албан тушаал, томилгооны үед юм уу, эсвэл ямар нэгэн үед олон нийтийн сүлжээнд гаргаж цацдаг гэх мэт. Нөгөө нэг сонгуулийн үед улс төрчид юм уу эсвэл өрсөлдөгчид нэг нэгнээ намнах үйл ажиллагаа энэ бохир технологи бид өөрөө халъя гээд хууль чангатгаад байхад харин манай цэц маань өөрөө ийм зүйл рүү хүртэл орж байгаа нь маш гутамшигтай харагдсан л даа.

Тэгэхээр энэ цэцийн ёс зүйн асуудал ч гэсэн өнөөдөр цэцэд нэр дэвшиж байгаа

хүмүүсийн ёс зүйн асуудал, энэ цэц өөрөө тэнд шударга ёсыг тогтоодог байх энэ асуудал бол 1 дүгээрт, их чухал болж байна. Тийм учраас би өнөөдөр нэр дэвшээд энэ хүмүүс хэрвээ дэмжигдээд очсон тохиолдолд үүнийг тэр байгууллагад хатуу сахих хэрэгтэй байна. Түүнээс саяын яг хэлээд байгаа тэр иргэний эрхийн Үндсэн хууль, энэ Үндсэн хуулийг маш чанд баримтлах, үүнийг бол шударга ёсыг тогтоох энэ асуудал дээр маш хариуцлагатай байх хэрэгтэй байгаа юм. Тэгэхгүй бол сүүлийн үед нээрээ нэг асуудал болбол иргэн цэц рүү ханддаг. Цэц яг түүнийг шүүж үзээд энэ хүн үнэхээр зөв асуудлыг хөндөж, энэ нь өөрөө Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн бол тэр асуудлыг үнэнээр шийддэг. Уг нь ингэж явж ирсэн. Гэтэл яг энэ байдал маань гажуудчихвал ёстой утгагүй байдал руу орно. Жинхэнэ хүний эрх зөрчигдсөн ийм зүйл болох учраас та бүхэн маань яг энэ цэцийн гишүүнээр хэрвээ томилогдоод очвол энэ байдлыг маш яаралтай сахиулах тал дээр, тэнд энэ соёлыг тогтоох тал дээр хамтарч ажиллаасай гэж би бодож байна. Шаардлагатай бол яг энд шаардлагатай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг цаг алдалгүй оруулж ирээд шийдэх хэрэгтэй болов уу гэсэн санал 1 дүгээрт, хэлж байна.

Ер нь зүгээр та бүхэн энэ болж байгаа процессыг харахад энэ цэцтэй холбоотой асуудал дээр ийм хуульд нэг өөрчлөлт оруулчих хэрэгтэй байгаа юм уу эсвэл үүнийг бид засаж энэ асуудлыг чанд сахих асуудал тулгараад байна гэсэн тийм бодол байгаа юу? Энэ дээр нэг хариулт авчихъя гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Хэнээс асуусан юм. Оюунчимэг гишүүн хэнээс асуусан юм. 3 хүнээс яг тодорхой асуулт асуухгүй бол. Хэн нь эхэлж хариулах вэ. Рагчаагийн Батрагчаа 2 номер.

Р.Батрагчаа: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Ер нь аливаа хуулийг хийхэд бол заавал ч үгүй судалгаа хийх хэрэгтэй. Хуулийн

хэрэгжилтийн дүн шинжилгээ зайлшгүй хийх ёстой. Тэр судалгаагаа хийж байж нөгөө хуулийн төслийг боловсруулах асуудал яригддаг. Гэхдээ одоо Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа Үндсэн хуулийн цэцийн болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл явж байгаа. Энэ төсөл дээр үндсэн эрхийн маргаантай асуудал бол зайлшгүй байгаад байгаа. Манайд анх Үндсэн хуулийг батлахдаа 4 асуудлыг Үндсэн хуулийн цэцэд харьяалуулсан байдаг. Үндсэн эрхийн маргаан нь өөрөө энэ дээр яг тийм түрүүний Болдбаатар нэр дэвшигчийн хэлдэг шиг ингэж нэмэлт, өөрчлөлт оруулахаар юм шиг харагдаж байгаа боловч яг хэлэлцэж байгаа тохиолдолд түрүүний миний нөгөө хэлсэн агуулгаар ер нь хууль нь өөрөө шүүхийн хэрэглэсэн хууль нь Үндсэн хуульд нийцсэн үү, үгүй юү гэдэг талаараа энд авч үзвэл зүйтэй байх. Хэрвээ тэгээд үндсэн эрхийн маргаан нь зайлшгүй Үндсэн хууль орох шаардлагатай гэх юм бол энд маш их судалгаа хийж байгаад гаднын улсуудын хуулиар яаж зохицуулсан байна, бас нөгөө олон улсын эрх зүй, практик нь ямар байна гэдгийг нь нарийн судалгааны үндсэн дээр хийж байгаад хэрвээ нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай бол энэ тал дээрээ судалгааны үндсэн дээр шийдэх байх. Баярлалаа.

Г.Занданшатар: 1 номер Бямбадоржийн Болдбаатар.

Б.Болдбаатар: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Оюунчимэг гишүүн бол бас чухал асуудал хөндөж тавьж байна. Тэгэхээр Үндсэн хуулийн цэц бас сүүлийн үед олон нийтийн дунд байгаа ойлголт бас тийм таатай биш маягийн, тийм хандлагууд байгаа.

Тэгэхээр энэ хандлагыг өөрчлөх дээр 2019 онд орсон Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулаад, тэгээд манайд тавигдаж байгаа бодлого, чиглэлийн дагуу Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагаанд баримталж байгаа хуулиуд, энэ дэг журмуудыг бас өөрчлөх шаардлага бол байгаа. Одоо өргөн

баригдсан байгаа хуулиуд бол дэвшилттэй сайн талууд бий л дээ. Энэ дээр бас Үндсэн хуулийн цэцийн хараат бус байдлыг хангах чиглэлээр нэлээн сайн нөхцөлүүдийг тусгасан харагдаж байгаа. Гэвч зарим нэг тал дээрээ бас эргэж харах нэлээн сайн бодож тунгааж, шийдвэр гаргах ийм шаардлага байгаа юм уу гэж харж байгаа юм.

Цэц өөрөө Үндсэн хуульд заасны дагуу зөвхөн Үндсэн хуульд захирагдаж үйл ажиллагаа явуулдаг. Байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байдлаар албан тушаалаа явуулах ёстой. Мөн хувь хүний хувьд, ёс зүйн хувьд хараат бус байдлаараа мэдлэг, ур чадварын хувьд хараат бус байдлаараа үйл ажиллагаа явуулж байх ёстой. Энэ чиглэлээрээ цаашаа цэц хөгжих юм. Цэцийн нэр хүнд улам бэхжиж, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болж чадна гэж үзэж байгаа юм.

Г.Занданшатар: Цэрэнпиллийн Даваасүрэн гишүүн үг хэлж, асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Үндсэн хуулийн цэц гэдэг бол маш хариуцлагатай байгууллага. Энд очсон хүнийг бол ёстой 7 хэмжиж, 1 огтлох ёстой. Би бол адаглаад нэг Их Хуралд дор хаяж нэг удаа суучихсан, Үндсэн хууль батлалцчихсан ийм зиндааны хүмүүс бас очоосой гэж ингэж боддог юм. Тэнд бол бас улс эх орны хувь заяа бий. Их ноцтой байгууллага. Өнгөрсөн хугацаанд бас энэ нь харагдсан.

Залуу байна гэдэг бол мундаг гэсэн үг биш л дээ. Сайхан залуучууд очиж байна гэдэг бол сайн гэсэн үг биш. Ер нь ажлын туршилага амьдралаар чанагдсан байна уу гэдэг чинь л өөрөө харин тэр мундаг сайны бол шалгуур. Тэгж харж бид дүгнэх ёстой. Зүгээр яах вэ одоогийн энэ нэр дэвшиж байгаа 3-аас харахад яах вэ, 2 нь 50-аас дээш насны болсон байна. Цолмон, Болдбаатар 2 бол бас бидний хажууд нэлээн хэдэн жил болчихсон, зүгээр Их Хурлын хууль хэлэлцэх

мэтгэлцээнд оролцоогүй ч гэлээ гэсэн бас нэг арга барил суучихсан, мэдэрсэн байгаа байх. Ер нь бид нар цаашидаа цэцийн гишүүдийг сонгохдоо Их Хуралд бас суусан, үгүй ээ, манай Мөнх-Оргил гээд л хүн энэ тэр Их Хурлаас гараад л явж байна шүү дээ. Бэлэн хүн, манай Сүхбаатар энэ тэр гээд байж л байна. Нэг адаглаад Их Хуралд суучихсан ийм хүмүүс уг нь байх ёстой юм.

Тэгээд би зүгээр та 3-ын хувьд бол дэмжинэ. Тэгэхдээ би сайн мундаг гэдэг дээр бол үг хэлэхгүй. Цаг хугацаа л та нарыг харуулна. Тэгэхдээ очоод өнгөрсөн хугацааны гишүүд шиг тэр цэцийг нэг баллаад тавьчихав. Өнгөрсөн хугацаанд бол цэц Үндсэн хуулийн манаач биш Үндсэн хуулийн самрагч байсан байхгүй юу. Би нэг жишээ хэлэхэд, Үндсэн хуулийн өөрчлөлт хийсэн. Үндсэн хуулиа зарчмыг нь алдагдуулж тайлбарласан. 2016 онд пропорциональ буюу энэ намын жагсаалтыг Үндсэн хуульд байж болохгүй гэсэн дүгнэлт гаргачхаад, тэрийгээ үгүйсгэсэн. Эцсийн шийдвэрээ эргээж харж тэнэгтсэн дээ. Та нар минь ийм л гишүүд байв. Хүн бас нэг бүтэн нүүртэй ажиллах хэрэгтэй.

Тэгээд зарим нь сонгогдож авчхаад ингээд тэнгэрээс өөр юм алга гээд ингээд дураараа загнаад суучихдаг. Тэгэх юм бол энэ улс эх орны хувь заяанд маш эвгүй, тогтворгүй байдал үүсгэж болох газар бол Үндсэн хуулийн цэц. Үндсэн хуулийг та нар янз бүрээр тайлбарлаад өөрчлөөд одоо чинь Үндсэн хуулиа засвар хийсэн хэрэг шүү дээ. Өнгөрсөн цэц чинь. Ингэчих юм бол та нарт арга хэмжээ авч болдоггүй, маш хэцүү. Намын жагсаалт гээж юмыг оруулж өгсөн.

Харин сая азаар Оюун-Эрдэнэ намын дарга бол бас жагсаалтыг салбар, салбарын бас хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг төлөөллүүдийг жагсаалаа. Тэгээгүй 1 зарчимгүй нөхөр байсан бол одоо олон түмэнд нэр нүүрээ барчихсан, сонгогдох боломжгүй болчихсон гарууд жагсчих тийм аюул байгаа юм. Бусад

хөгжсөн төлөвшсөн улс орнуудад элит давхаргаа авч үлддэг систем. Манайд энэ системийг буруугаар ашиглах юм бол хулгайч, луйварчдыг авардаг систем болох ийм аюултай. Ийм зүйлийг өнгөрсөн цэцийн гишүүд маань бол хийсэн. Та нар тийм нүгэл Монголын төрд үйлдэв гэдгийг л би эцэст нь захъя.

Тэгэхээр нүгэл бага үйлдээрэй, төрдөө буян сайн хийгээрэй л гэж захъя.

Г.Занданшатар: Үг хэллээ. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Манай Цэц бол үнэхээр хариуцлагагүй, хэн нэгний нөлөөнд автдаг ийм байгууллага болж хувирсан. Эрх баригчдын дохио, зангаагаар хэн нэгэн гишүүний дохио зангаагаар, хэн нэгэн албан тушаалтны дохио зангаагаар шийдвэр гаргадаг болсон. Түүний нэг бол хуурамч шатахууны хууль байгаа. Өөрөөр хэлбэл, энэ хуурамч шатахууны хуулиар Монголын ард түмний эд хөрөнгө, эрүүл мэндийг хохироодог ийм байдлыг зогсоож би 2021 оны 7 сард энэ хуулийг гаргасан. Гэтэл 23 оны 6 сард Үндсэн хуулийн цэц нөгөө 3 компани хууль бус үйлдлээ хийхийн тулд миний хуулийг цэцэд өгсөн байгаа юм. Цэц өөрт нь ямар ч хамааралгүй асуудлаар энэ хуулийг хүчингүй болгох ийм шийдвэр гаргасан. Энд бол авлига, хээл хахууль явсан. Би баталгаатай мэдэж байгаа. Энэ бол үнэхээр засах замбараагүй зүйл.

Тэгээд энэ хуурамч шатахуунд хольдог хольц дээр татвар авах нь буруу гэж байгаа юм. Үгүй ээ, тэгээд тэд нар жишээ нь бүх бараа гаалийн татвар 5 хувьтай байдаг. Гэтэл ард түмний гурил өндөр байж байхад, 15 хувийн татвартай байж байхад, тэрийг буулгах талаар цэцийн дүгнэлт гаргаагүй шүү дээ. Ард түмний төлөө юм болох дээр ерөөсөө шийдвэр гаргадаггүй, зүгээр л өөрт нь хэрэгтэй, өөрт нь шан харамж амласан тохиолдолд дураараа шийдвэр гаргадаг ийм зүйлийг хийсэн байхгүй юу даа.

Тэгэхээр энэ явдлыг зогсоож манай Болдбаатар хуульч маань тэнд очно гэж очиж байгаа. Би ийм замбараагүй, ийм ашиг сонирхолд хөтлөгдсөн, хэн нэгэн даргын дохио зангаагаар хийгдсэн ийм ажил манай Болдбаатар огт хийхгүй, сайн хуульч учраас, хуулийн өндөр мэдлэгтэй учраас ийм ажлыг ерөөсөө хийхгүй.

Дээрээс нь гадаадад дипломатын ажил хийж байсан. Энэ Үндсэн хуулийн цэц гэдэг чинь тусгаар тогтнолыг хамгаалж байдаг ийм байгууллага байхгүй юу даа. Тэгэхээр энэ гадаад, дотоод нөхцөлөө мэдэж, тэнд тодорхой ямар ямар нөлөө, гадаад нөлөө байна гэдгийг харж шийдвэрлэнэ гэдэг чинь бас тодорхой хэмжээний энэ шийдвэр гаргахад нь томоохон нөлөө үзүүлнэ.

Тэгээд хууль тогтоох байгууллагад бас 4 жилийн туршид энэ хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаа яаж явдаг, ямархуу шийдвэр гаргадаг, ямар процедуртай гэдгийг бүгдийг нь сайн мэддэг хүний хувьд бол тэр Үндсэн хуулийн цэц дээр шийдвэр гаргахад бол нэлээн өндөр ур чадвартай ажиллаж чадна л гэж би харж байгаа.

Тийм учраас энэ Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилогдож байгаа Болдбаатарт энэ Үндсэн хуулийнхаа манаач сайн байгаарай, хариуцлагатай, сайн ажиллаарай. Тэгээд бас олон олон хүмүүсийн итгэл найдварыг алдахгүйгээр ажиллаарай гэж хүсэх байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Пүрэвдорж гишүүн үг хэллээ.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Тэгээд энэ таширамд нэг юм онцлон тэмдэглэхэд үндсэн эрхийн маргааныг Үндсэн хуулийн цэц хэлэлцэх асуудал нь бол онолын хувьд маргаантай боловч хамгийн гол нь тэр do frocess буюу энэ хуулийн хэм хэмжээ, шаардлагыг ягштал мөрдөж, процессын хуулийг дагаж

мөрдсөн эсэх дээр олон улсад ер нь нийтлэг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэдэг практик сүүлийн үед тогтоож байгаа. Тэгээд do frocess гэдэг дээр нэг юм хэлэх гээд байгаа нь өмнө Амарсанаа академичийг цэцээс татах процесс бол алдаатай болсон. Үүгээр бол Амарсанаа академичийн нэр хүнд эргэж сэргэх ёстой. Жишээлбэл процессын алдааны хувьд ч тэр, эргүүлж татах Дээд шүүхийн танхимын хуралдаанаар буцааж татдаг байсан асуудлыг. Энэ талаар бол Учрал гишүүн тогтоолын төсөл санаачилсан байгаа.

Тэгээд үүнийг бас цэцийн гишүүдийн бие даасан хараат бус байдалтай холбоотой учраас үүнийг бас цаашидаа ер нь анхаарч байх зүйтэй юм байна лээ. Цэцийн тухай хууль дээр ч гэсэн энэ тодорхой тусаж байгаа. Шинэчилсэн найруулга дээр.

Ингээд санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар нууц санал хураалт явуулна.

Цэдэвийн Цолмонг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт болно.

Гишүүд суудалдаа сууя. Учрал гишүүн тогтоолын төсөл чинь өргөн баригдчихсан байгаа шүү. Тэгээд 1 цагаас Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан дээр нь цэцийн асуудалтай холбоод нэмээд хариулчих.

Энэ ингээд хамгийн эхний санал хураалт учраас туршилтын санал хураалт явуулна. Нууц туршилтын санал хураалт явуулна.

Одоо санал хураалт явуулна.

Цэдэвийн Цолмонг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна.

28 гишүүн дэмжиж, 68,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Бямбадоржийн Болдбаатарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулъя. Санал хураалт.

28 гишүүн дэмжиж, 68,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Рагчаагийн Батрагчааг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт.

Санал хураалт дэмжигдлээ. 68,3 сарын саналаар.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Тогтоолыг уншиж танилцуулна.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай. Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын санал болгосноор Цэдэвийн Цолмонг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Шилаагарьдын

Солонгыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

Энэ тогтоолыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Бямбадоржийн Болдбаатарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Батсүхийн Баяндэлгэрийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

Энэ тогтоолыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай. Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн

102.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Рагчаагийн Батрагчааг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2. Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Гомбожавын Туулхүүг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

3. Энэ тогтоолыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилогдсон Цэдэвийн Сэргэлэн, Бямбадоржийн Болдбаатар, Рагчаагийн Батрагчаа нарт ажлын өндөр амжилт хүсье.

Та бүхэн Үндсэн хуульд ёсыг дээдлэх, бие даасан, хараат бус үйл ажиллагаа явж Үндсэн хуулийн манаач, сахин хамгаалах үүргээ нэр төртэй гүйцэтгэж, Монгол Улсын парламентын ардчилал, хүний эрхийг хамгаалах хуульчийн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэнэ гэдэгт итгэж байна. Та бүхний ажилд өндөр амжилт хүсье.

12.09 цаг

Дараагийн асуудалд орно.

Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгугийн Содбаатар танилцуулна.

Индэрт урьж байна. Зөвшилцөх талаар танилцуулга хийнэ.

Я.Содбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 17 дахь хэсэг, Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Очирсүхийн Машбатыг Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчоор томилох асуудлыг зөвшилцөхөөр Улсын Их Хуралд санал болгон Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулж байна.

Цагаан овогтой Очирсүхийн Машбат нь 1981 онд Дорноговь аймагт төрсөн, 43 настай, ам бүл 5.

Машбат нь 1998 онд Дорноговь аймгийн ЕБС, 2002 онд Чингис хааны нэрэмжит Их засаг их сургуулийн эрх зүйч мэргэжлээр, 2005 онд Их засаг сургуульд Хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. 2005 онд Санхүү, эдийн засгийн их сургуулийг Бизнесийн удирдлагаар, 2007 онд АНУ-ын Колорадогийн их сургуульд суралцаж, Эрүүгийн эрх зүйд суурилсан шинжлэх ухааны удирдлагын магистрын зэрэг хамгаалсан.

Машбат нь 2003-2005 онд Улсын Их Хурлын Тамгын газарт туслах ажилтнаар, 2008-2009 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газарт мэргэжилтнээр, 2009-2013 онд НЗДТГ-т Хууль зүйн хэлтсийн даргаар, 2015-2017 онд Улсын ерөнхий прокурорын газарт хяналтын прокурор, 2017-2019 онд Нийслэлийн прокурорын газарт хэлтсийн дарга, ахлах прокурор, 2019-2020 онд Улсын ерөнхий прокурорын газарт Тамгын хэлтсийн дарга, ахлах прокуророор ажилласан. 2020 оноос ЗГХЭГ-ын Шадар сайдын зөвлөх, 2021 оноос Ерөнхийлөгчийн Тамгын газарт Хуулийн бодлогын газрын даргаар ажиллаж байгаад 2024 оны 01 сарын 01-нээс Улсын ерөнхий прокурорын газрын

Хэрэг эрхлэх газрын дэд дарга ахлах прокуророор ажиллаж байна.

2004 онд хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцэж, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ авсан. Хуульч мэргэжлээр 20 жил ажиллаж байгаа ийм боловсон хүчин байна.

Машибат нь Прокурорын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4-д хуульч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, 35 насанд хүрсэн прокурорыг Улсын ерөнхий прокурор түүний орлогчоор томилно гэсэн шаардлагыг бүрэн хангаж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Очирсүхийн Машибатыг Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд томилох асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт заасны дагуу зөвшилцөхөөр хүргүүлж байгаа тул хууль тогтоомжид заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд томилох асуудлыг Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн Очирсүхийн Машибатыг Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд томилох асуудлыг зөвшилцөх тухай саналыг хэлэлцсэн бөгөөд

хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд томилох асуудлыг зөвшилцөх саналын талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Чуулганы танхимд нэр дэвшигч Очирсүхийн Машибат хүрэлцэн ирсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж, түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнээр тасаллаа.

Чимэдийн Хүрэлбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ч.Хүрэлбаатар: Нэр дэвшигч орж ирж байгаа, амжилт хүсье. Би нэг зүйлийг л ярьж гэж бодож байна.

Өчигдөр сошиалаар бас мэдээнүүд явсан. Өнөөдөр бас үргэлжлээд явж байна. Монполимет компанийн захирал Гарамжав гэдэг хүнийг баривчилсан гэдэг ийм асуудал бол сошиалаар явж байна л даа. Тэгээд бодвол бариад хорьсон байх шиг байна. Би бол энэ Эдийн засаг хөгжлийн сайд.

Тэгэхээр эдийн засагт бол яах аргагүй энэ манай хувийн хэвшлийнхний оруулдаг үүрэг бол асар их байдаг. ДНБ-ий 80 орчим хувийг манай хувийн хэвшлийнхэн үйлдвэрлэдэг юм байгаа юм. Тэгээд гаргаж байгаа мэдээг нь үзвэл Хөгжлийн банктай холбоотой асуудлуудаар хорьж байгаа юм шиг, баривчилсан юм шиг ийм юм явагдаад байна л даа. Хөгжлийн банкны хэргийг шалгаад, сонсгол болоод, бүх юмнууд нь

дуусчихсан байгаа болов уу гэж би бодож байгаа юм.

Тэгээд яагаад ийм зүйлийг хийгддэг юм бэ гэдэг дээр олон нийт эргэлзэж гайхаж байгаа. Тэр тусмаа сонгуулийн, зарлачихсан, явагдаж байгаа үед, элдэв бусаар гүтгэх, хий хоосон юманд холбогдуулж, нэр төрийг нь гутаах ийм ажлуудыг идэвхтэй хийхийн хажуугаар бизнесүүдийг ингэж яг сонгуулийн өмнөхөн, тэр тусмаа Улсын Их Хурлын гишүүн байсан хүнийг ингэж хорьж байгаад би гайхаад байна л даа.

Тэгэхээр би Машибатыг бол ийм юм хийсэн гэж байгаа юм биш. Зүгээр ийм нөхцөл байдалд прокурор хүний хувьд ямар байр суурь барих нь зөв бэ гэдгийг асууж тодруулмаар байгаа юм.

Хөгжлийн банкттай холбоотой юм бол тэр асуудлыг ярьж байх үед нь тэр асуудлаа цэгцлээд, нэг талдаа гаргаад явчих ёстой шүү дээ. Одоо огт холбоогүй цаг үе дээр нь тэр тусмаа сонгууль дөхчихсөн байгаа ийм үед үүнийг бол улс төрийн акц гэж үзэхээс өөр аргагүй болоод байна шүү дээ.

Тийм учраас яагаад ийм зүйл хийгдэж байгаа юм. Тэгэхээр энд хувь хүнийхээ хувьд юу гэж үзэж байгаа вэ, энэ албан тушаал дээр. Яагаад гэвэл өөрийг чинь прокурорын орлогч болгох гэж байгаа үед, ийм үед энэ хүн ямар байр суурьтай байх бол гээд Улсын Их Хурлын гишүүд өөрийг чинь харж байгаа болов уу гэж бодож байна. Тэгэхээр өөрийн чинь зөв байр суурийг нь сонсьё.

Г.Занданшатар: Нэр дэвшигч хариулах юм уу? Содбаатар дарга хариулах юм уу? Содбаатар дарга хариулах юм уу. 3 номер Содбаатар дарга. Янгугийн Содбаатар Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга.

Я.Содбаатар: Хүрэлбаатар гишүүний асуултад хариулъя. Одоо энэ асуудал бол нөгөө хуулийнхны, хууль хүчний байгууллагуудын ажил учраас энд

бид нар тодорхой зүйлийг хэлэхэд боломжгүй. Хуулийн дагуу аливаа хууль, хүчний байгууллагууд танилтай санал нэг байна. Зөвхөн хууль дээдэлж, хуулийн хүрээнд ажиллах ёстой. Тэр тусмаа хууль хүчний байгууллагуудын үйл ажиллагаанд ямар нэгэн улс төрийн болон бусад нөлөөлөл оролцох ёсгүй. Мөн хэн нэгэн албан тушаалтанд бас нөлөөлөлд оролцох ёсгүй. Тэр агуулгаараа бол хуулийн дагуу энэ процесс явж байгаа байх гэж ингэж бодож байна.

Ер нь бол бизнес эрхлэгчид, аж ахуй эрхэлж байгаа хүмүүсээ дэмжих ёстой. Болж өгвөл эд нарыг хуулийн хүрээнд ажиллаж байгаа хүмүүсээ дэмжиж, хөрөнгө оруулалтыг дэмжих ёстой гэдэг ийм байр суурьтай бол санал нэг байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Энэ прокурорын зөвшөөрөлтэй баривчилсан юм уу, зөвшөөрөлгүй баривчилсан юм уу гэж асуусан л даа. 4 номерын нэр дэвшигч.

О.Машибат: Хүрэлбаатар гишүүний асуултад хариулъя. Би бас хэвлэлээр ийм мэдээллийг харсан байгаа. Яг одоо аливаа мөрдөн шалгах ажиллагаанд тухайн одоо юу гэдэг юм мөрдөгч, хяналт тавьж байгаа прокурорууд ингэж оролцож, тухайн ажиллагааг хариуцаж ингэж ажилладаг.

Миний хувьд энэ талаар яг тодорхой мэдээлэл алга байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Асуулт, нөгөө хуульчийн хувьд мэдээлэл үйлчилж нөгөө Хөгжлийн банкны асуудал 2 шатын шүүхээр шийдвэрлэгдээд, сонсгол хийгдээд шийдэгдчихсэн. Тэгтэл тэр асуудлаар

О.Машибат: Хөгжлийн банкны асуудлаар миний авсан мэдээллээр Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатын шүүх шийдвэр гаргасан. Үүний дараа хэргийн оролцогч нар бол тэдгээрийн өмгөөлөгч нар Улсын дээд

шүүхэд гомдол гаргасан байгаа гэж ингэж ойлгосон ийм мэдээлэлтэй байгаа.

Би хуульчийн хувьд прокурорын байгууллага Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд заасан зохицуулалтын үндсэн дээр үйл ажиллагаа нь явдаг. 56.1 дээр бол прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно гэсэн ийм зохицуулалттай. Мөн Прокурорын тухай хууль болон Эрүүгийн, Зөрчлийн хууль тогтоомжоор прокурорын чиг үүргүүдийг илүү нарийвчилж тодорхойлж өгсөн байгаа. Би хуульчийнхаа хувьд хууль тогтоомжийг чанд мөрдөж, хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллана гэсэн ийм бодол, байр суурьтай байна.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар гишүүн тодруулж асууна. Гол нь нөгөө хувийн хэвшлийг ингээд байршуулж ороод байдаг нь зөв юм уу л, бизнес хийсний төлөө гэсэн асуулт. Чимэдийн Хүрэлбаатар гишүүн.

Ч.Хүрэлбаатар: Машбатын тайлбарт бол болж байна. Ер нь бол цаашдаа энэ прокурорын орлогчоор болсон тохиолдолд, томилогдсон тохиолдолд нэг зүйлийг их анхаарч ажиллах ёстой. Юу гэвэл ковидын 2 жил ингээд 2 хүнд жилийн дараа эдийн засаг өсөж байгаа. Энэ эдийн засгийн өсөлтийг чинь манай хувийн хэвшлийнхэн маш их хэмжээгээр бий болгож байгаа.

Тэгэхээр хувийн хэвшлийнхэн, тэр тусмаа Монгол Улсад ихээхэн хэмжээний бүтээн байгуулалтуудыг хийчихсэн энэ хувийн хэвшлийнхэнд хүндэтгэлтэй хандаарай. Заавал хорихгүйгээр тэр шалгадаг зүйлээ шалгаад, явчхаж болдоггүй юм уу. Хорьж байгаад, айлгаж байгаад гэдэг чинь төрийн дарамт ирүүлээд байгаа юм шиг харагдаад байна шүү дээ.

Эдийн засгийн өсөлтөд төрийн дарамт ерөөсөө огтхон хэрэггүй шүү. Аль

болохоор чөлөөтэй хориг, саад багатай байж байж, Монгол Улсын эдийн засаг хөгжинө. Эдийн засаг хөгжиж байж, ажлын байр бий болно, ажлын байр бий болж байж Монгол Улсын ард иргэдийн орлого нэмэгдэнэ.

Ийм учраас бид нар энэ хувийн хэвшил, эдийн засаг руугаа нэлээд сайн анхааралтай хандаж явахгүй бол болохгүй шүү гэдгийг би хэлье. Тэгээд Машбатад амжилт хүсье. Тэгээд энэ ялангуяа энэ хувийн хэвшлийнхэн дээр хандаж байгаа хандлага, эд нарыг бол бүх талдаа жосоохон өөрчлөхөд бас өөрийнхөө хувь нэмрийг оруулж ажиллаарай гэдэг үгийг хэлье.

Г.Занданшатар: Эдийн засгийн хөгжлийн сайдын хувьд бас. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн алга байна, хаслаа.

Дамдины Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Би өчигдөр манай Байнгын хороогоор энэ нэр дэвшигчийн асуудал ороод дэмжигдээд гарахад нэг зүйлийг хэлсэн. Юу гэвэл прокурорын байгууллага мэдээжийн хэрэг хэргийг хянан шалгах ажлыг хянаж явуулж байгаа. Гэхдээ ингэхдээ хүний эрхийг дээдэлж, хүний эрх талаас нь асуудалд хандаж явах ёстой шүү гэдгийг би онцолж хэлсэн байгаа.

Тэгээд сая энд Хүрэлбаатар гишүүн ч, Улсын Их Хурлын дарга ч энэ ярьж байгаа асуудал дээр мэдээж би Хууль зүйн байнгын хорооны даргын хувьд аливаа тухайлсан хэрэг дээр тухайн хүний асуудал дээр ямар нэгэн байр суурь хэлэхгүй. Гэхдээ заавал барьж ажиллах нэг зарчим юу гэвэл, энэ хүний эрхийг дээдлэх тал дээрээ бол аливаа барьж, хорих үйл ажиллагаа явж байгаа бол зайлшгүй шаардлагатай, хатуу үндэслэлтэй ийм л алхмуудыг хийж байх ёстой шүү. Би энэ дээр тэгээд тэр нь бизнесийн хүн байна уу, эрэгтэй хүн байна уу, эмэгтэй хүн байна уу, эх орныг хамгаалагч байна уу, эмч байна уу тэр нь

ерөөсөө хамаагүй. Монгол Улсын иргэн хүн Үндсэн хуулиараа үндсэн эрхүүд нь хамгаалагдсан байдаг гэдгийг анхаарч ажиллах ёстой гэдгийг нэг хэлмээр байна.

2 дугаарт, аливаа хуулиар давж болохгүй гээд заачихсан байгаа, аливаа тэр шалгууруудыг давж болохгүй л бол, тэр шалгуур хангагдаагүй л бол, хэзээ ч давдаггүй байх ёстой. Тэгэхээр энэ баривчлах асуудал дээр ер нь хорьж саатуулах асуудал дээр бол бид нар Улсын Их Хурал дээр сая хэд хэдэн хууль дээр бодлого яаж гарч байна гэхээр аль болох барьж хорихгүйгээр тийм зайлиггүй шаардлага байхгүй бол барьж хорихгүйгээр энэ асуудлуудаа шийдэж бай. Ялангуяа жишээлбэл хорих санкцгүй тийм зүйл ангиар шалгагдаж байгаа хүнийг бол бүүр хорьж барихгүй байхаар энэ хуулиудыг нь бид нар гаргаад өгч байгаа шүү дээ.

Тэгэхээр хуулийн бодлого чинь ингээд өөрчлөгдчихсөн байгаа, энэ бодлогыг барьж ажиллаж байгаарай гэдгийг бас захиж хэлмээр байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал, үг хэлсэн, тийм ээ. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Ерөнхий прокурорын орлогчид нэр дэвшээд орж ирж байгаа Машибатыг дэмжиж байна. Мөн түүх намтрыг нь уншихад яг л ийм мерит зарчмаар багаас нь ингэж яваад байдаг, энэ салбарынхаа бүх түвшинд л ингээд доороос нь ажиллаад өнөөдөр ингээд прокурорын орлогчоор нэр дэвшээд орж ирж байгаа юм байна.

Би бас энэ асуудлыг хөндөх гэсэн юм. Би Гарамжав гишүүн асан, хуучин гишүүн байсан, уг нь мэднэ л дээ. Аливаа асуудалд зарим нэг бизнесийн салбараас орж ирсэн хүмүүс чинь хувийн бизнесээ бодоод л гүйчихдэг. Энэ хүн бол тэгдэггүй. Аливаа юманд тийм улс эх орноо хандаж асуудалд ханддаг байсан Эдийн засгийн байнгын хорооны гишүүн бид нар хамт байсан л даа.

Тэгээд өнөөдөр Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбоо болон Монголын бизнесийн салбарынхан тэр чигээрээ л 1-д айж байх шиг байна, 2-т гайхаж байх шиг байна. Хэрвээ Хөгжлийн банктай холбоотой асуудал бол Хөгжлийн банкны тэр төгрөг, долларын харьцаанаас асар их алдагдал хүлээсэн цөөхөн хүмүүсийн нэг нь энэ Гарамжав Монполимет компани юм байна лээ шүү дээ. Гэхдээ цементийн үйлдвэрээ барьчихсан. Тэгээд энэ Хөгжлийн банкны энэ их өр, зээлийг буцааж төлсөн хоёрхон хүн байдаг юм байна лээ. Тэр нь хэн гэхээр 1-д Гарамжав, 2-т Билэгт энэ 2 эмэгтэй л нөгөө буцааж төлөөд ингээд явж байгаа юм байна лээ шүү дээ. Хүү, өргүй. Гэтэл зарим нь юун төлөх битгий хэл, өнөөдөр бүр ингээд цайрчихсан хүмүүс байна. Яагаад энэ хүмүүсийг тэгвэл ингэж барьж, хорьж шалгадаггүй юм бол. Эмэгтэй хүнд хатуу байна уу даа. Ер нь энэ аль аль салбар дээр хараад байхад манай Монголын энэ нийгэм дээр улс төр дээр ч, бизнес дээр ч, арай л эмэгтэй хүнд нэг хатуу дээрэнгүй хандаад байх шиг байх юм. Энэ ямар учиртай гэдгийг нь би мэдэхгүй. Яагаад энэ хүнийг тэгж шууд барьж хорих, тийм том ноцтой ямар шалтгаан байсан юм бол оо? Гадуур шалгачхаж болоогүй юм болов уу? 60 нас гарч байгаа. Тэгээд тийм гэмт хэрэг үйлдчихээр хүн биш баймаар юм. Тэгээд энэ бүхнийг бид нар эргэж харах ёстой юм болов уу гэж би бодож байна.

Энэ өөрөө эргээд нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино гэдэг шиг мянга мянган бизнес хийж байгаа хувийн хэвшлийнхэн, үгүй ээ нэг өдөр бид нарыг бас ингэчих вий гэсэн энд айдаст автуулж байна шүү дээ. Энэ нь юу юм гэхээр яагаад гэдэг шалтгааныг нь мэдэхгүй. Тайлбарлаж байгаа тэр АТГ-ын хүн нь Хөгжлийн банк болон зарим юм ярихаар хүмүүс сүүлдээ үгүй ээ, тэгвэл тийм ээ, яагаад ялгаад байгаа юм. Үүнийг яагаад авахгүй, үүнийг яагаад ингэж байгаа юм гээд ийм нийгэмд хүний эрхийн зөрчил үүсгээд, ялгаварлал үүсгээд байгаа нь өөрөө бас ноцтой үр дагавартай учраас үүнийг манай хууль, хүчний

байгууллагынхан маань анхаараасай гэж 1-д, хэлмээр байна.

2-т нь, энэ байдал бас юунаас үүсээд байна гэхээр өмнө нь нөгөө хууль, хүчний байгууллагуудын тэр хэрэг тавьж, хэргийг яаж шүүж байгаа энэ тэр дээр нь прокурорын байгууллага өөрөө хяналт тавиад явчихдаг тэр тогтолцоо механизм байсныг аваад хаячихсан шүү дээ. Тэгэхээр та хэрвээ Монгол Улсын прокурорын орлогчоор эндээс зөвшөөрөгдөөд нэр дэвшээд яваад очвол энэ прокурорын байгууллага, хууль хүчнийхэндээ хяналт тавьдаг энэ тогтолцоог буцаагаад сэргээх энэ зөв гэсэн бодол танд байгаа болов уу? Ер нь энэ нэг тийм юм байхгүй бол ер нь нээрээ үнэхээр тэр их үнэн байна уу, алдаатай байна уу, хүний эрх зөрчиж байна уу, эсвэл үнэхээр гэмт хэрэгтнийг хамгаалаад байна уу гээд энэ дээр хуучин бол тэр прокурорын байгууллага хяналт тавьдаг байхад бас өөр байсан шүү дээ. Манай прокурорынхон чинь бас энэ ингэж байна, энд хүний эрх зөрчсөн байна, энэ дээр ийм байна гээд асуудалд бол өөр хандлага байсан. Одоо тэгэхээр ямар ч ийм хяналт байхгүй болчихоод байгаа нь өөрөө асуудлыг сөрөг үр дагавар дагуулах эрсдэл үүсгэж байгаа юм.

Тэгэхээр та энэ дээр хэрвээ дэмжигдээд явбал энэ прокурорын байгууллага хяналт тавьдаг тогтолцоог буцаагаад сэргээх тал дээр хуульд өөрчлөлт оруулаад оруулж ирэх ч юм уу, энэ ер нь зөв байгаа юм уу гэсэн энэ дээр таны байр суурийг 1-д, сонсмоор байна.

2-т, тэр асуудал тал дээр, эргэж нэг харах тал дээр, ер нь хаанаа яах ёстой байдаг юм бол оо, манай энэ байгууллагууд. Гадуур шалгаад яаж болохгүй байгаа юм болов уу? Тийм ноцтой юм болоод байгаа юм болов уу? Энэ зөв мэдээлэл нийгэмд өгөх хэрэгтэй байна гэдгийг би бас хэлмээр байна.

Г.Занданшатар: 4 номер
Машибат.

О.Машибат: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Түрүүний асуудал дээр бол би бас өөрийнхөө хариуг бас өгчихсөн гэж ойлгож байна.

2 дахь асуудлын тухайд тогтолцоо гэж та хэллээ. Зүгээр миний ойлгож байгаагаар прокурорын мөрдөн Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн шалгах алба гэж байсан. Тэр талаар одоо таныг саналаа хэлж байна гэж ингэж ойлгож байна. 2002 онд бол энэ тухайн үеийн Эрүүгийн хууль, Иргэний хууль, прокурорын, шүүхийн маш олон хуулийн шинэчлэлийг хийсэн байдаг. Тэгэхэд 2002 оны Прокурорын байгууллагын хууль гэж байсан. Тэр хууль дээр бол Прокурорын мөрдөн шалгах, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн шалгах алба гэдгийг ажиллуулж байгаад, 2014 онд Улсын Их Хурлаас хууль өөрчлөөд, хуулийн тэр холбогдох зүйл, заалтыг хүчингүй болгоод, прокурорын мөрдөнгийн хариуцаж байсан чиг үүргийг АТГ-т, ахуйн үйлдэлтэй холбоотой асуудлыг ЦЕГ-ын мөрдөн байцаах албаны тусгай субъектийн гэмт хэрэг мөрдөх хэлтэс рүү ингээд шилжүүлсэн байгаа. Энэ үйл ажиллагаа бол ингээд явж байгаа.

Зүгээр яг хууль өөрчлөгдөх эсэхийг би хэлж мэдэхгүй байна. Энэ бол хууль санаачлагч Улсын Их Хурал, Засгийн газар, цаашид Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн асуудал гэж ингэж ойлгож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Гишүүд холбогдох асуудлын талаар бүрэн эрхийнхээ хүрээнд холбогдох байгууллага, прокурорын газарт холбогдох байгууллагад асуудал тавьж, өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлж болно гэсэн хуультай. Тэр дагуу л хариулах ёстой байхгүй юу даа. Томилогдоогүй байгаа учраас.

Ингээд Байнгын хорооны саналаар Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох асуудлаар нууц санал хураана.

Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчоор Очирсүхийн Машбатыг томилох саналыг дэмжэе гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд суудалдаа. Санал хураалт.

62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчид санал хураалтын дүнг албан бичгээр хүргүүлэх болно.

12.30 цаг

Дараагийн асуудалд орно.

Одоо Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн Саранчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Саранчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мэдээлэл, технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын гишүүн Учрал Мэдээлэл, технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиар төрийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн Үндэсний зөвлөл, мэдээллийн технологийн компаниудыг тодорхой шалгуураар виртуал бүсэд буюу цахим орчинд бүртгэх, тэдгээрт татварын

болон татварын бус дэмжлэгээр зах зээлд гарах нөхцөлийг бүрдүүлэх зориулалтыг тусгасан.

Цаашид татварын болон татварын бус хөнгөлөлтөд тавигдах шалгуурыг төсвийн хуультай уялдуулах, виртуал бүсэд ажиллах журамд Засгийн газар шалгуурыг тодорхой тусгаж өгөх талаар, Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн хуулийн төсөлд тусгагдсан татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбогдуулан хуулийн цоорхой үүсэхээс сэргийлэх талаар нарийвчилсан зохицуулалтын журмыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Сангийн яам хамтран боловсруулах талаар тус тус санал хэлсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн бодлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж,

асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Мэдээлэл, технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжжүүлээ.

Учрал сайд аа, Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийн хуулийг эцэслэн батлахад өнөөдөр ирцээ бүрдвэл 39 гишүүнээр дэмжиж, эцэслэн батална шүү.

12.35 цаг

Дараагийн асуудалд орно.

Дараагийн асуудалд орохын өмнө нэг нийтэд мэдээлэх зүйл байна. Нийт Улсын Их Хурлын гишүүдэд. Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулган сонгуулийн ээлжит чуулгантай холбогдуулан завсарлах болно. Ирэх 7 хоногт. Тэгээд энэ хүртэл хугацаанд Засгийн газрын нэн яаралтай горимоор өргөн мэдүүлснээс бусад аливаа хуулийн төсөл, тогтоолын төслийг хүлээж авахгүй болсныг үүгээр мэдэгдэж байна.

Сонгуулийн сүүлийн юу жил дөхсөн жил 7 хоногийн хугацаанд хууль ахиад өргөн бариад хэлэлцэн батлах боломжгүй. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай шинэ хууль хүчин төгөлдөр болж мөрдөгдөхөд бүх асуудал шинээр эхэлнэ.

Ийм учраас хууль, тогтоолын төсөл хүлээж авахгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

12.35 цаг

Дараагийн асуудалд орно.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл

болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүн Батжаргал нарын 38 гишүүнээс 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж ажлын хэсгийн гишүүд үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасныг баримтлан 1 саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дэмжлээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусгах нь төслийн агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд болон Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Малчин өрхийн эрх зүйн байдлын тухай хууль хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын тоо, толгойн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хориооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж, асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулчихъя. Протоколд тэмдэглэж үлдээх зорилгоор.

Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Энхбаатарын Цолмонжаргал тус яамны Хуулийн хэлтсийн дарга, Цэвэгнямын Мөнхнасан тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Мал аж ахуйн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн, Аюурзанын Энх-Амгалан Бодлого судлалын төвийн тэргүүн.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрөөтэй 1 санал байгаа.

Гишүүд чуулганы танхимд цуглана.

Энэ Болорчулуун гишүүн санаачилсан биш гишүүд санаачилсан хууль л даа. Батжаргал нарын гишүүд.

Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжсэн санал.

1. Төслийн 2 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“52.2.Бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр гэсэн ерөнхий хуваарийн дагуу ашиглана. Отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр, уст цэг, хужир мараа бүхий бэлчээрийг нийтээр ашиглана. Бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээрийн даацыг харгалзан, багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг

үндэслэн сумын Засаг дарга Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээний дагуу ашиглуулж болно.” Санал гаргасан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо. Санал хураалт явуулна.

Энэ Боловсрол, шинжлэх ухааны байнгын хороо хуралдаж байгаа. Санал хураалт явуулах шаардлага давхцаж байгаа учраас санал хураалтыг түр хойшлууллаа.

Боловсрол, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдааны дараа санал хураалтыг явуулна.

12.40 цаг

Дараагийн асуудалд орно.

Энэ хууль татан авах тухай төсөл танилцуулъя. Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа. Хуулийн төсөл эргүүлэн татах тухай.

Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн нарын 4 гишүүн санаачилсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн агуулга, үзэл баримтлал нь тухайн хуулиудын шинэчилсэн найруулгад тусгагдсан тул эдгээр хуулиудыг эргүүлэн татаж болохыг мэдэгдэж байна гэсэн байна.

Ингээд Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эргүүлэн татсанд тооцлоо. /12:41/

Дараагийн асуудалд орно.

Гишүүд өнөөдөр чуулганы хуралдаандаа тогтвортой сууж, сунгаж хуралдана. 23 асуудал байгаа.

Мөнхбаатар дарга, Тогтохсүрэн дарга нар гишүүдийг өнөөдөр хуваарь гаргаж байгаад яг суулгаж, орой хүртэл нэлээн суулгаж, юмнуудаа явуулах ёстой шүү.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Н.Учрал, Д.Цогтбаатар нарын гишүүд 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэх эсэхийг 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 84 дүгээр захирамжаар хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Мөнхбаатар, Оюунчимэг, Б.Энх-Амгалан нар болон холбогдох албан тушаалтнууд ажиллалаа.

Байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ.

Ажлын хэсэг шүүх хуралдааны нээлттэй ил тод байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар олон нийт үнэн бодит мэдээллийг авах боломжийг тэгш хангах зарчмыг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байгаа нууцын холбогдох хууль тогтоомжийг шүүхийн шатад хэрхэн зохицуулах талаар, төрийн нууцад хамаарах болон өсвөр насны яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн хууль ёсны эрх ашгийг хөндөгдөхөөс бусад шүүхийн хэлэлцүүлэг шүүх хуралдаан нээлттэй байх, иргэд нээлттэй хуралдааныг хөндлөнгөөс ажиглах зорилгоор шүүх хуралдаанд оролцох дэг журмыг баримтлан шүүх хуралдааны танхимд чөлөөтэй нэвтрэн орох боломж олгох зэргийг 31 зарчмын зөрөөтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж зарчмын зөрөөтэй 1 санал гаргасан бөгөөд Байнгын хорооны хуралд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн гаргасан 1 зарчмын зөрөөтэй саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Н.Учрал нар хуулийн төсөл болон зарчмын зөрөөтэй саналын томъёололтой холбогдуулан асууж, хариулт авсан болно.

Байнгын хороо хуулийн энэ төслүүдийг зүйл бүрээр нь болон зарчмын

зөрөөтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд олонхын санал авсан зарчмын зөрөөтэй саналын томъёолол болон хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрөөтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Батаагийн Батцэрэн Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын шүүгч, Лхагвадоржийн Энхбилэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Навагчамбын Баасанжав Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Нямсүрэнгийн Мөнгөнцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Содномцэрэнгийн Заяадэлгэр Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга, Баатарсүрэнгийн Оюунгэрэл Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хуулийн хэлтсийн дарга, Жаргалсайханы Амгалан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байгаа.

Одоо байнгын хорооны гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор энэ чинь. Одоо Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Санал хураалтад гишүүд.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Санал асуулт байхгүй.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрөөтэй 33 санал байгаа. Энэ олон санал дотор бол бас санал зөрөлдөөнтэй асуудлууд нэлээн байгаа гэж байгаа.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо хуралдаж байгаа учраас санал хураалтыг хойшлууллаа.

12.47 цаг

Дараагийн асуудалд. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Санал хураалт болохоор дуудна.

Дараагийн асуудал чинь.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна.

Д.Сарангэрэл: Улсын Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт

бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гаргаагүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Сарангэрэл гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлээ.

12.50 цаг

Дараагийнхаа асуудалд орёе.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэн танилцуулах вэ? Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулъя. Таныг индэрт урьж байна.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 05 сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 05 сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны

хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Тус байнгын хороо 2024 оны 05 сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Энхболд уг хуулийн дагаж мөрдөх хугацааг 24 оны 6 сарын 15-ны өдөр болгох талаар зарчмын зөрөөтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Байнгын хороо Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Их Хурлын эрхэм гишүүд ээ, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Энхболд даргад баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй 1 санал байгаа.

Боловсролын байнгын хороо хуралдаж байгаа учраас уг Байнгын хороо хуралдаж дууссаны дараа санал хураалтыг явуулна. Санал хураалтыг түр хойшлууллаа.

12.53 цаг

Дараагийнхаа асуудалд орёе.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг Байнгын хорооны дарга Батжаргал танилцуулъя. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Жигжидийн Батжаргал танилцуулъя. Таныг индэрт урьж байна.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас зарчмын зөрөөтэй 1 саналын томъёоллыг гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасныг баримтлан уг саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэн, төслүүдийн болон Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг та бүхэндээ хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Ургамлын эрүүл мэнд, ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ургамал хамгааллын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн

хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Батжаргал даргад баярлалаа.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Байхгүй.

Чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал нар оролцож байна.

Асуулт асуух гишүүн алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёолол байгаа. 1 саналтай. Үүнийг түр хойшлууллаа. Санал хураалтыг түр хойшлууллаа.

12.57 цаг

Дараагийнхаа асуудалд оръё.

Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гомпилдоогийн Мөнхцэцэг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Г.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их

Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүнээс 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар захирамжаар дээрх хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалаар ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Ганибал, Ц.Идэрбат, Саранчимэг, Энхтүвшин нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллалаа.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс залуу малчин гэр бүл болон хот, сууринаас шилжин очиж 2-оос доошгүй жил тасралтгүй мал маллаж байгаа малчин өрхөд өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх, бэлчээр ашиглуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, баг, хорооны ИНХ-ын шийдвэрт үндэслэн сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэх зохицуулалтуудыг нэмж төсөлд тусгах, мал аж ахуйн тогтвортой хөгжлийн бодлогыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт шаардагдах санхүүжилтийг улсын төсөвт тусган

хэрэгжүүлэхээр мал үржүүлэг, технологийн болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг хөнгөлөлттэй зээл болон бусад хэлбэрээр дэмжихээр өөрчлөлт оруулан найруулах, малчны өөрөө удирдах байгууллагын тогтолцоо, малчин өрх, тэдгээрт газар, эдэлбэрийн эрхийг баталгаажуулах, малчны оролцоотой байгалийн нөөцийг сэргээх чадварыг бэхжүүлэх зохицуулалтуудыг төслөөс хасах зэрэг зарчмын зөрөөтэй 14 санал, найруулгын 3 санал болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар 1 зарчмын зөрөөтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн юм.

Байнгын хороо ажлын хэсгээс гарсан зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан саналуудыг бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэндээ хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналууд байгаа. Үүнийг санал хураалтыг бас түр хугацаагаар хойшлууллаа.

13.01 цаг

Дараагийнхаа асуудалд оръё.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Жигжидийн Батжаргал танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар, Аубакир, Ж.Батжаргал

нар Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар зарчмын болон найруулгын нийт 16 саналын томъёоллыг бичгээр гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэндээ хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Батжаргал даргад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Бямбын Болдбаатар, Мал эмнэлгийн ерөнхий газрын Статистик, дүн шинжилгээ

хариуцсан ахлах мэргэжилтэн Сандагийн Батхуяг нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналууд байгаа.

Уг санал хураалтыг түр хойшлууллаа.

13.04 цаг

13 цаг болсон байна. Чуулганы нэгдсэн хуралдааны үдээс өмнөх хуралдааныг өндөрлүүлж байна.

14 цагаас нэгдсэн чуулган хуралдана.

ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан эхэлж байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭХХШТХ-д өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал танилцуулна. Таныг өндөрт урьж байна.

Н.Учрал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаанд оролцсон Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд тусгасан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулахтай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Учрал гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Байхгүй байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭХХШТХ-д өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ.

14.27 цаг

Дараагийнхаа асуудалд оръё.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Н.Учрал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулиудыг боловсронгуй болгох зорилгоор боловсруулсан холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Хууль зүй, дотоод хэргийн салбарт хамаарах 35 хууль тогтоомжоор эрх олгосон 160 гаруй заалт

Л.Мөнхбаатар: Учрал гишүүн ээ, та нөгөө Засгийн газрын гишүүнийхээ хувьд хууль санаачлагчийнхаа илтгэлийг эхлээд уншижъя. Тэгээд яачих. Хууль санаачлагчийнхаа илтгэлийг эхэлж уншаад, дараа нь нөгөө Байнгын хороогоо яачихъя. Байнгын хорооны санал, дүгнэлтийг нь Бямбацогт гишүүн, Бямбацогт гишүүн тэгэх үү? Танилцуулъя. Учрал сайд түр байж байгаарай, хүлээж байгаарай.

Учрал сайдыг индэрт урьж байна. Та хууль санаачлагчийн илтгэлийг танилцуулъя.

Н.Учрал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуульд 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр оруулсан өөрчлөлтийг үндэслэн Монгол Улсын ...

Л.Мөнхбаатар: Учрал сайд яагаарай. Хууль санаачлагчийн илтгэл бэлэн болсон байна.

Н.Учрал: Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт шинжилгээ, үнэлгээ

хийсний үр дүнгийн тайлан, хуулиар тусгайлан эрх олгосон заалтын судалгааны дүн, цаашид авах арга хэмжээний тухай хэлэлцээд Засгийн газар төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагад тус тус эрх олгогдсон заалтыг 2 дахин багасгах чиглэлийг баримтлан холбогдох хуулийн төслүүдийг боловсруулж, танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны ажлын хэсэг байгуулах тухай 191 дүгээр захирамжаар байгуулагдсан.

Уг захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдыг 2024 оны А/03 дугаар тушаалаар хууль зүй, дотоод хэргийн салбарын хууль тогтоомж, дүрэм журамд хяналт шинжилгээ хийж холбогдох хуулийн төсөл боловсруулах ажлын дэд хэсэг байгуулагдан ажиллалаа. Дэд ажлын хэсэг нь хууль зүй, дотоод хэргийн салбарт хамаарах 35 хууль тогтоомжоор эрх олгосон 160 гаруй заалт, түүний дагуу баталсан дүрэм журамтай нэг бүрчлэн танилцаж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах багцын хүрээнд 26 хуульд 65 журмыг холбогдох хуулиар зохицуулагдах ёстой гэж үзэн хуулийн төслүүдийг боловсрууллаа. Эдгээрээс Галт зэвсгийн хууль нь олон тооны журмын зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай байгаагаас нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бичих боломжгүй болсон тул хуулийн шинэчилсэн найруулга хэлбэрээр төслийг боловсрууллаа.

Дээрх хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу үзэл баримтлалыг тусад нь тодорхойлж, холбогдох үнэлгээ, судалгааг хийж ажиллалаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Хууль зүйн туслалцааны хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын

иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг 7 хуульд 25 эрх олгосон заалтын дагуу баталсан журмыг нэмж тусгах, хуулийн төслүүдийг хүний эрхийг хангах багц хуулийн төслүүдийн хүрээнд боловсрууллаа.

Ингэснээр хууль зүй, дотоод хэргийн салбарт Засгийн газрын 2023 оны 48 дугаар тэмдэглэлээр өгсөн захиргааны хэм хэмжээний актыг 2 дахин бууруулах чиглэлд 90 журмаар зохицуулж байгаа харилцааг хуульд тусгахаар төслийг боловсруулсан болно. Үүнд:

Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний улсын бүртгэлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Дотоодын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэрээт харуул, хамгаалалтын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувийн хамгаалалтын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,

Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль тогтоомжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд тус тус багтсан.

Хуулийн төслүүдийг дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Учрал гишүүнд баярлалаа.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Гишүүд танхимд орж ирээрэй, одоо санал хураалт явагдана шүү.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулиудыг боловсронгуй болгох зорилгоор боловсруулсан холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн.

Хууль санаачлах хууль зүй, дотоод хэргийн салбарт хамаарах 35 хууль тогтоомжоор эрх олгосон 160 гаруй заалт, түүний дагуу баталсан дүрэм журамтай нэг бүрчлэн танилцаж, хяналт шинжилгээ үнэлгээ хийсний

үндсэн дээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах багцын хүрээнд 26 хуульд 65 журмыг холбогдох хуулиар зохицуулах ёстой гэж үзэн хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

Хуулийн төслүүдийг Ди парламент.мн цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хуулиудыг боловсронгуй болгох зорилгоор боловсруулсан хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Хууль зүй, дотоод хэргийн салбарт хамаарах хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хуулиудыг боловсронгуй болгох зорилгоор боловсруулсан Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барааны тэмдэг, газар зүйн заалтын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэргийн хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Дотоодын

цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэрээт харуул, хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нөхөрлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Бямбацогт гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Аюурзанын Энх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Бүрэнтөгсийн Алтантуяа нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Уг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Санал хураалтыг түр хойшлууллаа.

14.39 цаг

Дараагийнхаа асуудалд орёе.

“Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан төсөл байна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ж.Чинбүрэн: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр нэн яаралтай хэлэлцүүлгээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн эрсдэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг баримтлан Байнгын хорооноос боловсруулсан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Нийгмийн бодлогын байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар явууллаа.

Тогтоолын төслийн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга баталсантай холбогдуулан авах арга хэмжээний талаарх зохицуулалтыг тусгаж боловсруулсан.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, зарчмын зөрөөтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Анужингаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасны дагуу тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан тухай Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Чинбүрэн гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Энэ Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал байгаа. Энэ санал хураалтыг түр хойшлууллаа.

Дараагийнхаа асуудалд орёё.

“Шүүгчийн орон тоог батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2024 оны 05 сарын 21-ний өдөр Монгол Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасныг баримтлан “Шүүгчийн орон тоог шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Байнгын хорооны 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

“Шүүгчийн орон тоог шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэсэн саналыг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн. Тогтоолын төсөл болон холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Шүүгчийн орон тоог шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Бямбацогт гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

“Шүүгчийн орон тоог батлах тухай” Их Хурлын тогтоолын төслийг санал хураалтыг түр хойшлууллаа.

14.44 цаг

Дараагийнхаа асуудалд орёё.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ерөнхий прокурорын газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 1/4805 тоот албан бичгээр ирүүлсэн санал, Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 1/1198 тоот албан бичгээр ирүүлсэн дэмжсэн саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2024 оны 05 сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Тогтоолын төсөлд “Төрийн зарим албан байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 18 дугаар тогтоолын хавсралтын Монгол Улсын ерөнхий прокурорын газар гэсэн баганын АА5 зэрэглэлийн “тасгийн дарга” гэсний

өмнө “Прокурорын газрын хэлтэс” гэж, АА9 зэрэглэлийн “ахлах мэргэжилтэн” гэсний өмнө “Прокурорын газрын” гэж нэмэхээр тусгалаа.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Бямбацогт гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооны саналаар санал хураалт явагдана.

Санал хураалтыг түр хойшлуулъя.

Давхар Байнгын хороод хуралдаж байгаа учраас, хуралдаж байгаа, түүнээс гадна сонсгол бас хийгдэж байгаатай холбогдуулан гишүүд хурлуудаа дуусгаад яаралтай танхимдаа орж ирээрэй.

14.46 цаг

Дараагийнхаа асуудалд орёё.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн

Даваажсанцангийн Сарангэрэл
танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.4 дэх хэсэг, мөн Төрийн албаны зөвлөл болон Ёс зүйн хорооноос ирүүлсэн саналуудыг тус тус үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хороо “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийг хэлэлцээд дараах санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулж байна.

Тогтоолын төслийг боловсруулахдаа Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно гэж заасны дагуу Төрийн албаны зөвлөл нь хуулиар хүлээсэн чиг үүрэг, бүрэн эрхээ хэрэгжүүлэх, төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндсэн зорилгын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, Ёс зүйн хорооны гишүүдийн ажиллах нөхцөл, баталгааг сайжруулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд нэмэлт, өөрчлөлт оруулахаар боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед

гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжиж, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанд хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Сарангэрэл гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй.

Санал хураалтыг нэгтгэж явуулна. Санал хураалтыг түр хойшлууллаа.

14.49 цаг

Дараагийнхаа асуудалд орёё.

“Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Жаргалмаа: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.4 дэх хэсэг болон Төрийн албаны зөвлөлөөс 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 01 1097 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг

үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хороо “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийг хэлэлцээд, дараах санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулж байна.

Тогтоолын төслийг боловсруулахдаа Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн албаны чадахуйн зарчмыг сахиулж, улс төрийн зүй бус нөлөөллөөс ангид, иргэдийн итгэл хүлээсэн төрийн албыг төлөвшүүлэх зорилтын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааг үр ашигтай, үр нөлөөтэй явуулах, хуулиар хүлээсэн бүрэн эрхийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагыг үндэслэн мөн Төрийн албаны зөвлөлийн гишүүдийн ажлын ачаалал, хариуцлагыг харгалзан үзэж, нийгмийн баталгааг нь хангах зорилгоор цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг шинэчлэн тогтоосон байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед асуулт асууж, үг хэлсэн гишүүн гараагүй болно.

“Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн ишийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Жаргалмаа гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

Санал хураалтыг түр хойшлууллаа. Санал хураалтыг нэгтгэж явуулна.

14.51 цаг

Дараагийнхаа асуудалд орёе.

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье. Хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Цэрэнпилийн Даваасүрэн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2001 онд Улсын Их Хурлын 57 дугаар тогтоолоор батлан мөрдүүлснээс хойш эдүгээ 23 жилийн хугацаа өнгөрч байна.

Өнгөрсөн хугацаанд бүс нутаг төлөвлөлтийн онол арга зүйч шилжилт хийгдэж, шинэ эдийн засаг, газар зүйн онол, кластерын онол, хөгжлийн туйл, өсөлтийн төвийн онолууд орчин үеийн чиг хандлага болж ирлээ. Мөн өнгөрсөн хугацаанд Улаанбаатар хотод нийт хүн амын 48,9 хувь буюу 1,7 сая хүн ам амьдарч, бүртгэлтэй ААН-ийн 70 хувь нь, худалдаа аж үйлдвэрийн 85 хувь нь, их, дээд сургуулийн 96 хувь нь төвлөрч, ДНБ-ий 63 хувь нь үйлдвэрлэгдэж, хот, хөдөөгийн хөгжил эрс ялгаатай болсон.

Иймд дэлхий дахинд баримталж буй ирээдүй, хойч үедээ унаган байгалийг алдагдуулахгүй өвлүүлэх, тогтвортой хөгжлийн үзэл санаа, орчин үеийн онолын чиг хандлага, хот, хөдөөгийн хөгжлийг тэнцвэржүүлэх практик хэрэгцээ шаардлагаас үүдэн Монгол Улсын

бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулаад байна.

Тус үзэл баримтлал 6 бүлэг, 1 эрхэм зорилго, 7 зорилго, 217 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Монгол Улсын эдийн засгийн, Хангайн, Баруун хойд, Төвийн, Зүүн, Говийн, Улаанбаатарын гэсэн 7 бүсийн тогтолцоогоор хэрэгжүүлэхээр тодорхойлсон.

Хангайн бүсэд Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг, баруун бүсэд Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг, Хойд бүсэд Булган, Орхон, Хөвсгөл аймаг, Төвийн бүсэд Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймаг, Зүүн бүсэд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг, Говийн бүсэд Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгууд, Улаанбаатар бүсэд Улаанбаатар хот, дагуул хотод хамрагдаж байна.

Бүсүүдийн хөгжлийн нийтлэг зорилтуудыг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд:

1. Бүс, нутгийн хөгжлийн орчин үеийн онолын чиг хандлагад үндэслэж, бүс нутгийн онцлог давуу талыг нээн илрүүлж, бүс, орон нутгийн эдийн засгийн чиг үүргийг оновчтой тодорхойлж, байгалийн нөөц баялгийг зохистой, өгөөжтэй, хүртээмжтэй ашиглаж, хамгаалж, нөхөн сэргээх, үйлдвэрлэл, үйлчилгээг хоршилт, төрөлжилт, дагналт, кластерын бодлогоор дэмжих.

Бүс, орон нутагт өндөр технологи инновацыг нэвтрүүлэх.

Бүс дамнасан салбар хоорондын уялдааг хангасан стратегийн төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламж, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрийг оновчтой хуваарилж, татвар, санхүүгийн ялгаатай бодлогыг

хэрэгжүүлж, бүс нутгийн хөгжилд оролцох талуудын хамтран ажиллах сонирхлыг дэмжиж, тээвэр ложистикийн нэгдсэн сүлжээ, боомт, чөлөөт бүс, тусгай бүсийг хөгжүүлж, дэд бүтцийн нэгдсэн ухаалаг сүлжээг байгуулж, бүс нутгийн эдийн засгийн интеграц нэгдэж зах зээлийг тэлж, орчин үеийн шинэ суурьшлын бүс хотуудыг байгуулж, бүс нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, орон нутагт ажиллаж, амьдрах бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлж, өрсөлдөх чадвартай бүс нутгийг хөгжүүлэхээр төлөвлөж байгаа болно.

Эрхэм гишүүд ээ, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын шинэчилсэн хувилбарыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Даваасүрэн сайдад баярлалаа.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Жаргалмаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2001 онд Улсын Их Хурлын 57 дугаар тогтоолоор батлан мөрдүүлснээс хойш 23 жилийн хугацаа өнгөрч байна. Мөн хугацаанд Улаанбаатар хотод нийтдээ хүн амын 48,9 хувь буюу 1,7 сая хүн амьдарч, бүртгэлтэй ААН-ийн 70 хувь, худалдаа

үйлчилгээний 84 хувь, их, дээд сургуулийн 96 хувь нь төвлөрч, ДНБ-ий 63 хувь нь үйлдвэрлэгдэж, хот, хөдөөгийн хөгжлийн хэт ялгаатай байдал үүссэнийг арилгах зорилгоор Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулсан байна.

Тогтоолын төсөлд Монгол Улсын бүсүүдийг тодорхойлж, тэдгээрийг нь тэргүүлэх чиглэл, эрхэм зорилгыг томьёолон, түүнд хүрэх эдийн засаг, санхүүгийн дэмжлэг, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, орон зайн төлөвлөлт бүхий зорилтуудыг Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан тодорхойлсон байна.

Тогтоолын төсөлд иргэдийн оролцоог хангах санал авах зорилгоор Улсын Их Хурлын Ди парламент.мн цахим системд байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганболд орон нутгийн хөгжлийн төв, түүнд татагдах сум, сууриныг оновчтой тодорхойлсон эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа хууль, тогтоолын төслүүдтэй нийцэл, уялдаа холбоог хангасан эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Жаргалмаа гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Сүхбаатарын Цогтгэрэл, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Цогтын Баярбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Даваасамбуугийн Эрдэнэбаяр байна. Улсын Их Хурлын гишүүн асан, техникийн ухааны доктор Норжсмаагийн Тогтох. Тогтох гуай ирсэн байна. Монгол Улсын их сургуулийн профессор, шинжлэх ухааны доктор Равсалын Ренчинбазар, Эрчим хүчний хөгжлийн төлөө Монголын нийгэмлэгийн захирал Доржсүрэнгийн Пүрэвбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны ахлах шинжээч Дамбийнямын Мөнхжаргал, Барилга, хот байгуулалтын яамны газрын дарга Эрдэнэбатын Батболд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны газрын дарга Сүхбаатарын Сүхбат, Хот, хөдөөгийн сэргээгдэх газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн үндэсний хорооны ахлах мэргэжилтэн Мягмарсүрэнгийн Буяндэлгэр, Эрүүл мэндийн яамны газрын дарга Пүрэвийн Оюунцэцэг, ирсэн үү? Сангийн яамны газрын дарга Ганболдын Золбоо, Эдийн засаг, хөгжлийн яамны ахлах мэргэжилтэн Алтангэрэлийн Чулуунчимэг, ирсэн үү? Зам, тээврийн хөгжлийн яамны газрын дарга Болор-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны газрын дарга Цэрэндулам нар Цэрэндуулал уу, тийм ээ. Бүгдээрээ оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Батжаргал гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүнээр

тасаллаа. Байнгын хорооны дарга Жигжидийн Батжаргал асуултаа асууя.

Ж.Батжаргал: Бүсчилсэн хөгжлийнхөө үзэл баримтлалыг шинэчлэх тодорхой төсөл орж ирж байна. Тодруулах зүйлүүд байна.

Угаасаа бид энэ бүсчилсэн хөгжлийг нэлээн бодитой явуулж, тэр хэмжээгээр энэ бүс нутгуудын хөгжлийг хангах асуудал юунаас чухал байгаад байгаа юм. Тийм учраас бүсийн хөгжлийн төлөвлөлтийн асуудлыг ер нь ямархуу байдлаар энэ үзэл баримтлал талд нь тусгаж оруулав гэдэг 1 асуудал байгаа юм.

2 дахь зүйл. Ер нь энэ бүсийн хөгжлийн төлөвлөлт, түүний хэрэгжилтийн асуудал дээр удирдлага шинжилгээнийх нь бүтэц ер нь ямархуу байдлаар явна гэж төсөөлөөд байна вэ? Энэ дээр нэг тодорхой хариулт авмаар байна.

3 дахь зүйл бол ерөөсөө угаасаа энэ бүс нутгуудын өөр өөрийнх нь нөөц боломж, давуу тал дээр тулгуурласан хөгжлийн, тэр тусмаа эдийн засгийн хөгжлийн том концепц явах болов уу гэж би ингэж хараад байгаа.

Тэгэхээр зэрэг тухайн бүс нутгуудын давуу боломж дээр тулгуурласан үйлдвэржилтийн зураглалын тухай асуудал хамгийн түрүүн гарч ирнэ ээ. Үүнийг ер нь ямархуу байдлаар төсөөлж, энэ үзэл баримтлалд тусгаж оруулав гэдэг асуудал байна.

Тэгээд мэдээж энэ тодорхой бүс нутгууд бас нөөц боломж, давуу талууд нь бүсэд хамрагдаж байгаа нэгжүүд дээрээ адил байх магадлалууд их өндөр бий. Тэгэхээр зэрэг ижил төрлийн үйлдвэрлэл, хөгжлийн асуудлууд нэг бүс дотроо хэд хэдэн газар байриших юм уу эс үгүй бол технологийн боловсруулалтынхаа түвшинээр хоорондоо уялдаатай, тэгээд хөгжлийнх нь төлөвлөлтийг бодож байна уу? Үүн

дээр ер нь ямархуу төсөөлөл юмнууд бууж оров гэж. Ер нь өнгөрсөн 20-оод жилийн түүхийг аваад үзэхээр зэрэг бид нар бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаа ерөнхий тодорхойлчихоод, тэгээд хөгжлийнхөө зураглал юмнуудыг их тодорхой болгож чадаагүй, хоорондоо харилцан уялдах асуудлыг нь тодорхой шийдэлд хүргэж гаргаж чадаагүйтэй холбогдоод энэ их тийм сүйдтэй амь орж чадаагүй л гэж би ойлгоод байдаг.

Тэгэхээр зэрэг энэ нэг 20-оод жилд явсан бас ололт, алдаа, туршлага, сургамждаа тулгуурлаад энэ удаагийн энэ үзэл баримтлалыг ер нь ямархуу байдлаар нь төсөөлж оруулж ирэв гэдэг л асуудал бид нарын гол зүйл байна л гэж хараад байна л даа.

Тэгээд энэ бүсчлэлийн энэ юмнууд яваад ирэхээр зэрэг төр, хувийн хэвилийнхээ түншлэлийн хүрээнд ч тэр, энэ шинжлэх ухаан, технологийн хүрээлэнгүүд нь ч тэр, хамтарч ажиллах ажиллагааныхаа тал дээр ямар юм байх юм бэ? Монголын нэрээр гадагшаа гардаг бүтээгдэхүүнүүдийн чинь тоо хэмжээ ямар хэмжээнд явах юм. Тэгээд үүнийг явуулахын тулд зүгээр дан ганц төлөвлөлтөөр биш юм билээ. Амьдрал дээр. Энэ манай технологи хөгжүүлэлтийн гэдэг юм уу, бараа судлалын гэдэг юм уу, энэ байгууллагууд шинжилгээний байгууллагууд нь хоорондоо хамтарч ажиллаж, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийнхээ асуудлыг нэлээн нарийн судалж, энэ нэр, төрөл дээр тулгуурласан экспортын үзэл баримтлал явах юм байна гэдэг юмаа тодорхойлж авч тэр лүүгээ хатуу зүтгэж чадаж байж л Монголын нэр устай валют дотогшиллуулах жоохон бүтээгдэхүүнүүд гарах бололцоо бий. Тэгээд тэр уур уурхайн бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хэмжээг нэмэгдүүлэх асуудал. Энд л би гол суурь нь явах ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 4 дүгээр

микрофоныг өгье. Нэр, албан тушаалаа хэлээд асуултад хариулаарай.

Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр Батжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ удаагийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулахдаа орчин үеийн чиг хандлага болж буй шинэ Эдийн засаг, газар зүйн онол, өсөлтийн төвийн онол дээр тулгуурлаж боловсруулсан. Мөн хөрш орнууд, Азийн бүс нутагт байгаа улс орнууд бол яг энэ загвар дээр тулгуурлаж бүсчилсэн хөгжлийнхөө бодлогыг боловсруулж байгаа. Өөрөөр хэлбэл Монгол Улсын газар нутаг дээр байгаа байгалийн баялгийн ижил төстэй байдлаар нь бүс нутагт хуваах, түүнийг дэмжсэн, эдийн засаг, татвар, санхүүгийн ялгаатай бодлогыг хэрэгжүүлэх ийм зорилгоор арга зүйг бол сонгосон.

Бүс болгонд бол хувийн хэвшлийг дэмжих замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулахын тулд үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлэх эко систем буюу энэ орчныг бүрдүүлэх чиглэл дээр бол энэ удаагийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал дээр голлон анхаарсан. Өөрөөр хэлбэл, тээвэр ложистик, худалдаа, үйлдвэр үйлчилгээний төвүүдийг Монгол Улсын хамгийн нөөц сайтай, хамгийн байршил сайтай ийм газруудад 3 шаталсан хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөж байгаа. Өөрөөр хэлбэл орон нутгийн тээвэр ложистикийн төв. Энэ нь 50-80км-т байгаа иргэд, ААН-ийн түүхий эд бүтээгдэхүүн, байгалийн дагалдах түүхий эдийг дотоодын болон гадаадын зах зээл рүү анхан шатын боловсруулалт, тордолт хийж хүргэх. Үүний дараа Мизо бүсчлэл буюу аймгийн төв дээр байгаа үйлдвэр үйлчилгээний томоохон төвүүд дээр дараагийн шатын боловсруулалтыг хийх. Мөн олон улсын тээвэр ложистикийн сүлжээнд холбогдох хамгийн стратегийн байршил дээр олон улсын тээвэр Ложистикийн төв, хуурай боомт, түүний 2 холболтын цэг дээр байгаа боомтын хүчин чадлыг өргөтгөх

замаар хөрш орнуудын хамгийн ашигтай үйлдвэр үйлчилгээний төвүүд, технологийн паркууд, гол хотууд руу холбох гэсэн энэ концепцоор дэд бүтцийн буюу холболтын эдийн засгийн гол төслүүдийг нэн тэргүүн ээлжид хэрэгжүүлэхээр бүс тус бүр дээр 3 шатлалаар тооцож оруулсан байгаа.

Мөн 90 оноос хойш Монгол Улсын гадаад худалдааны плутин болон ДНБ-д дийлэнх салбарын гол оролцоог бүрдүүлж байгаа салбарууд тус бүрээр нийтдээ 119 шалгуур үзүүлэлтээр орон зайн тохиромжтой байдлын үнэлгээг хийсэн. Өөрөөр хэлбэл бизнес эрхлэхэд хамгийн тохиромжтой тэр орчин бүрдсэн ийм салбар, салбарын зураглалыг хийж, тэд нарыг давхардуулах замаар оновчлолыг гаргаж, үйлдвэр үйлчилгээг төвлөрүүлэн хөгжүүлэх энэ концепцыг тусгасан. Нийт 21 аймгийн төв дээр нэмэх нь 69 үйлдвэр, үйлчилгээ, худалдааны гол ашигтай байршил дээр байх юм гэдгийг гаргаж ирсэн байгаа.

Ингээд өнгөрсөн оны 07 сарын 07-нд Улсын Их Хурлаар батлуулсан Азийн хөгжлийн банкны аймаг, сумын бүсчилсэн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд энэ төслийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийн зарим хэсгийг тусгаж, Их Хурлаар баталгаажуулсан байж байгаа.

Технологийн хувьд кластерын үзэл санаа буюу энэ ашигтай байршил дээр төр, хувийн хэвшлийн түншлэл, эрдэм шинжилгээний байгууллагуудын оролцоог хамтын ажиллагааг хангах замаар газар зүйн заалттай орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг орчин үеийн технологитой хослуулах замаар хувийн хэвшил дээр тулгуурлан дэмжих дэд бүтцийг болон санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх замаар хөгжүүлнэ гэж ингэж тусгаж байгаа. Өөрөөр хэлбэл, хувийн хэвшлийн үйлдвэр үйлчилгээг төлөвлөхөөсөө илүү тэр орчныг бүрдүүлэх дээр илүү анхаарч энэ удаагийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулсан.

Удирдлага зохион байгуулалтын хувьд Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаа батлуулсны дараа Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохион байгуулалтын тухай хуулийг намрын чуулганаар оруулахаар төлөвлөж, ажлын хэсэг бол ажил ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу? Гүйцээгээд хариулчих. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгчихье.

Д.Эрдэнэбаяр: Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хувьд нэг аймгийн Засаг дарга нь тухайн бүсийнхээ захирагчаар ажиллах ийм эрх зүйн зохицуулалттай байгаа. Өнгөрсөн хугацаанд бол энэ бүтэц, зохион байгуулалт нь бол хэрэгжих боломжгүй юм байна гэдэг нь өнгөрсөн 23 жилийн хугацаанд нотлогдсон байгаа. Өөрөөр хэлбэл Эдийн засаг, хөгжлийн яам дээр нэгдсэн удирдлага зохион байгуулалтыг нэгдсэн бодлого төлөвлөлт, эдийн засгийн төлөвлөлтүүдтэйгээ уялдуулах замаар энэ удирдлага, зохион байгуулалтыг шийдэх нь илүү оновчтой юм байна гэдэг ийм эрдэмтдийн судалгаа бол одоогийн байдлаар гарсан байгаа.

Тэгээд үүнийг үргэлжлүүлж Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу олон шаталсан хэлэлцүүлгийг хийж байж, намрын чуулганд дахиж энэ бүтэц, зохион байгуулалтыг оруулахаар төлөвлөж байгаа. Хувийн хэвшлийн бүс болгон дээр мэргэжлийн холбоод, Худалдаа аж үйлдвэрийн танхим, салбарын гол холбоодын төлөөлөл бүхий хувийн хэвшлийн зөвлөл харин байж болох юм. Эдгээр зөвлөл тухайн бүсдээ ямар төсөл, арга хэмжээг үйлдвэр үйлчилгээ, хувийн хэвшлийг дэмжих чиглэлээр хэрэгцээ шаардлага байгаа, үүнийгээ хэлэлцээд жил болгон эдийн засгийн асуудал хариуцсан төв байгууллагад хүргүүлэх, салбар яамнууддаа хүргүүлэх замаар жилийн төлөвлөгөө, 4 жилийн төлөвлөгөө, 5 жилийн төлөвлөгөөнд тусгаад явах ийм бодлого, төлөвлөлтийн шинэ тогтолцоог бүрдүүлээд, хувийн

хэвшил дээрээ тулгуурлаад явах нь бол оновчтой юм байна.

Харин энэ хувийн хэвшлийг дэмжих төсвийн хөрөнгө оруулалтаар хийх ажлууд нь нэгдсэн зохион байгуулалтаар явах нь илүү оновчтой юм байна. Яагаад гэхээр салбар бүрийн хэрэгжүүлэх томоохон төслүүдийг өнгөрсөн хугацаанд бол уялдаа холбоогүйгээр өөр өөр байриил дээр хэрэгжүүлж байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөж, байрилын уялдаа холбоог хангахгүй ийм сөрөг үр дагаврууд бол гарч байна.

Нөгөө талдаа нэг аймгийн Засаг дарга бүсийн хэмжээний төслийн ТЭЗҮ, судалгаа энэ юмыг хөөцөлдөөд явах нь өөрөө потенциал талаасаа нэлээн хүндрэлтэй, цаг хугацааны болоод бусад зүйл дээр бол хүндрэл учирч байгааг өнгөрсөн хугацаанд харуулсан байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу? Байнгын хорооны дарга Жигжидийн Батжаргал тодруулж асууя.

Ж.Батжаргал: Мэдээж хэлэлцүүлгийн түвшинд үзэл баримтлалаа сайжруулж гарах байх. Түүний ар дээр удирдлага, зохион байгуулалтын хуулийн асуудал яригдах юм байна. Тэгэхээр энэ дээр нэг их онцгой анхаармаар байгаа зүйл бол бид энэ хөгжлийн бодлого, төлөвлөлтийнхөө хуульд нэмэлт оруулах замаар энэ бүсийн төлөвлөлтийн зарчим руугаа шилжихгүй бол энэ ажил болохгүй ээ. Ерөөсөө бид нарын хориод жилийн чинь явж чадаагүй юм энэ дээр нэг гол зүйл байгаад байгаа.

2 дахь зүйл, энэ үйлдвэржилтийнхээ ерөнхий зураглал юмнуудаа гаргаад хувийн хэвшил гэдэг юм уу, энэ гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар хийчхэж болохоор зүйлээ нийтэд ил зарлаж шийдвэрлэх асуудал бид нар оройтоод болж өгөхгүй байгаа. Төлөвлөлтөө дарж хэвтчихээд тэр нь ажил болж өгөхгүй, үүнээсээ болоод удаашираад болж өгөхгүй байгаад байгаа юм байна юм.

Тэгэхээр ийм зүйлүүдээ хэрхэн шийдэх вэ гэдэг юмаа энэ үзэл баримтлал талдаа нэлээн тодорхой тусгаж өгөөд тэгээд үүн ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулах юм уу тийм ээ. Хариулт авах уу? Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгье. Ажлын хэсэг хариулья.

Д.Эрдэнэбаяр: Одоогийн хууль, эрх зүйн орчны хувьд Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль дээр 7 зорилтот хөтөлбөрийг 10 жилийн хугацаатайгаар Улсын Их Хурлаар батлуулж хэрэгжүүлнэ ээ гэсэн бас ийм заалт байгаа. Үүний нэгдүгээрх буюу эдийн засгийн зорилтот хөтөлбөр нь Шинэ сэргэлтийн бодлого нэртэйгээр батлагдаад хэрэгжээд явж байгаа.

Үүний дараа бол бас ямар заалт байгаа вэ гэхээр бүсийн зорилтот хөтөлбөрүүдийг 10 жилийн хугацаатай боловсруулж батлуулна гэсэн. Хууль, эрх зүйн орчин нь бол бүрдчихсэн байж байгаа. Тэгэхээр бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлагдсаны дараа эхний 10 жил хэрэгжүүлэх бүс болгоны зорилтот хөтөлбөрийг энэ хуулийн Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу оруулж ирж хэлэлцүүлэх ийм эрх зүйн орчин бол нээлттэй байгаа.

Таны хэлж байгаа бүх эдийн засгийн тэргүүлэх салбаруудын орон зайн үйлдвэржилтийн зураглал, тохиромжтой байдлын судалгааг Эдийн засаг, хөгжлийн яам, ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн сектортой хамтраад өнгөрсөн 4 жилийн хугацаанд нэг бүрчлэн 330 сум ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Бүсчилсэн хөгжил яах вэ, бизнесийг дарамтлахаа зогсоо. Сүүлийн үед ер нь бол хууль гаргаж, хувь бизнесийг дарамталдаг явдал хэрээс

хэтэрч байна. Жишээ хэлье. 3.Энхболдод дургүй байж болно. Стратеги шоглохын тулд давхар АМНАТ-ын хууль батлаад 50 гаруй тэрбум төгрөг төлдөг 50 ААН-ийг өнөөдөр дампууруулаад хаячихсан байж байгаа. Номтойбаярт дургүй байж болно. Баялгийн сангийн хууль гаргаад тэр зүгээр дурын ордыг стратегийн орд гээд улсад хурааж авах тийм боломжийг нээж байгаа юм.

Тэгээд ингээд хайгуулын ажил бүрэн зогсох байхгүй юу даа. Нэг гайгүй орд гаргаад ирэнгүүт нь түүнийг нь стратегийн орд гээд авчихвал яана гэдэг тэр эрсдэлээс болоод энэ хайгуулын ажил бүрэн зогсоно. Алтан тариан Цэнгүүнд дургүй байж болно. Гэтэл гурилын импортын татварыг тэглээд, газар тариалангийнхаа салбарыг дампууруулж байна шүү дээ. МАК-т дургүй байж болно. Цементийн импортын татварыг тэглээд л, тэгээд үндэсний үйлдвэрүүдээ ингээд эрсдэлд оруулаад эхэлчихнэ шүү дээ. Тэгээд данс хаах. Тэгээд л ААН дээр байнгын тэр яам болгоноос нөгөө нэг хяналт шалгалт нь оччихсон, яам болгоноос өдөр тутам очиж шалгах явдал бол хэрээс хэтэрсэн. Одоо тэр зүгээр л НДШ-ийн өртэй байхад л гадаад явах хоригийг нь тавьж байна шүү дээ. Хилийн хориг тавьж байна шүү.

Тэгээд энэ татвар, хуулийн байгууллагынхан тэр ААН-үүдийг дарамталдаг, шалгадаг, хорьдог энэ асуудал чинь бүр хэрээс хэтэрсэн. Тэгээд байтлаа бүр тэгээд дуртайгаа хорьдог болчихоод байна шүү дээ. Гарамжав гуайг хорьчихсон байж байна. Би бизнес эрхэлж байсан хүн би бол Гарамжав гуайг ер нь бол ямар шалтгаанаас болж хорьсныг нь би ерөнхийдөө гадарлаж байна. Тэгэхдээ тэр хүнийг заавал хорих шаардлага байхгүй байхгүй юу. Гадуур шалгах бүрэн боломжтой. Гэтэл аваачиж хорьж байгаад л тэгээд л ингээд л ер нь яах юм коммунизм тогтоох гээд байгаа юм уу, яах гээд байгаа юм. Энэ нэг хэдэн төгрөг олж ирдэг энэ нэг бизнесийнхнээ бүр дарамталдаг энэ явдал чинь бүр хэрээс хэтэрч байна шүү дээ.

Тэгээд ХАҮТ-ын дарга нь тэгээд л өөрсдийг нь дарамталдаг, бизнесийнхнийг нь дарамталдаг тэр намын жагсаалтад ороод нуугдчихсан байж байна шүү дээ. Амартүвшин гэж манай намыг дэмждэг залуу ХАҮТ-ын дарга хийж байсан. Гэхдээ хэзээ ч бизнесийнхнийг ашиглаж Их Хуралд дэвшээгүй л байхгүй даа. Ямар, ямар их ёс зүйн зөрөө байна гэдэг эндээс харагдана шүү дээ. Энэ бизнес бол үнэхээр хүнд нөхцөлд байна. Энэ дарамт, шалгалт хэрээс хэтэрч байна. Тэгээд энэ айлгаж ичээдэг, тэр бизнесийнхнийг, ялангуяа өөр үзэл бодолтой байж, өөр намыг дэмжих тэр явдлыг бүр ингээд хуулийнхантайгаа нийлж байгаад хорьдог, шалгадаг ийм зүйл болж байна шүү дээ. Энэ чинь тэгээд л бүр коммунизм руугаа шууд орж байна гэсэн үг шүү дээ.

Тэгээд доор шатдаа бол ерөөсөө гарын үсэг болгон, гарын үсэг болгон төлбөртэй болсон, авлигатай болсон. Ерөөсөө төрийн ажил ерөөсөө явахаа больсон. Нэг нь гарын үсэг зурахгүй, мөнгөө нэхээд хэвтчихдэг, тэгэнгүүт ерөөсөө бизнесийнхний ажил ерөөсөө явдаггүй энэ зүйл хэрээс хэтэрч байна шүү дээ. Энэ юунаас болж байна вэ гэхээр дээрээ хулгайлж идээд Их Хурлын гишүүд, сайд дарга нар нь хулгайлж идээд болоод байгаа юм чинь доор нь бид нар энэ Ардын нам ялагдах нь, байгаа дээрээ бушуухан шиг нэг хэдэн төгрөг хийгээд авъя гэдэг ийм зүйл бүр энэ дээр дээрээсээ доор хүртэл бүр энэ авлигад живчхээд байна шүү дээ. Энэ Монгол улс чинь. Энэ асуудлаа цэгцлээрэй. Энэ арай хэтэрч ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Пүрэвдорж гишүүн үг хэлчихлээ тийм ээ. Асуулт байгаа юу? Хэн хариулах юм? Пүрэвдорж гишүүн нэмэлт 1 минут өгье.

Б.Пүрэвдорж: Тогтох гуай, таныг бүсчилсэн хөгжлийн талаар бас нэлээн сайн ярьдгийг би сайн мэднэ. Тэгэхдээ энэ удаагийн бүсчилсэн хөгжил, бүсчилсэн тойрог гэдэг бол зүгээр сонгуульд ялах Ардын намын тактик болохоос биш өнөөдрийг хүртэл хөдөөгүүр явж байгаа

МАН-ын гишүүд бүсчилсэн хөгжлөөр энэ аймгийг ингэж хөгжүүлнэ, энэ аймагт ийм үйлдвэр байгуулна, энэ аймгийн иргэд үүний үр дүнд ингэж сайхан хөгжинө гэдэг тийм зүйлийг ерөөсөө ярихгүй байгаа. Хамгийн дээд тал нь ярьж байгаа вэ гэхээр танай аймагт аялал жуулчлалыг л хөгжүүлнэ гээд хаа сайгүй ярьж байгаа. Өөр юу ч ярихгүй байгаа. Энэ бүсчилсэн хөгжил гэдэг бол таны бодож сэтгэж байгаа шиг тийм зүйл биш. Энэ бол зөвхөн сонгуульд зориулсан, сонгуульд яаж ялалт байгуулах вэ гэдэг гадаадынхны саналаар бий болсон тэр сонгуулийн хуульд зориулагдсан л жүжиг гэж ойлгож болно.

Л.Мөнхбаатар: Хэн хариулах юм бэ? Монгол Улсын Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг жүжиг гэж л ярьж байх шиг байх юм. Яах вэ, сонгууль дөхчихсөн байгааг ойлгож байна. Гэхдээ нэг хүнээрээ л хэдүүлээ нэг сонгуулийн ард гарчихмаар байна. Эргээд уулзахгүй нүүр биш, Монгол Улсын хөгжлийнхөө бодлогоор хэдүүлээ бие биеэ ингэж бас попорч болохгүй л дээ. Тэгээд Пүрэвдорж гишүүн ээ, та ингэж попроод яах вэ дээ. Та зөвхөн Ховд аймгаас сонгогдохгүй шүү. Увс аймгаас сонгогдоно шүү, та. Говь-Алтайгаас сонгогдоно шүү, та. Завхан аймгаас сонгогдоно шүү, та.

Тэгээд бүсчилсэн хөгжил хамаагүй гэж үзээд тэр бусад аймгууд надад хамаагүй гэж та хэлж болохгүй шүү. Бид нар энэ улс орныг хөгжүүлэхийн тулд явал богинохон хугацаанд санхүүгийн эх үүсвэрээ зөв оновчтой хуваарилж байгаад бодлогоо зөв болгож байгаад сонгогдох, хөгжүүлэх тухай л ярьж байгаа. Та энэ бодлогыг бүгдийг нь эсэргүүцэж байгаа юм байна л даа. Энэ бүх яриа явж тэр аймгуудад уулзалт хийх ярьж байсан бүх зүйл чинь таны хувьд тэгээд жүжиг юм уу? Ингэж болохгүй шүү, та, ингэж болохгүй шүү, та. Энд Монгол Улсын хөгжлийг явал хурдатгах вэ, түргэтгэх вэ гэдэг ийм асуудлыг энд оруулж ирж байгаа, Монголчууд бид нар хуваагдаж

жижгэрч үзсэн. Хуваагдаж жижгэрлээ гээд Монгол Улс хөгжссөн юм уу, хөгжсөөгүй. Монголчууд өнөөдөр тулгамдаж байгаа асуудлуудыг нэгдэж нийлж байж шийдье гэдэг ийм бодлогын асуудал орж ирж байхад та үүнийг жүжиг гэж хэлээд яах вэ. Ингэж болохгүй шүү. Бид нар Монгол Улс бол өөрөө нэгдэж томорч байж бид нар Монгол улс хөгжинө. I нэгийгээ барьж идэж, I нэгийгээ доромжилж, I нэгийгээ доош нь хийж байж Монгол Улс хөгжихгүй. I нэгийгээ гүтгэж доромжилж, элдэв бусаар нь дуудаж, гүтгэж байж Монгол Улс хөгжихгүй. Монгол Улсад огт хэрэггүй тэс хөндлөн төмөр замыг их наядаар нь хулгайн мөнгө барьж, мөнгө хулгайлчихаад одоо Улсын Их Хуралд нэр дэвшээд явж байгаа шиг тийм экс Ерөнхийлөгч шиг тийм хүмүүстэй байж байж Монгол Улс хөгжихгүй шүү.

Тийм учраас, тийм учраас Монгол Улсад бодлогоо хийхийн тулд нэг хүн мэддэг, 2 хүн мэддэг байх биш, олуулаа нийлж, ярьж байгаад хөгжлийн асуудлаа ярьдаг энэ бодлогын тогтолцоо руу шилжье гэхээр үүнийг эсэргүүцдэг байж болохгүй шүү дээ. Алийн болгон Монголчууд бид нар тамын тогоондоо амьдрах юм. Алийн болгон худал хуурмагаар бид нар өнөөдрийг хүртэл явах юм. Алийн болгон энэ хувийн хэвилийнхнээ дарамталж явах ёстой юм. Хувийн хэвшилтэй холбоотой хэлсэн зүйлийг чинь бол дэмжиж байна. Чин сэтгэлээсээ хэлсэн байгаасай гэж горьдож байна.

Ер нь Монголчууд бид нар цаашидаа хуваагдаж жижгэрч, талцаж хуваагдах биш, гаднын явуулгаар элдэв бусын хүмүүсээр бие биедээ хуваагдаж, талцаж бие биеэ доромжилдог энэ тогтолцооноосоо салж бид нар нэгдэж нийлж, Монгол Улсынхаа эрх ашгийн төлөө ажиллаж амьдрах ёстой шүү. Сонгууль болдгоороо болоод өнгөрнө. Түүнд нийцүүлж элдэв бусын зүйлээр бодлогын асуудлуудаа нэгдэж хамтрах

зүйлийгээ үгүйсгэж яримааргүй байгаа юм.

Ийм учраас энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг дэмжиж өгөхийг гишүүнээс ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Гишүүд танхимдаа байраа эзэлье. Гишүүд танхимдаа байраа эзэлье. Санал хураалт явагдана.

Уг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт.

Хэн, энэ миний төхөөрөмж сая ажилласангүй. Уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя, гишүүд ээ. Гишүүд байраа эзлээрэй. Санал хураалт. Гишүүд байраа эзэлье. Санал хураалт.

Санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт.

Мөнхцэцэг гишүүн горимын санал гаргая. Гишүүд анхааралтай.

Ц.Мөнхцэцэг: Саяын санал хураалт дээр миний төхөөрөмж гацсан учраас энэ санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэгийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Адьшаа горимын санал гаргая.

Гишүүд энэ төхөөрөмжөө, техникийнхэн бас анхаараарай.

Ш.Адьшаа: Миний төхөөрөмж санал хураалт дээр гагцхилаа. Дахин санал хураалт явуулж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Адьшаа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд яав, сууцгаагаарай. Гишүүд байраа эзэлье.

Адьшаа гишүүний гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд анхаараарай.

55,3 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Үндсэн саналын томъёоллын, санал хураалтын саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт гишүүд ээ, анхааралтай.

55,3 хувиар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлээ.

15.30 цаг

Дараагийнхаа асуудлыг хэлэлцье. Дараагийнхаа асуудлуудыг орно.

Хойшлуулсан санал хураалтуудыг нэгтгэж явуулна. Гишүүд байраа эзлээд байж байгаарай.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалтыг явуулъя.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байгаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй 1 санал байна. Үүнийг танилцуулъя.

Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал байна.

1. Төслийн 2 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“52.2. Бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр гэсэн ерөнхий хуваарийн дагуу ашиглана. Отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр, уст цэг, хужир мараа бүхий бэлчээрийг нийтээр ашиглана. Бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээрийн даацыг харгалзан, багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээний дагуу ашиглуулж болно.” Санал гаргасан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо. Санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүн Адьшаа горимын санал гаргаарай.

Ш.Адьшаа: Төхөөрөмж гагцсан тул дахиж санал хураалт явуулж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаагийн гаргасан горимын саналаар уг санал

хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

55,3 хувиар санал дэмжигдлээ.

Үндсэн саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт, үндсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт, гишүүд ээ.

Энэ дэмжигдсэнгүй. Хэн санал өгөөгүй юм бэ? Мөнхцэцэг гишүүн горимын санал гаргая.

Ц.Мөнхцэцэг: Сая санал хураалт дээр миний төхөөрөмж гацсан байна. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар горимын санал гаргая. Цогтбаатар саналаа өгч амжсангүй.

Д.Цогтбаатар: Дахин санал хураалт явуулах горимын санал гаргаж байна. Миний аппарат ажилласангүй, уучлаарай.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарын гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд саналаа өг.

52,6 хувиар санал дэмжигдлээ. Уг санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Үндсэн саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт, гишүүд ээ, гишүүд саналаа өгөөрэй.

Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьяа горимын санал гаргая. Гишүүд анхааралтай.

Ш.Адьяа: Миний төхөөрөмж гацлаа. Энэ Чинзориг болиорой, хэрүүл хийгээд байх юм.

Л.Мөнхбаатар: Адьяа гишүүний микрофоныг өгөөрэй. Болчихсон уу.

Адьяа гишүүний гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

52,6 хувиар Адьяа гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ.

Үндсэн саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

Хэн юм, Мөнхцэцэг гишүүн горимын санал гаргая.

Ц.Мөнхцэцэг: Саяын санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү. Санал хураалтаас би сая хоцорчихлоо.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэгийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох саналын санал хураалт явуулъя.

Мөнхцэцэг гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ.

Үндсэн саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

55,3 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

15.39 цаг

Дараагийнхаа асуудалд оръё.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан.

Энэ дээр зарчмын зөрөөтэй санал байгаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй санал байна. Санал хураалтыг явуулна.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн байна.

Төслийн 2 дугаар зүйлийн "... дүгээр сарын ...-ний" гэснийг "06 дугаар сарын 15-ны" гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд.

Гишүүд байраа эзлээрэй. Адьшаа гишүүн байрандаа очъё. Пүрэвдорж гишүүн асуудалдаа сууя. Нямаагийн Энхболд гишүүн суудалдаа сууя. Нямаагийн Энхболд гишүүн суудалдаа суугаарай.

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт.

57,9 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжжүүлээ.

Дараагийнхаа асуудлыг хэлэлцье.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт дэх санал хураалтыг явуулъя.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй санал байна. Үүнийг танилцуулъя.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын

зөрөөтэй саналын томъёоллыг танилцуулъя.

1. Төслийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"6.4.Энэ хуулийн 6.1-д заасан хөнөөлт организмтай тэмцэх, ариутгах, халдваргүйжүүлэх, устгах арга хэмжээний зааврыг ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батлан энэ хуулийн 26.1-д заасан мэдээллийн санд байршуулна." Санал гаргасан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, санал хураалт.

55,3 хувиар санал дэмжигдлээ. Зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжжүүлээ.

Дараагийнхаа асуудалд оръё.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийн санал хураалтыг явуулъя.

Байнгын хорооны саналаар Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрээт харуул, хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт

оруулах тухай, Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мөнгөн зээлийн ажиллагааг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль тогтоомжийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт гишүүд ээ.

52,6 хувиар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийнхаа асуултад оръё.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал хураалтыг явуулъя.

Байнгын хорооноос гаргасан горимын санал байна.

Энэ “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

55,3 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын санал дэмжигдсэн учраас уг асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ. Эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байнгын хороонд шилжүүлж байна. Нийгмийн бодлогын байнгын хороонд.

Дараагийнхаа асуудалд оръё. Шүүхийн асуудал байна.

“Шүүгчийн орон тоог батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Санал хураалтыг явуулъя.

Шүүгчийн орон тоог батлах тухай. Шүүгчийн энэ орон тооны асуудал чинь хууль батлагдчихсан шүү дээ, тийм ээ.

Тэгэхээр энэ тогтоолын төслийг хэлэлцэх боломжтой байгаад байгаа юм. Хууль зүйн хувьд.

“Шүүгчийн орон тоог батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураая. Гишүүд саналаа өгөөрэй.

55,3 хувиар дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт.

55,3 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Дараагийнхаа асуудалд оръё.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал хураалтыг явуулъя.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

52,6 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Хэлэлцүүлгүүд явагдчихсан. Зөвхөн санал хураалтууд явагдаж байгаа юм шүү. Хэлэлцүүлгүүд явагдаад гишүүд үг хэлээд, асуултаа асуучихсан. Зөвхөн санал хураалтууд явагдаж байгаа гэдгийг гишүүдэд хэлье.

Дараагийнхаа асуудалд оръё.

“Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал хураалтыг явуулъя.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Байнгын хорооны саналаар “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт.

55,3 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн горимын санал гаргая.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Би нэг горимын санал гаргая.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлэн байгаа хуулиудыг бол ингээд хэлэлцээд дуусгачихмаар байгаа юм. Батлахаас бусад асуудлуудыг нь.

Тийм учраас Засгийн газраас өргөн барьсан Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн эцсийн хэлэлцүүлгийг явуулаад, 1 санал хураалттай юм байна лээ. Санал хураалтыг нь шийдээд, тэгээд эцсийн хэлэлцүүлэг рүү шилжүүлчихвэл яасан юм бэ гэдэг ийм горимын саналыг гаргаж байгаа юм. Гишүүдийг дэмжиж өгөхийг хүсье.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Тогтохсүрэнгийн гаргасан горимын санал 53,8 хувиар санал дэмжигдлээ.

Асуудлаа хэлэлцье.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийе.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 сарын 18-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их хурал 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас зарчмын зөрөөтэй саналын томъёоллын 7 дугаар саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу холбогдох хууль тогтоомжид нийцүүлж, найруулан томъёолж, санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Тус Байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн бөгөөд хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн Допингийн эсрэг үндэсний байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүнийг хугацаатай сонгох асуудал нь олон улсын допингийн байгууллагын дүрэм журамд нийцүүлэх талаар асуулт асууж хариулт авсан болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрөөтэй саналыг хуулийн төсөлд тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулга, хуулийн төсөл болон зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэг хийсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрөөтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Мөнхцэцэг гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй 1 санал байгаа юм байна.

Үүнийг уншиж танилцуулъя.

Бат-Эрдэнэ сайдын хууль эцсийн хэлэлцүүлэг хийгдэж байна.

Биеийн тамир, спортын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёололыг танилцуулъя.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал байна.

1. Төслийн 13 дугаар зүйлийн “13.1.11” дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 13.1.6 дахь заалтын “санхүүгийн

дэмжлэгийг төсөвт тусган санхүүжүүлэх” гэснийг “олгосон санхүүжилтийг зарцуулах” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.1.7, 13.1.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.7.орон нутгийн төсвөөс өсвөр үе, оюутны шигшээ багт санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

13.1.10.нутаг дэвсгэрийн нэгжийн онцлогийг харгалзан спортын төрлийг хөгжүүлэх;” Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо.

Энэ нөгөөдөх чиглэл өгсний дагуу зассан юм байна шүү дээ, тийм ээ. Хуульд нийцүүлсэн юм байна. Санал хураалт гишүүд ээ.

51,3 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлээ.

Одоо Шүүхийн хуулиар санал хураалт явагдана.

Дараагийнхаа асуудлыг хэлэлцье.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалтыг явуулъя.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байгаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх

ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал байна.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт, 4 дэх заалтын 46.10 дахь хэсэг, мөн зүйлийн 6 дахь заалтыг тус тус хасаж, 2 дахь заалтын 32.2.4, 32.2.5 дахь заалтыг өөрчлөн найруулж 32.8 дахь хэсэг болгож, 4 дэх заалтын 46.9 дэх хэсэг, 5 дахь заалтын 71.1.31 дэх заалтыг тайлбар болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.8.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 32.2.1, 32.2.2-т зааснаас бусад тохиолдолд шүүгчийн сул орон тоо гарсан бол энэ хуулийн 34.9-д заасан нэр дэвшигчийг сонгон шалгаруулалтад тэнцсэн эрэмбийн дарааллыг баримтлан энэ хуулийн 35.1-д заасны дагуу өргөн мэдүүлнэ.”

“46.9. Шүүгч зэрэг дэвтэй байх бөгөөд шүүгчид зэрэг дэв олгох журмыг Улсын Их Хурал батална.”

“Тайлбар: -Энэ хуульд заасан “Шүүхийн цахим платформ” гэж шүүхийн үйл ажиллагаанд мэдээлэл цуглуулах, боловсруулах, хайх, илгээх, хүлээн авах, ашиглах болон түүний аюулгүй байдлыг хангах зорилго бүхий үндсэн программ хангамж, техник хангамж, мэдээллийн сан, бусад бүрэлдэхүүн системийг хэлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир, Амартүвшин, Мөнхбаатар, Оюунчимэг, Б.Энх-Амгалан. Цаашид “ажлын хэсэг” гэнэ. Санал хураалт гишүүд ээ. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Гишүүд байраа эзэлье. Санал хураалт явуулъя.

Гишүүд байраа эзэлье. Даваасүрэн гишүүн суудалдаа сууя. Сарангэрэл гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн, Тэмүүлэн гишүүн, Учрал гишүүн суудалдаа сууцаая. Тэнд бас гишүүд байгаад байх юм. Сүхбаатар гишүүн суудалдаа сууя. Пүрэвдорж гишүүн суудалдаа сууя. Н.Энхболд гишүүн бас суудалдаа сууя. Сүхээ гишүүн чинь бас багш байсан хүн. Очоод нэг лекц уншвал харин тэгээд ер нь бол нэг цагийн, цаг 40 минутын лекцтэй байх шүү.

Пүрэвдорж гишүүн суудалдаа сууя. Хууль зүйн байнгын хорооны гишүүн Пүрэвдорж суудалдаа сууя. Ерөөсөө дэгд заасныхаа дагуу яривал ерөөсөө огт таны микрофоныг таслахгүй байгаа шүү дээ. Өчигдөр хэлэлцэх асуудлаас өөр зүйл хэлсэн учраас микрофоныг нь хаасан болохоос биш, тийм. Ер нь бол энэ удаагийн парламентад бол хамгийн олон удаа үг хэлсэн гишүүн бол Пүрэвдорж гишүүн байгаа шүү дээ.

Санал хураалтыг явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт гишүүд ээ.

51,3 хувиар санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийн “давж заалдах, анхан шатны” гэснийг “Ерөнхий зөвлөлийн ажлын алба,” гэж өөрчилж, “72 дугаар зүйлийн 72.1.5 дахь заалт “шүүгчид” гэсний дараа “болон шүүхийн захиргааны ажилтанд” гэж,” гэснийг “72 дугаар зүйлийн 72.1.5 дахь заалтын “шүүгчид” гэснийг “шүүгч болон шүүхийн захиргааны ажилтанд” гэж,” гэж, “85 дугаар зүйлийн 85.6 дахь хэсгийн “орон тоог” гэсний дараа “, албан тушаалын цалингийн хэмжээг” гэж,” гэснийг “85 дугаар зүйлийн 85.6 дахь хэсгийн “орон тоог” гэснийг “орон тоо, албан тушаалын цалингийн хэмжээг” гэж,” гэж тус тус өөрчилж 4 дүгээр зүйлд шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

51,3 хувиар санал дэмжигдлээ.

Пүрэвдорж гишүүний үгэнд Тоогий дарга бас хамаагүй орж болохгүй шүү, яг.

3. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 12.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 12.1, 12.2 дахь хэсэг болгох:

“12.1.Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нээлттэй эсхүл хаалттай явуулах эсэх асуудлыг энэ хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ.

12.2.Шүүхийн үйл ажиллагааг дараах байдлаар олон нийтэд нээлттэй, ил тод явуулна.”. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Санал хураалт. Гишүүд байраа эзлээрэй.

Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг горимын санал гаргая.

М.Оюунчимэг: Сая дарга аа, би нөгөө ярилцлагад орчхоод яг нэг минут хоцорсон чинь санал хураалт явчихлаа. Дахин санал хураалт явуулж өгөхийг хүсэж байна. Саяынхыг хүчингүй болгоод. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

56,4 хувиар санал дэмжигдлээ. Уг санал хураалтыг хүчингүйд тооцоо.

Үндсэн саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

51,3 хувиар санал дэмжигдлээ.

4. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 12.1.2 дахь заалт, 12.2 дахь хэсэг, 12.10, 12.13, 12.14 дэх хэсгийг тус тус өөрчлөн найруулж, 12.11 дэх хэсгийг хасах.

“12.1.2.шүүх хуралдааныг нээлттэй явуулах, шүүхийн цахим хуудас, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсхүл олон нийтийн цахим сүлжээгээр энэ хууль болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайлсан хуульд заасны дагуу шууд дамжуулах,

Тухайлсан хууль гэнэ үү. Ийм томъёолол байгаа юм уу. Үүнийгээ хараарай.

шууд дамжуулах, эсхүл олон нийтэд дуудгүрсний бичлэгээр хүргэх;”

“12.2.Нээлттэй явуулсан шүүх хуралдааны шийдвэрийг хэргийн оролцогч нарт гардуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүхийн бусад шийдвэр, шүүгчийн захирамж, шүүх хуралдааны тэмдэглэлийг албажиж гарснаас нь хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 12.1.3-т заасан цахим мэдээллийн санд ил тод, нээлттэй байршуулна.”

“12.10.Төрийн нууцад хамаарах хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд хаалттай явуулахаар тусгайлан зааснаас бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хурал нээлттэй байна.”

Энэ томъёолол нь энэ яаж уншигдаад байгаа юм. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль. Ингэж томъёолж бичих юм уу. Энэ чинь өөр өөрийн хэрэг хянан шийдвэрлэх, үүнийг чинь нэгтгэсэн ийм хууль зүйн ийм томъёолол байх уу? Тус бүрдээ биз дээ? Тийм ээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай гэдэг юм уу? Ингээд нийтэд нь томъёолоод бичиж болж байгаа юм уу? Хууль зүйн байнгын хорооныхон.

“12.13.Энэ хуулийн 12.10-т заасан шийдвэрт гомдол, хүсэлт гаргах, гомдол, хүсэлтийг шийдвэрлэх журмыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайлсан хуулиар зохицуулна.

12.14. Шүүх энэ хуулийн 12.1.1, 12.1.2-т заасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэр, энэ хуулийн 12.1.3-т заасан цахим мэдээллийн санд төрөлжүүлэн архив, албан хэрэг хадгалалтын хугацааны турш, шүүх хуралдааны бичлэгийг Ерөнхий зөвлөлийн баталсан журамд заасан хугацаанд хадгална.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Санал дэмжигдсэнгүй. Санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд горимын санал гаргая.

Н.Энхболд: Уучлаарай. Би сая уг нь дарсан чинь энэ ажиллаагүй бололтой. Тэгээд санал хураалтыг хүчингүй болгоод дахиад санал хураалгаж өгөхийг хүсье.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболдын гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

55 хувиар санал дэмжигдлээ. Уг санал хураалтыг хүчингүйд тооцоо.

Үндсэн саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

57,5 хувиар санал дэмжигдлээ.

5. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 12.5 дахь хэсгийн “заавал байршуулна” гэснийг “байршуулахтай холбоотой журмыг Ерөнхий зөвлөл батална” гэж, 12.1.1 дэх заалтын “хуульд заасны дагуу сонирхогч этгээд биечлэн болон цахимаар” гэснийг “хууль болон хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааны тухайлсан хуульд заасны дагуу сонирхогч этгээд” гэж, 12.8 дахь хэсгийн “хэсэгчлэн хаахаас” гэснийг “зарим хэсгийг хаахаас” гэж тус тус өөрчилж, 12.3 дахь хэсгийн “биечлэн, эсхүл цахимаар” гэснийг, 12.16, 12.17 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

55 хувиар санал дэмжигдлээ.

6. Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 24.5 дахь хэсгийн “заавал” гэснийг, мөн зүйлийн 3 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

57,5 хувиар санал дэмжигдлээ.

7. Төслийн 4 дүгээр зүйлийн “48 дугаар” гэсний өмнө “32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалтын “32.2.2-т” гэснийг “32.2.2, 32.8-д” гэж нэмж, “19.2.3” гэсний дараа “дахь заалтын “Хүрээлэнд” гэснийг “Шүүхийн академид” гэж” гэж, мөн зүйлийн “Хүрээлэн” гэснийг “Шүүхийн академи” гэснийг “Хүрээлэнгийн” гэснийг Шүүхийн академийн” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

52,5 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал байна.

Төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

57,5 хувиар санал дэмжигдлээ.

Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал байна.

Адъяаа гишүүний санал байна.

1. Төслийн 5 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адъяаа. Санал хураалт.

16 гишүүн буюу 40 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Дараагийн хууль оръё.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг танилцуулъя.

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг үйлдэх, шийдвэр гаргах,” гэж нэмж, мөн зүйлийн 2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Санал хураалт гишүүд ээ, суугаарай. Гишүүд санал хураалт. Санал хураалт гишүүд ээ, санал хураалт гишүүд ээ, суугаарай. Гишүүд суу.

Уг санал дэмжигдсэнгүй.

Цогтбаатар Байнгын хорооны дарга аа. Саналуудыг чинь дэмжигдэхгүй, сая унасан. Цогтбаатар. Цогтбаатар дарга аа, 2 санал дэмжигдэх, үгүй ээ үгүй Цогтбаатар сайд аа. Сая горимын санал гаргах хүн байгаа юм уу? Энэ сая яачихлаа шүү дээ. Та өөрөө юм уу, саналаа өгсөн юм уу? Үгүй ээ, тийм тийм өөр санал шүү дээ, энэ чинь. Сая 2 дахь санал унаад байна шүү дээ. 2 дахь санал хураалт чинь унаад байна. Бүх санал хураалтууд чинь явахгүй

байгаад байна. Цогтбаатар сайд аа. Хэн горимын санал гаргах гэж байгаа юм? Та өөрөө өгөөгүй юм уу сая, өгөөгүй юм уу?

Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар горимын санал гаргая.

Д.Цогтбаатар: Энэ сая би дэмжсэн санал өгсөн боловч гарсангүй. Тийм учраас саналыг хүчингүй болгож, дахиж санал хураалт явуулах хүсэлт гаргаж байна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарын гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулж байгаа шүү.

52,5 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Саналын үндсэн томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. Гишүүд анхааралтай. Үндсэн санал хураалт явагдаж байгаа шүү. Саналаа өгөөрэй.

Санал дэмжигдсэнгүй.

Үгүй ээ, энэ хуулиа явуулчихмаар байгаа шүү дээ, та нар. Одоо яахгүй бол наад хууль чинь батлагдахгүй шүү. Эцэслэн батлах батлагдахгүй бол үлдэх нь байна шүү, энэ чуулганаар. Өнөөдөр явахгүй бол.

Ирцээ бүрдүүл. Цогтбаатар сайд аа, горимын санал гаргахгүй юм уу, сая.

Ганбат гишүүн горимын санал гаргая. Хууль зүйн байнгын хорооны гишүүн Ганбат гишүүн горимын санал гаргая. Микрофоныг нь өгөөрэй.

Д.Ганбат: Уучлаарай. Би уул нь дэмжсэн юм. Тэгсэн чинь минийх эсрэг гарчихсан байна. Энэ саналыг ахин хураалгаж өгнө үү, хүчингүй болгож өгнө үү.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбатын гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Саналыг хүчингүйд тооцох санал хураалт шүү.

51,3 хувиар санал дэмжигдлээ. Санал хүчингүйд тооцлоо.

Үндсэн санал хураалтыг явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан, санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Аубакир горимын санал гаргая.

Т.Аубакир: Би сая дэмжиж санал өгсөн чинь эсрэг гарчихдаг, энэ аппарат болохгүй байх шиг байна. Хүчингүй болгоод дахиад санал хураалт явуулж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Гишүүд, гишүүд анхааралтай байгаарай, суугаарай, байраа эзэлье.

Улсын Их Хурлын гишүүн Аубакир гишүүний гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

53,8 хувиар санал дэмжигдлээ.

Үндсэн санал хураалтаа явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

53,8 хувиар санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 11.11 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байж болно. Цаасан баримтыг шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын ажилтан хөрвүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулна.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

51,3 хувиар санал дэмжигдлээ.

3. Төслийн 2 дугаар зүйлийн “цахим хаягаар” гэснийг “цахимаар” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

53,8 хувиар санал дэмжигдлээ.

4. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3.2 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Төрийн нууцад хамаарах хэрэг, энэ хуульд тусгайлан зааснаас бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

2.Хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын ялагч, хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нээлттэй, эсхүл хаалттай явуулах эсэхийг шүүх шийднэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

53,8 хувиар санал дэмжигдлээ.

5. Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 34.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2 дахь хэсгийн “хаалттай” гэснийг “нээлттэй, эсхүл хаалттай” гэж өөрчлөх:

“1.Төрийн нууцад хамаарах хэрэг, энэ хуульд тусгайлан зааснаас бусад шүүх хуралдааныг нээлттэй явуулна.”

“2.1.хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын ялагч, хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны

шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс хүсэлт гаргасан бол.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал хураалт.

53,8 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 2 дахь заалтын 34.4 дүгээр зүйлд шилжүүлж 6 дахь хэсэг болгох:

“6. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасан албаны нууцыг задруулахгүй байх баталгааны зохицуулалт шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулахад хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

56,4 хувиар санал дэмжигдлээ.

7. Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал хураалт.

56,4 хувиар санал дэмжигдлээ.

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналууд байна.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 7.5, 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7.5, 7.6, 7.7 дахь хэсэг болгож, мөн зүйлийн 2, 5, 6, 7, 8 дахь заалт, 4 дэх заалтын 75^б дугаар зүйлийн 75^б.4.3, 75^б.4.4 дэх заалтыг тус тус хасах:

“7.5. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим

хэлбэртэй байж болох бөгөөд шүүхийн цахим платформын шаардлагад нийцсэн байна. Цахим баримт бичгийг шүүхийн захиргааны эрх бүхий ажилтан хөрвүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулна.

7.6. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шүүхийн мэдэгдэх хуудас, тэмдэглэл, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шийдвэр зэрэг баримт бичгийг цахимаар хөтлөх, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, хуульд заасан бусад этгээдэд танилцуулах, гардуулах, эрх, үүрэг тайлбарлах, нэхэмжлэл, хариу тайлбар, сөрөг нэхэмжлэл, бие даасан шаардлага, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлт, нотлох баримтыг танилцуулах ажиллагааг шүүхийн цахим платформыг ашиглан цахимаар явуулж болно.

7.7. Хэргийн оролцогчтой цахимаар харилцахад төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, мэдэгдэл хүргэх систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, мэдэгдэл хүргэх системд иргэний, эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар, өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шууданг ашиглана.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүн Чимэдийн Хүрэлбаатар горимын санал гаргая.

Ч.Хүрэлбаатар: Би уг нь сая дэмжиж санал өгсөн юм. Энэ хурууны хээ нь ерөөсөө уншигдахгүй байна. Сая яг энэ дээр бол уншсангүй. Тийм учраас, тийм учраас саяын саналыг дахиж санал гаргаж өгөх горимын санал гаргаж байна.

Л.Мөнхбаатар: Хүрэлбаатар сайд, гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

57,5 хувиар Хүрэлбаатар гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Үндсэн саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

53,8 хувиар санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Шүүх хуралдаан, хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааг нээлттэй явуулах

8.1. Төрийн нууцад хамаарах хэрэг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

8.2. Хэргийг шийдвэрлэж буй шүүгч, шүүх бүрэлдэхүүн дараах тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулахаар, эсхүл хэрэгт авагдсан нотлох баримтыг олон нийтэд мэдээлэхгүй талаар шийдвэр гаргаж болно.

8.2.1. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд насанд хүрээгүй гэрч, хохирогч оролцож байгаа бол шүүх өөрийн санаачилгаар;

8.2.2. нээлттэй ил тод байх нь хүний үндсэн эрхэд ноцтой хохирол учруулж болзошгүй талаар хэргийн оролцогчийн гаргасан хүсэлт тайлбарыг шүүх үндэслэлтэй гэж үзсэн;

8.2.3. цаашид үргэлжлэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ноцтой хохирол учруулах үндэслэлтэй гэж үзвэл.

8.3. Энэ хуулийн 8.2-т заасан шийдвэр нь шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол хэлбэртэй байна. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл хэргийн оролцогч гомдол, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, сонирхогч бусад этгээд хүсэлт гаргах эрхтэй.

8.4. Энэ хуулийн 8.2-т заасны дагуу шийдвэрлэсэн хэргийн үйл баримт, нотлох баримтын талаар олж мэдсэн хэргийн оролцогч, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, бусад этгээд уг үйл баримт, нотлох баримтын талаар олон нийтэд түгээх, хэвлэн нийтлэх, аливаа хэлбэрээр нийтэд дэлгэхийг хориглоно.”

8.5. Иргэний эрх зүйн чадамжгүй, согтуурсан, мансуурсан, 18 насанд хүрээгүй хэргийн оролцогч биш этгээдээс бусад хүн нээлттэй шүүх хуралдааныг хөндлөнгөөс ажиглах зорилгоор шүүх хуралдааны танхимд чөлөөтэй нэвтрэн орох эрхтэй. Шүүх хуралдаан хөндлөнгөөс ажиглагч этгээд нь шүүх хуралдаанд оролцох дэг, журмыг баримтална.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа үг хэлнэ. Асуулт бол байхгүй. Дэгээр дэмжсэн болон дэмжээгүй үг хэлж болно. Жаргалмаа гишүүний микрофоныг.

Б.Жаргалмаа: Ерөнхийдөө нөгөөдөх шүүх хуралдааныг олон нийтэд нээлттэй байлгах гэдэг асуудал бол олон жил яригдаж ерөнхийдөө шүүх хурал маань иргэдийн хяналтыг авах бүрэн боломж бас тавигдсан гэж үзэж болно. Тэгээд энэ хуулийн энэ иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр энэ 8.3 дахь заалт дээр ингэчихсэн байгаа байхгүй юу. Энэ хуулийн 8.2-т заасан шийдвэр нь шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол хэлбэртэй байна. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл хэргийн оролцогч гомдол

таслал, хэвлэл мэдээллийн байгууллага таслал, сэтгүүлч таслал сонирхогч бусад этгээд хүсэлт гаргах эрхтэй. Үүнийг нэг задлаад тайлбарлаад өгөх боломж байгаа болов уу? Одоо ер нь аливаа шүүх хуралдааны нээлттэй байлгаач ээ гэдэг хүсэлт маш ихээр явдаг. Гарамжав гишүүний ч гэсэн хэргийн асуудал дээр олон нийт мэдээлэл нэхэж байна. Өнөрөөгийн хэрэг дээр ч гэсэн олон нийт мэдээлэл нээлттэй байх эрхийг нэхэж байна. Тийм ээ, энэ дээр энэ нэг ойлгомжгүй өгүүлбэр байгаад байна л даа. Тэгээд энэ дээр би нэг олон нийтэд бас тайлбар өгөөч ээ л гэдэг хүсэлтээ тавих гэсэн юм. Ядаж өгүүлбэр юм уу найрлага юм уу, редакцын юм уу нэг алдаа байгаа юм шиг л харагдаад байх юм.

Л.Мөнхбаатар: Жаргалмаа гишүүн ээ, юу асуулт хариулт бол байхгүй, дэгээрээ. Энэ дээр нь Цогтбаатар Байнгын хорооны дарга яах юм уу, та үг хэлчих. Үг хэлэх байдлаар хэлэх юм уу. Шаардлагагүй юу.

Жаргалмаа гишүүн үг хэллээ.

Санал хураалт явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан.

51,3 хувиар санал дэмжигдлээ.

3. Төслийн 3 дугаар зүйлийн “нэрийг” гэснийг “гарчгийн” гэж, “өөрчлөн найруулсугай” гэснийг “өөрчилсүгэй” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

51,3 хувиар санал дэмжигдлээ.

4. Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

56,4 хувиар санал дэмжигдлээ.

5. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг төсөлд хэвээр үлдээх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж. Төсөлд хэвээр үлдээх гэсэн санал.

Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдоржийн гаргасан санал дэмжигдсэн байна.

51,3 хувиар дэмжигдлээ.

Дараагийнх.

- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 8.5 дахь хэсгийн “ажиллагаанд хөтлөгдөх” гэснийг “ажиллагааны” гэж, “байна” гэснийг “байж болно” гэж өөрчилж, мөн зүйлийн 2 дахь заалтын 10¹ дүгээр зүйлийн 10¹.1-10¹.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 10¹.1, 10¹.2 дахь хэсэг болгох:

“10¹.1.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхийн цахим платформыг ашиглан явуулж болох бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь шүүхийн цахим платформын шаардлагад нийцсэн байна.

10¹.2.Цаасан баримтыг шүүхийн захиргааны эрх бүхий ажилтан хөрвүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулна.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

56,4 хувиар санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 10¹ дүгээр зүйлийн 10¹.6 дахь хэсгийн “үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, тухайн этгээдийг таньж,

баталгаажуулах боломжтой бусад цахим систем” гэснийг “эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн үүсгэсэн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар,” гэж өөрчилж, 10¹.5, 10¹.7, 10¹.8 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Г.Занданиатар: 3. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 32.9, 32.10, 32.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 32.9 дэх хэсэг болгож, мөн зүйлийн 4, 5, 6 дахь заалтыг тус тус хасах:

“32.9.Шүүх цахим баримт бичгийг эргэлзээтэй гэж үзвэл энэ хуульд заасны дагуу шаардлагатай ажиллагаа хийнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

22 гишүүн дэмжиж, 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4. Төслийн 2 дугаар зүйлийн “57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн “гардуулна.” гэсний дараа “Цахим нэхэмжлэлийг хариуцагчид энэ хуулийн 10¹ дугаар зүйлийн 10¹.1-д заасны дагуу гардуулна.” гэж, 57.2 дахь хэсгийн “ирүүлнэ.” гэсний дараа “Цахимаар гаргасан хариу тайлбарыг тоон гарын үсгээр баталгаажуулна.” гэж, 71 дүгээр зүйлийн 71.2 дахь хэсгийн “үүрэгтэй” гэсний дараа “Цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд шүүхээс цахим системээр мэдэгдэл илгээснээр товыг мэдэгдсэнд тооцно” гэж,” гэснийг, “108.4 дэх хэсгийн “гардан авна.” гэсний дараа “Цахимаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг энэ хуулийн 10¹ дугаар зүйлийн 10¹.1-д заасны дагуу гардуулна” гэж,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1/“9 дүгээр зүйл:

“9 дүгээр зүйл.Шүүх хуралдаан, хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааг нээлттэй явуулах

9.1. Төрийн нууцад хамаарах хэрэг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

9.2. Хэргийг шийдвэрлэж буй шүүгч, шүүх бүрэлдэхүүн дараах тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулахаар, эсхүл хэрэгт авагдсан нотлох баримтыг олон нийтэд мэдээлэхгүй талаар шийдвэр гаргаж болно:

9.2.1. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд насанд хүрээгүй гэрч, хохирогч оролцож байгаа бол шүүх өөрийн санаачилгаар;

9.2.2. нээлттэй ил тод байх нь хүний үндсэн эрхэд ноцтой хохирол учруулж болзошгүй талаар хэргийн оролцогчийн гаргасан хүсэлт тайлбарыг шүүх үндэслэлтэй гэж үзсэн;

9.2.3. цаашид үргэлжлэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ноцтой хохирол учруулах үндэслэлтэй гэж үзвэл.

9.3. Энэ хуулийн 9.2-т заасан шийдвэр нь шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол хэлбэртэй байна. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл хэргийн оролцогч гомдол, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, сонирхогч бусад этгээд хүсэлт гаргах эрхтэй.

9.4. Энэ хуулийн 9.2-т заасны дагуу шийдвэрлэсэн хэргийн үйл баримт, нотлох баримтын талаар олж мэдсэн хэргийн оролцогч, хэвлэл мэдээллийн

байгууллага, сэтгүүлч, бусад этгээд уг үйл баримт, нотлох баримтын талаар олон нийтэд түгээх, хэвлэн нийтлэх, аливаа байдлаар нийтэд дэлгэхийг хориглоно.

9.5. Иргэний эрх зүйн чадамжгүй, согтуурсан, мансуурсан, 18 насанд хүрээгүй хэргийн оролцогч биш этгээдээс бусад хүн нээлттэй шүүх хуралдааныг хөндлөнгөөс ажиглах зорилгоор шүүх хуралдааны танхимд чөлөөтэй нэвтрэн орох эрхтэй. Шүүх хуралдаан хөндлөнгийн ажиглагч этгээд нь шүүх хуралдаанд оролцох дэг, журмыг баримтална.”

Шүүх хуралдаанд гэж энд аятайхан засвар хийх бол баримтална. Санал гаргасан ажлын хэсэг.

Чимэдийн Хүрэлбаатар гишүүнээр тасаллаа. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно.

Ч.Хүрэлбаатар: Би энэ шүүхийн хуультай холбоотойгоор нэг их санал хэлээд байдаггүй. Тэгээд өмнө нь нэг л санал гаргасан юм байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр Монгол Улсад явагдаж байгаа бүх шүүхийн шүүх хуралдааныг ил тод нээлттэй явуулчих гэдэг ийм л санал гаргасан. Тэр нь юу вэ гэхээрээ бид нар шүүгч нар бас өөрөө өөрсдийнхөө алдаан дээрээсээ суралцана. Тэр шүүх хурал ил явагдаж байгаа тохиолдолд үзэж байгаа, сонирхож байгаа хүмүүс нэлээд яг бодит амьдралыг хууль дээр хэрэглээд, хуулийг бодит амьдрал дээр яг хэрэглэж байгаа тохиолдлыг хүмүүс хараад тал талдаа сурах үйл явдал тэнд бас явагдана.

Тэгээд шүүх хурал ил тод болно оо гэдэг чинь өөрсдөө энэ шүүхийн олон асуудлууд хуульдаа ч алдаа байхыг үгүйсгэхгүй, хүндээ ч алдаа гаргахыг үгүйсгэхгүй. Энэ бүхэн бол цэгцлэгдэх ийм л учиртай. Өөрөөр хэлбэл шүүх болохгүй байна гээд л хүмүүс бол шүүмжилдэг. Яг нь болохгүй байгаад байгааг бүгдээрээ л мэдэхгүй байгаад байгаа шүү дээ.

Тийм учраас бүх шүүх хуралдааныг ил явуулъя гэдэг ийм л заалт гаргасан. Тэр уг нь дэмжигдээд явж байгаа. Саяхан нүүрсний хулгайн хэрэг хаалттай болсон байж байгаа. Уг нь энэ юун дээрээс болоод энэ хэрэг гарав, ямар хохирол Монгол Улсад учрав хэн хэн энэ дээр ямар ямар үүрэг рольтойгоор энэ нүүрсний хулгайн хэрэгт холбогдсон юм бэ гэдгийг олон нийт бол мэдэх л ёстой байсан. Гэтэл харамсалтай нь хулгайн хэрэг нууцаар явж байгаа.

Сая уншсан заалтыг сонсоход бол түүн дотор шүүх өөрөө мэдээд заримыг нь хаагаад явуулаад байх ийм боломжтой л юм унших шиг боллоо. Тэгээд би энэ дээр бол жоохон гайхаж байна. Хэн нэгэн хүнээс хамаарч үүнийг хаалттай, нээлттэй болгомооргүй байх юм. Үнэхээр хувь хүний нууцтай холбоотой асуудал бол тэр үгийг шүүх хуралдааны үеэр тэр хэсгийг нь дууг нь хаачихдаг байж болно шүү дээ. Хэн нэгэн хүнд эрхээ хэтрүүлж хэрэглэх ийм бололцоог бол энэ хуулиар гаргаж ирж өгч байна л гэж ойлгож байгаа, би.

Ер нь энэ шүүх хурлыг бүгдийг нь нээлттэй явуулдаг байх ёстой. Тэгж байж энэ Монгол Улсад олон зүйл цэгцэрнэ шүү, ер нь. Шударга ажилладаг шүүгчдийг нь Монголын ард түмэн мэдээд аваг. Хэн нэгэн хүнийг гүтгэж, хэлмэгдүүлж, асуудал яригдаж байгаа бол тэр хүн ч гэсэн нэрээ цэвэрлээд авах боломжийг нь гаргаад өгөх хэрэгтэй. 500 сая төгрөгөөр ч гэнэ, тэрбум төгрөгөөр ч гэнэ, хэн нэгэн хүн рүү гүтгэлэг элдэв болсон материалыг явуулчихдаг. Дараа нь тэр хүмүүс нэрээ цэвэрлэх ч боломж олдохгүй байх ийм эрсдэлүүд бол үүсэж байгаа шүү дээ. Цэвэр улс төрийн зорилгоор.

Тэгээд эцэст нь хаа хамаагүй хэн нэгэн хүнийг буруутгаад салдаг. Тэгэхээр энэ шүүх хуралдааныг ил тод явуулах нь энэ Монгол Улсад бугшаад байгаа олон асуудлуудыг илаарьшуулахад их чухал үүрэгтэй гэж би бол бодож байгаа.

Тийм учраас ямар нэгэн нөхцөл заадаг, хэн нэгэн хүнээс хамаарч хуралдааныг хаалттай явуулдаг, нууц явуулдаг, шийдвэрийг хаадаг, нуудаг ийм зүйлийг энэ дээр гаргамааргүй байх юм. Ер нь хэдүүлээ болохгүй байгаа асуудлаа ил тод, бүгдийг нь нээлттэй болгож байгаад үзье л дээ. Яагаад болохгүй гэж. Олон сонсгол явагдсан. Олон асуудлууд яригдаад буруу, зөв юм яригдаж байгаа ч гэсэн цаана нь буруу зүйлүүд нь олон нийтэд ил болоод, шийдэл нь гарч ирээд байгаа шүү дээ.

Тийм учраас энэ шүүх хуралдааныг аливаа нэгэн зүйл дээр нь хаадаг, нуудаг зүйлийг болимоор байгаа юм. Харин шүүх дээр тэр шат шатны хяналт шалгадаг байгууллагууд нь, прокурор нь, шүүх нь, прокурор нь, АТГ нь, цагдаа дээрх тэр тоног төхөөрөмжүүдийг нь хангалттай тавьж өгч шийдэж, үүнийг нь бүх олон нийтээр ил тод болгох хэрэгтэй. Тэр цахимаар нэлээд явуулах ёстой гэж түрүүн яригдаад байсан, тэр цахимыг шат шатанд нь цахимжуулах ёстой. Тэгээд эцсийн шүүх хуралдааныг бол олон нийтэд ил явуулах хэрэгтэй.

Тэгэхээр хэн нэгэн хүнээс хамаарч, ялангуяа шүүгчид өөрсдөө үүнийг хаадаг, тэд нарын үзэмжээр нээлттэй явуулах уу, хаалттай явуулах уу гэдгийг шийддэг бол байж боломгүй байна. Тэгэхээр үүнийгээ нэгмөсөн 1 мөр цэгцлээд явмаар байгаа юм. Дахиж ийм энэ шүүхийн хуулиа өөрчлөх боломж гарах ч билүү, үгүй ч билүү гэсэн ийм байр суурьтай байна.

Г.Занданшатар: Энэ хууль санаачлагчид, Цогтбаатар нарын гишүүд бид бол энэ шүүх засаглалд итгэх итгэл суларч байгаатай холбогдуулаад энэ ил тод байдлыг хангах, нэн ялангуяа саяын яригдаад байгаа нүүрсний болон бусад хэргүүд ил тод, нээлттэй, хэлэлцэгддэг байх зарчмаар хууль санаачилсан гол үндэслэл бол энэ шүүхийн нээлттэй ил тод байдлыг хангах зорилгоор энэ заалт санаачлагдаж орсон.

Тэгэхдээ энэ 9 дүгээр зүйлд бол насанд хүрээгүй хүүхэд, гэрч хохирогч оролцож байгаа бол шүүх өөрийн санаачилгаар гэсэн заалт нь бол тодорхой байна.

Нөгөөдөх нь хүний үндсэн эрхэд ноцтой хохирол учруулж болзошгүй талаар саналыг үндэслэлтэй гэж үзсэн бол гэдэг нь хянан шийдвэрлэх ажиллагаанд ноцтой хохирол учруулах үндэслэлтэй гэж үзээд энэ тодорхой биш заалтууд байгаа учраас энэ нь бол нь бас сүүлд нь тэр цонхоор бүгд хаалттай болчих вий гэсэн ийм болгоомжлолыг Хүрэлбаатар гишүүн хэлж байна.

Үүнийг тэгээд. Энэ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль явж байгаа. Зарчим нь эрүүгийн процесстойгоо адилхан хийсэн байна.

Ингээд санал хураалт явуулъя. Энэ тодорхойгүй заалтууд сүүлд нь нэг тийм цонх үүсгэх вий гэдэг болгоомжлолыг бол эцсийн хэлэлцүүлэг дээр анхаарч үзэх хэрэгтэй.

Санал хураалт явуулъя. Гишүүд суудалдаа сууя. Санал хураалт.

57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6. Төслийн 4 дүгээр зүйлийн “цахим шуудан” гэснийг “энэ хуулийн 59.12-т заасны дагуу гэж,” гэснийг хасаж, “шаардлагатай тохиолдолд” гэснийг “эсхүл” гэж тус тус” гэснийг “хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд” гэснийг “хүргүүлэх, эсхүл” гэж” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Адъяаа гишүүн. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Сая дэмжиж санал өгсөн, дэлгэцэн дээр эсрэг гарч байна. Саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгнө үү.

Г.Занданиатар: Адъяаа гишүүн мөн адилхан саналтай юм байна, тийм ээ.

Ингээд саяын гаргасан санал хураалтыг хүчингүйд тооцох горимын саналаар санал хураалт явуулъя.

57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ санал хураалт дэмжигдчихсэн учраас хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт.

Пүрэвдорж гишүүн, Адъяаа гишүүн саналаа.

55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7. Төслийн 5 дугаар зүйлийн “30 дугаар зүйлийн 30.4.4 дэх заалтын “байгууллага,” гэснийг,” гэснийг, “75 дугаар зүйлийн 75.2.6,” гэснийг тус тус хасаж, “50.4-т” гэсний өмнө “энэ хуулийн” гэж нэмж, мөн зүйлийн “, 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсгийн “байгууллагын нууц,” гэснийг 6 дугаар зүйлийн “хэсгийг” гэснийг “хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсгийг” гэж өөрчилж мөн зүйлд шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8. Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зургаа. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

- 5. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал.

Төслийн 1 дүгээр зүйлийн 15.36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нэг” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

55 хувийн саналаар санал хураалт.

- 6. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “ажиллагаанд хөтлөх” гэснийг “ажиллагааны” гэж, “байна” гэснийг “байж болно” гэж өөрчилж, 2 дахь заалтын 2.1 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 3 дахь хэсэг болгож, мөн зүйлийн 7 дахь хэсгийн “эрүүгийн” гэснийг “зөрчлийн” гэж, “хүргүүлнэ” гэснийг “хүргүүлж болно” гэж өөрчлөх:

“3. Хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхийн нэгдсэн цахим платформыг ашиглан явуулж болох бөгөөд хэргийн баримт бичиг, материал нь шүүхийн нэгдсэн цахим платформын шаардлагад

нийцсэн байна.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

55 хувиар саяын санал дэмжигдсэн.

Зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлнэ.

Энд үндсэн концепц зарчимтайгаа бас зөрчигдөөд нөгөө бангалорын зарчим гэдэг томилогдох этгээд нь томилсон этгээд нь сургалт дахин сургах асуудлыг хариуцдаггүй зарчим зөрчигдсэн санал энэ гишүүд ирц цөөтэй байх үед тэр Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал буюу төслийн 5 дугаар зүйлийг хасах Адышаа гишүүний санал босгож дэмжигдсэн. Үүнийг эцсийн хэлэлцүүлэг дээрээ Байнгын хороо анхаарах хэрэгтэй. Адышаа гишүүн ч гэсэн тэгж Байнгын хороо дээрээ ярилцъя гэж зөвшөөрсөн байгаа. Үүнийг ингэж чиглэл өгч байна.

Ингээд эцсийн хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ. Эцсийн хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ.

17.11 цаг

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууссан.

Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрөөтэй 78 санал байгаа.

Санал хураалт явуулна.

Ажлын хэсгийн гишүүдийг энэ хооронд танилцуулъя.

Сүхбаатарын Цогтгэрэл Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Дорждэрэмийн Цолмон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Хотын захирагчийн хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх, Мөнхөөгийн Батбаяр Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга.

Санал хураалт явуулна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

1. төслийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

3.1 Нийслэл, Улаанбаатар хот улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот тосгоны тухайлан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал, Энхтайваны Бат-Амгалан, Жигжидийн

Батжаргал, Баагаагийн Баттөмөр, Гонгорын Дамдинням, Тогмидын Доржханд, Цэндийн Мөнх-Оргил, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Ганзоригийн Тэмүүлэн. Цаашид “ажлын хэсэг” гэнэ.

Санал хураалт явуулъя.

Учрал гишүүн, Учрал гишүүн ээ, гишүүдээ дууд. Нийслэлийн гишүүдийг дуудъя. Оюунчимэг гишүүн ээ, Ардын намын бүлгийн дэд дарга. Яагаад гараад явцаачхав.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Би нэг санал хэлэх гэсэн юм дарга аа, горимын санал.

Тэгэхээр Нийслэлийн хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулиудыг санал хураах байсан боловч энэ Ардчилсан намын гишүүд гарч яваад, ирц бага байгаа учраас өнөөдөр санал хураах боломж маш бага байна. Санал хураах боломжгүй болчихлоо.

Тийм учраас маргааш өглөө 10 цагт шууд хамгийн эхэнд оруулж, энэ 2 хуулийг оруулна гэж тогтоод, одоо харин хэлэлцэх эсэхийг шийдэх гээд байгаа Засгийн газраас өргөн барьсан Орон сууцжуулах тухай хуулийн төслийг болон түүний дагасан өргөн барьсан хуулиудыг хэлэлцээд явбал яасан юм бэ гэдэг ийм горимын саналыг гаргаж байгаа юм.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14.2-т заасны дагуу энэ 2 хуулийн төслийг, санал хураалтыг хойшлуулахаар өглөө 10 цагт санал хураалт явуулахаар шийдвэрлэж байна.

Одоо нийслэлийн гишүүд ч гэсэн бас оролцооор байна. Нийслэлийн гуравхан

гишүүн байна шүү дээ. Жаргалмаа гишүүн, Цогтбаатар гишүүн, Оюунчимэг гишүүн, Сарангэрэл, Учрал гишүүн нар.

Маргааш тэр нийслэлийн гишүүдээ бүрэн оролцуулаарай.

17.22 цаг

Дараагийн асуудалд орёё.

Даваасүрэн гишүүн хаана байна.

Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Цэрэнпилийн Даваасүрэн танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл, алдагдлаас хамгаалах эрхтэй гэж, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4-д хүний аюулгүй байдал, Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн гэж, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 3.2-т өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн, өртөгтэй, эрэлт хэрэгцээнд нийцсэн байр сууриар хангах нөхцөлийг бүрдүүлнэ гэж тус тус заасан.

Энэхүү төрөөс баримталж буй бодлого, зорилтын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй сууцаар

хангах тогтолцоотой болох, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцын санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх, Үндэсний орон сууцын нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэ зохион байгуулалтаар өргөжүүлэн хэрэгжүүлэх, нийгмийн даатгал төлдөг, бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууцын худалдан авахад нь урьдчилгаа төлбөрт батлан даалт гаргах жилийн 3-6 хувийн хүүтэй орон сууцын хөнгөлөлттэй зээлд хамруулах зэрэг арга хэмжээнүүдийг үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Үндэсний баялгийн сангийн тухай хуульд Монгол Улсын иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцын зориулалтаар дэмжлэг үзүүлэх хуримтлалын санг уул уурхайн олборлолт, ашиглалт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцааны ноогдол ашигаас бүрдүүлэхээр заасны дагуу Үндэсний орон сууцжуулах тухай анхдагч хуулийн төслийг 6 бүлэг, 27 зүйлтэйгээр боловсрууллаа.

Уг хуулийн зорилго нь төрөөс орон сууцыг хөгжүүлэх, санхүүжүүлэх, Үндэсний орон сууцын корпорац орон сууцжуулах санг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, чиг үүргийг тогтоох, хөрөнгө бүрдүүлэх, зарцуулахтай холбоотой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хуримтлалын сангаар дамжуулан иргэдийг орон сууцжуулах гол бодлого нь энэхүү хууль байх бөгөөд иргэд орон сууцдаа эрүүл, аюулгүй орчинд амьдарч байвал өөрийнхөө болон гэр бүлийн ирээдүйгээ өөрчлөх, улс орон өөдлөн хөгжих суурь тавигдана.

Үндэсний орон сууцжуулалтын хууль батлагдан гарснаар төрөөс

баримталж буй бодлогын дагуу улс даяар бага, дунд орлоготой иргэдийг орон сууцжуулах хөдөлгөөн илүү ихээр өрнөх бөгөөд төрийн болон хувийн аж ахуйн нэгж, байгууллагуудаас нийлүүлж буй орон сууцын нийлүүлэлтийн өсөлтийг зах зээлийн зарчимд нийцүүлэн хадгалах, үр өгөөжтэй ашиглах, зорилтот бүлгийн иргэдийг орон сууцад хүртээмжтэй хамруулах тогтолцоог бий болгож, цаашид орон сууцын хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр Засгийн газарт үе шаттайгаар шилжүүлэн авч, Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээнд нийцүүлэн тогтвортойгоор үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болно.

Энэхүү хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Индэрт урьж байна. Оюунчимэг гишүүн индэрт урьж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь иргэдийн орон сууцын эрэлт, хэрэгцээг тодорхойлж, иргэдийн орлогын бүлэгт тохирсон орон сууцын төрлүүдийг бий болгох, тэдний төлбөрийн чадварт нийцсэн урт хугацааны түрээс, зээлийн бүтээгдэхүүнээр хангах, үндэсний орон сууцжуулах үйл ажиллагааны төрөл, түүнийг хэрэгжүүлэх, орон сууцжуулах санг байгуулах, түүний үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, чиг үүргийг

тогтоох, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төслийг Ди парламент.мн цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, санал хэлээгүй бөгөөд хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Цэрэнпилийн Даваасүрэн Барилга, хот байгуулалтын сайд, Цогтын Баярбат Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Эрдэнэбатын Батболд Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Пүрэвдоржийн Мөнхбаяр Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын Санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал, Баатар Эрдэнэбулган Төрийн орон сууцын корпорац ТӨХХК-ийн захирал, Чинзоригийн Маргад-Эрдэнэ Төрийн орон сууцын корпорац ТӨХХК-ийн Хөрөнгийн ашиглалт зохицуулалтын газрын дарга, Надмидцэдэнгийн Түвшинтөгс Нийслэлийн Орон сууцын корпорац ХК-ийн Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн Батсүхийн Одбаатар, Гэсэржавын Чинсанаа Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах шинжээч, Гандашийн Гантөр Барилга, хот байгуулалтын яамны Хуулийн хэлтсийн ахлах шинжээч, Батбаатарын Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын шинжээч, Амгалангийн Амартүвшин Нийслэлийн орон сууцын корпорац ХК-ийн Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, Пүрэвийн Гэрэлт-Очир Нийслэлийн орон сууц корпорацын ХК-ийн захиргааны хэлтсийн хуульч, Баасангийн Лхамсүрэн Алекс ХХК-ийн захирал, хуульч.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу?

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжих нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Бид сая Баялгийн сангийн хуулиа батлаад, баялгийнхаа өгөөжийн тодорхой хэсгийг хуримтлалын сандаа төвлөрүүлээд, түүнээс иргэдийнхээ боловсрол, эрүүл мэнд, орон сууцжуулалтын асуудалд зарцуулахаар шийд гаргасан. Засгийн газраас тодорхой хөрөнгө төвлөрсөн хөрөнгөөс нь тодорхой хэсгийг зээлийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх хэлбэрээр шийдэж, эх үүсвэр талынх нь асуудал шийдэгдэж байгаа юм байна гэж ингэж ойлгосон.

Тэгэхээр цаашид орон сууцын үнэ цэний асуудал байгаад байгаа юм. Энэ хуульд хэрхэн зохицуулж оров гэдэг асуудал байгаад байна. Томоохон төвлөрсөн газрууд дээр орон сууцын хорооллуудын газрын асуудал дэндүү үнэтэй. Дэд бүтцийнх нь асуудал дэндүү үнэтэй. Үүнээсээ хамаараад орон сууцын метр квадратын өөрийн өртгийг өндөржүүлээд, тэгээд иргэдийн орон сууцын өртөг өндөржөөд, тэр өртөгдсөн ачааллыг иргэд үүрээд байгаа нэг ийм л юм харагдаад байгаа л даа.

Тэгэхээр зэрэг тодорхой нөөц газруудыг орон сууцжуулах, хороолол байгуулах хэлбэрээр нь сонгож төрөөс дэд бүтцийнх нь асуудлыг шийдээд, тэгээд төсөл сонгон шалгаруулах хэлбэрээр орон сууцжуулалтынхаа асуудлыг явах юм бол энэ хөтөлбөрийг би нэлээн үр дүнтэй явах бололцоо бүрдэнэ, 1.

2 дугаарт, бас энэ орон сууцын өртөг үнэ тодорхой хэмжээнд баригдаад, худалдан авч байгаа иргэддээ бас өртгийн ачаа үүрэгдээд байх юм нь багасна гэсэн ийм л бодол байгаа юм, 1.

2 дахь зүйл. Бид үнэхээрийн төвлөрлийг задалъя, олон тулгууртай хөгжлийн төвүүдийг бий болгоё гэж ингэж л үзэж байгаа бол яах аргагүй шинэ хөгжлийн төв болох газрууддаа орон сууцжуулалтын асуудлыг нь шуурхайлж, ипотекийн зээлийн эх үүсвэрийг тэр тогтсон бүс нутгууддаа олгох арга хэмжээг л илүүтэй авах ёстой. Дан дамаа энэ Шинэ Зуунмодын хотын дэд бүтцийн ажил нэлээн эрчимтэй явагдаж байна. Үүнийг дагуулж энэ орон сууцжуулалтынх нь асуудлыг ямархуу байдлаар тодорхойлж харж байна вэ? Яг үүн шиг энэ Улаанбаатар хотын төвлөрлийг задлах, тодорхой шинэ төвүүд дээр бас эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л үйлчилгээнүүдийг нь төвлөрүүлээд, түүнийгээ дагасан орон сууцжуулалтынх нь ажлыг шийдэх чиглэлээр энэ хуульд ямархуу байдлаар тусаж оров гэдэг ийм зүйлүүд дээр би тодорхой хариулт авах хүсэлтэй байна.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн сайд хариулъя.

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүн маш чухал асуудал асуулаа. Энэ хууль гарч байгаа нэг зорилго бол энэ орлого багатай иргэдэд, тэдэнд зориулсан орон сууцын тогтолцоог бий болгох энэ асуудал орж ирж байгаа юм. Одоогийн ипотекийн зээлийн санхүүжилтээр дундаж орлоготой орлогын боломжтой иргэд хамардаг. Яагаад гэвэл тэр байшин барилгууд нь зах зээлийн үнэлгээтэй, таны хэлж байгаа нөгөө үнэ өндөр, газраа худалдаад авчихсан байдаг юм уу. Дэд бүтэцдээ үнэтэй хөрөнгө оруулалт хийчихсэн ийм барилгуудыг худалдаж авахад ипотекийн зээлээр явж байгаа. Судалгаанаас харахад дийлэнх нь ер нь орлогын боломжтой иргэд хамрагддаг юм байна.

Тэгэхээр энэ хуулийн гол чиглэж байгаа зорилго бол тэр орлого багатай иргэдэд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, залуу гэр бүл гэдэг юм уу энэ улсуудад чиглэсэн орон

сууцжуулалтын тогтолцоог бий болгож өгч байгаа.

Энэ хуулийн хүрээнд 3 орон сууцын төрлийг авч үзсэн байгаа.

1 дүгээрт, ипотекийн зээл. Энэ бол зах зээлийнхээ зарчмаар явна. Таны хэлээд байгаа шиг тэр нэг үнэтэй газар гэдэг юм уу ингээд орлого боломжтой иргэдийг хамруулсан энэ тогтолцоо нөгөө банкаараа хуучин системээрээ явна.

2-т, төрийн болон орон нутгийн өмчийн сууцыг хөлслөлгүй, түрээсийн орон сууцын тогтолцоог бий болгоно.

3-т, түрээслээд өмчлөх орон сууцын тогтолцоог бий болгоно.

Энэ 2 орон сууцын тогтолцоог Төрийн үндэсний орон сууцын корпорац гэж байгуулагдаад, тэр корпорац өөрийн захиалгаар таны хэлж байгаа шиг төрийн газар дээр ямар нэг худалдаж аваагүй газар дээр, мөн төрөөс санхүүжүүлсэн инженерийн дэд бүтэцтэй тэр газар дээр хамгийн хямд өртгөөр орон сууц баруулаад, иргэдэд түрээслэх, түрээслээд өмчлөх энэ хэлбэрийг бол бүрдүүлж орж ирж байгаа юм. Энэ хуулийн шинээр бий болгож байгаа орон сууцуудын төрөл бол энэ 2.

Тийм учраас цаашидаа манай орлогын боломж муутай, энэ ипотекийн зээлд хамрагдаж чадахгүй байгаа иргэд маань бол орон сууцжуулах, тэр орон сууцад хамрах энэ боломж бүрдэнэ.

Хөдөө орон нутаг руу мөн энэ орон сууцын тогтолцооны хэлбэрүүд бүгд явагдана. Төрийн Үндэсний орон сууцын корпорац хөдөө орон нутагт мөн орон нутгийн төрийн захиргааны байгууллагатайгаа хамтарч тодорхой газрыг эзэмшээд, тэр газар дээрээ инженерийн дэд бүтцийг нь хийгээд, мөн хямд орон сууц барих энэ ажлыг хийгээд явах юм. Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудтай хамтраад.

Тийм учраас бидний чиглэж байгаа юм бол орлого багатай иргэд, төрийн албан хаагч, хөдөө орон нутагт ажлын байрны хэрэгцээг нь хангасан тэднийг орон сууцжуулах, нийгмийн асуудлыг нь шийдэхэд чиглэсэн энэ арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгоор энэ хуудас ... /минут дуусав/

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Их баярлалаа. Хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Надад нэг 3 асуулт байна.

1 дүгээрт, бол Засгийн газраас Ерөнхий сайд шийдвэрлэсэн, оруулж ирээд Засгийн газрын хурлаар шийдвэрлүүлсэн энэ Баялгийн сангийн хууль батлагдсантай холбоотойгоор ипотекийн зээлийн эх үүсвэрт 1,2 их наяд төгрөгийг төвлөрүүлсэн. Энэ ажил маань хэр үр дүнтэй явж байна гэж. Энэ хүрээнд одоогийн байдлаар бол нэг 20-оод мянган иргэд ипотекийн зээлийн хүсэлт гаргачихсан ингээд хүлээлэгт байж байгаа. Эндээс бол арваад мянган иргэнийх нь асуудлыг бол богино хугацаанд шийдвэрлэхээр ингэж шийдэгдсэн. Тэгээд тэр нь бол хөдөө орон нутаг руу, энэ хөдөөгийн сэргэлтийн бодлогын төвлөрлийг сааруулах энэ бодлогын хүрээнд хэрэгжинэ ээ гэсэн. Энэ тал дээр нэг тодорхой нэг зүйл хэлээч ээ гэж.

Дараагийнх нь юм бол энэ барилгын үнэ ханшитай холбоотой ийм асуудал байгаа юм. Барилгын материалын үнийн асуудал. Яаж өртгийг бууруулах юм уу эсвэл ямар төлөв байдалтай байгаа юм. Одоогийн байдлаар бол харьцангуй дотоодын цементийн үйлдвэрүүд бол бололцоотой байгаа байх гэж ингэж ойлгож байгаа юм. Тэгээд яагаад гэвэл энэ Хөгжлийн банкны асуудал байна. Хөгжлийн банкны энэ хулгай луйврыг шалгах ажлын хэсэгт та бид нар хамт ажилласан. Тэгээд энд чинь 2 Хөтөлийн цементийн үйлдвэрийг энэ

Хөгжлийн банкны зээлээр хулгай хийгээд аваад явчихсан. Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр бас мөн ялгаа байхгүй ингээд аваад явчихсан. Энэ 2-ыг төрийн мэдэлд авчихсан. Ингээд хулгай луйвраар авчихсан энэ хулгайн хохирлыг барагдуулахтай холбоотой гэхэд л энэ 2 үйлдвэрээс Хөгжлийн банкны ажлын хэсэг байгуулж ингэж ажилласны үр дүн ч бараг 1 их наяд төгрөгийг хохирлыг эргэн төлөвлөсөн шүү дээ.

Тэгэхээр энэ барилгын нэг гол 2 материалын чинь гол нь цемент, нөгөөдхөд нь арматур байж байгаа шүү дээ. Тэгээд энэ Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийн энд арматурын үйлдвэрлэлийн байдал нөхцөл ямархуу байгаа юм бэ. Энэ талаар нэг зүйл хэлээч ээ гэж.

Дараагийнх нь юм бол энэ хөдөө, орон нутгийн орон сууцжуулахтай холбоотой юм нь та 3 төрлийн энэ хуулийн зохицуулалт бол бага орлоготой, нэн хэрэгцээ шаардлагатай байгаа тэр хэсэг рүүгээ чиглэсэн ийм арга хэмжээ авна гэж байна. Ингээд түрээсийн орон сууцтай холбоотой асуудал байна л даа.

Тэгэхээр түрээсийн орон сууцын хувьд энэ төрийн албан хаагчид, төрийн байгууллагууд, төрийн албан хаагчдыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулахад ямар чиглэл бодлого байх вэ? Тухайлах юм бол тэр энэ төрийн албан газрууд өөрийнхөө нэн хэрэгцээ шаардлагатай ийм ажиллагсдынхаа нэн хэрэгцээ шаардлагатай орон сууцаар хангах, төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах, амьдрах орчныг бүрдүүлэх чиглэлээр энэ хуульд ямар ахиц дэвшил гарах вэ гэж.

Бид бол хамгийн түрүүнд Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмээ баталж явсан. Тийм ээ. Шатны гишүүнийг дээрээс нь шүүрдэнэ.

Дараа нь бол Төрийн албаны ёс зүйн тухай хуулиа баталсан. Төрийн албан хаагчдаасаа ёс зүй, сахилга хариуцлага шаардахын зэрэгцээгээр

тэднийхээ амьдрах, ажиллах орчин нөхцөлийг нь, нийгмийн хамгаалал, баталгааг нь, цалин, бусад чиглэлээр баталгаатай байлгах ийм бодлого чиглэл байгаа. Би энэ хүрээндээ л энэ асуудлыг хариуцаад асуугаад байгаа юм л даа.

Батлан хамгаалах сайдаар ажиллаж байхдаа бид нар энэ анги байгууллагын яг дэргэд түрээсийн орон сууцыг байгуулсан байхгүй юу? Тэгээд томилолтоор очиж байгаа хүн албан конторынхоо түлхүүртэй, амьдрах байрныхаа түлхүүртэй, холбоо түлхүүртэй авдаг. Яг дараагийн ажил албандаа шилжихдээ тэр 2 түлхүүрээ хүлээлгэж өгдөг, 2 байраа өрөөгөө хүлээлгэж өгдөг ийм ... /минут дуусав/

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваацэрэн сайд хариулна.

Ц.Даваасүрэн: Тийм, Баялгийн сангийн хуулиар бид нар хуримтлалын сан байгуулах, энэ хуримтлалын санг иргэн бүр орон сууц худалдаж авах баталгаа гаргахдаа ашиглах ийм эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн. Энэ бол Сингапурт их түгээмэл байдаг тогтолцоо. Энэ жил гэхэд бол нэг 578 тэрбум төгрөгийг хуримтлалын санд иргэн бүрдээ ингэж хуваарилахаар байгаа. Энэ эх үүсвэрийг бас орон сууцжуулалтад ашиглана, ингээд ипотекийн зээлд ашиглана гээд ингээд үзэх юм бол нийтдээ нэг 1 их наяд гаруй төгрөгийг бол орон сууцын ипотекийн зээлийн санхүүжилтэд ашиглахаар ингэж төлөвлөсөн байгаа. Энэ талаар бас манай ажлын хэсгээс нэмээд мэдээлэл бас өгчхөөрэй.

Хөдөө орон нутагт ипотекийн зээлийн явц байдлыг харахад бол өнгөрсөн жилтэй харьцуулахад эхний улирлын байдал бол 25 хувиар өссөн дүнтэй байгаа. Тодорхой мэдээллийг бас манай ажлын хэсгээс өгнө.

Барилгын үнэ өртөг өсөхгүй байх тал дээр бол бид нар бас тодорхой арга хэмжээнүүд авч байна. Яагаад гэвэл энэ жил бас ипотекийн зээлийн эх үүсвэрийг

нэмэгдүүлсэн учраас нэлээн эрэлт хэрэгцээ өсөх байх. Бид ер нь импортын орц барилгын материалд бол 70 хувь байгаа. Тийм учраас энэ дээр нэлээн анхааралтай хандах ёстой, цаашидаа.

Цемент дээр бид нар импортын татварыг 5 хувь хүртэл бууруулсан. Ингэснээр бидний сүүлийн үед авч байгаа мэдээллээр импортын цементийн нийлүүлэлт бол нэлээн нэмэгдсэн байна.

Арматур дээр дотноос ихэвчлэн дотоодын зах зээлээс гадна, гаднаас импортлохоор ингэж зохицуулалт хийгдээд явж байгаа. Бид нар энэ бас орон сууцжуулалтын чиглэл дээр тэр таны яриад байгаа Хөгжлийн банкттай холбогдолтой зарим асуудлуудыг бол бас ойрын үед Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэхээр ажиллаж байна. Тухайлах юм бол Эрэлийн компанийн Хөгжлийн банкны зээлийн барьцаанд байгаа байшин үйлдвэрлэх компаниудыг бас зээлд нь суутгах. Мөн Бэрэнгийн Эрдэнэт хотод байгаа Металлургийн үйлдвэрийг бас өрөнд нь тооцох, тэгээд арматур үйлдвэрлэлийг нь шаардлагатай хөрөнгө оруулалтыг нь хийгээд ингээд арматур чиглэлээр ашиглахаар бас ойрын үед Засгийн газрын хуралдаанаар шийдвэр гаргахаар ингэж ажиллаж байгаа.

Түрээсийн орон сууцын хувьд бол хөдөө орон нутагт бас хэрэгжүүлнэ. Тэр хөдөөгийн хөдөө орон нутагт шилжиж байгаа залуу гэр бүлүүд, залуу төрийн албан хаагчид 8 айлын орон сууц барих ажил 100 тэрбум төгрөгийн хүрээнд бол энэ жил хийгдэнэ ээ гэж ингэж төлөвлөж байна. Бид нар зургийг нь бол хийгээд ингээд явж байна.

Сумдыг ойрын үед тодорхой болгоно. Ер нь хөдөө орон нутагт төрийн албан хаагчийг л тогтвор суурьшилтай байлгахад бол бас энэ түрээсийн орон сууц, энэ хямд орон сууцын тогтолцоог бол ашиглана гэж ингэж төлөвлөж байгаа.

Саяын тэр металлурги, хөдөө орон нутагт байгаа ипотекийн зээлийн мэдээлэл, цементийн мэдээллийг бас манай ажлын хэсэг нэмээд өгчихье.

Г.Занданшатар: 4. Ажлын хэсэг.

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Баярбат Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Эхний ээлжид ипотектэй холбоотой мэдээллийг танд өгье.

1 дүгээрт, ер нь ипотекийн зээлтэй холбоотойгоор энэ төвлөрлийг сааруулах, орон нутагт хөгжлийг бий болгохтой холбогдуулан 2 төрлийн зээл явж байгаа. 6 хувийн, 3 хувийн зээлүүд явж байна.

Өнөөдрийн 2024 оны 05 дугаар сарын 20-ны байдлаар бол нийтдээ арилжааны банкнууд дээр 20 мянган иргэний ипотекийн зээлийн хүсэлт хуримтлагдсан. Үүнтэй холбогдуулаад Засгийн газраас бас шийдвэр гаргаж, 500 тэрбумыг хуримтлалын сангаас энэ ипотекийн зээлд зарцуулж зориулж шилжүүлээд ингээд зарцуулаад явж байна. Үүнээс өнөөдрийн байдлаар бол нийтдээ 3 хувийн ипотекийн зээлийн хөтөлбөрт бол нийт 1740 иргэний 153 тэрбум төгрөгийн зээлийг бол шийдвэрлэсэн. Ийм байгаа.

Мөн түүнээс гадна 6 хувийн зээлийн хувьд бол 397,3 тэрбум төгрөгийн 3361 зээлдэгчид ипотекийн зээлийг олгосон. Үүнээс үндсэндээ 61 хувь нь бол нийслэл Улаанбаатар хотод, 38,1 хувь нь бол орон нутагт ингээж оногдож байгаа.

Түрээсийн орон сууц, түрээслээд өмчлөх орон сууц бол төрийн албан хаагчид руу чиглэсэн, бага орлоготой иргэд рүү чиглэсэн ийм орон сууцын төрөл хөтөлбөр байгаа. Энэ хөтөлбөрийн хүрээнд бол ер нь Төрийн орон сууцын корпорацын шугамаар орон нутагт нийтдээ 430 төрийн албан хаагч бол

түрээсийн орон сууцын хөтөлбөрт хамрагдаад явж байна.

Квотын хувьд бол Барилга, хот байгуулалтын сайдын 2017 онд баталсан тушаалаар бол нийт түрээс орон сууцын 25 хувийг нийслэлд, 30 хувийг бол орон нутагт ингээж зориулж олгож явж байгаа.

Дотоодын голлох 12 нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ одоогоор бол тогтвортой байна. Ковидын нөхцөл байдалтайгаар ... /минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Байнгын хорооны саналаар Үндэсний орон сууцжуулалт.

Бадарчийн Жаргалмаа гишүүн үг хэлнэ. Гараа өргөөд, гараа өргөөд байхаар чинь, ногоон дээлтэй хүн л гараа өргөөд байхаар нь.

Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх санал хураалтыг маргааш өглөө 10 цагаас явуулна.

Өнөөдрийн цаг дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ